

П.Одсүрэн, С.Энхбаяр, Д.Дэнсмаа

# УРАН ЗОХИОЛ

# XI

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн  
11 дүгээр ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны  
зөвшөөрлөөр хэвлэв.

Гурав дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.  
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот  
2019 он

ДАА 373  
ННА 74.2  
У-457

Уран зохиол XI: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 11 дүгээр ангийн сурах бичиг. /Одсүрэн П., ба бус; Ред. Норжинлхам.С., Тех.ред. Томтогтох.Г., -УБ.2017. - 72х

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь Монгол Улсын “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99978-61-32-0

## ГАРЧИГ

Сурах бичгийн агуулга.....4

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ДЭЛХИЙН СОНГОДОГ ТУУЛЬСЫН ЗОХИОЛ.....5

“Махабхарата” тууль.....6

“Игорийн хорооны үг” тууль.....12

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. ДЭЛХИЙН СОНГОДОГ ЯРУУ НАЙРАГ.....19

Галидас “Үүлэн зардас” найраглал.....20

Омар Хайям “Рубай” шүлгүүд.....23

Мацуо Башё “Хайку” шүлгүүд.....25

Франческо Петрарка “Сонет” шүлгүүд.....27

### ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХҮҮРНЭЛ ЗОХИОЛ.....31

Нарангэрэл дагины тууж.....32

Оноре дө Бальзак “Эцэг Горио” тууж.....41

Альфонс Доде “Сүүлчийн хичээл” өгүүллэг.....48

Антон Павлович Чехов “Хамелеон” өгүүллэг.....54

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ДЭЛХИЙН СОНГОДОГ ЖҮЖИГ.....63

Софокл “Эдип хаан” эмгэнэлт жүжиг.....64

Ном зүй.....72

## СУРАХ БИЧГИЙН АГУУЛГА

Эзэмших ерөнхий чадвар	Суралцахуйн зорилт	Бүлэг	Дэлхийн сонгодог туульсын зохиол	Дэлхийн сонгодог яруу найраг	Хүүрнэл зохиол	Дэлхийн сонгодог жүжиг
УНШИХ	Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар нийгэм, соёлын олон янз байдлыг ойлгох					
	Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлах					
	Дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлж, зохиолын утга санаанд нөлөөлж байгааг дүгнэх					
	Зохиолын гадаад, дотоод орчныг задлан шинжилж, дүр ба сэдвийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох					
	Яруу найргийн хэлбэр бүтцийг шинжлэх					
	Өгүүлэгдэхүүн ба зохиомжийн нэгжүүдийн уялдаа холбоог таньж, утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох					
БИЧИХ	Яруу найргийн хэлбэр, бүтцийг дуурайн, тодорхой сэдвийн хүрээнд санаагаа хөгжүүлэн, дүрслэн бичих					
	Зохиолын утга, бүтцийн онцлогийг шинжилж бичихдээ холбогдох нэр томъёог хэрэглэх					
СОНСОХ, ЯРИХ	Уншсан зохиолын хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн хэлэлцэх					

# 1

## ДЭЛХИЙН СОНГОДОГ ТУУЛЬСЫН ЗОХИОЛ

### НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН ЗОРИЛГО:

- Туульсын зохиолын онцлог, туульсын баатрын талаар мэдлэгтэй болно.
- Туульсын зохиолыг уншиж, задлан шинжлэх чадвартай болно.
- Уншсан зохиолын хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн хэлэлцэнэ.
- Туульсын зохиолын баатруудын эерэг, сөрөг зан чанарыг ялган, сайнаас суралцана.

## МАХАБХАРАТА (тууль)

Энэтхэгийн уран зохиол нь 4000 гаруй жилийн түүхтэй. 3000 жилийн тэртээ зохиогдсон энэ тууль 20 боть юм. Хэмжээгээрээ Библи судраас дөрөв дахин, Илиада, Одиссейг нийлүүлснээс долоо дахин том, дэлхийн хамгийн урт тууль.

“Маха” гэдэг нь их гэсэн утгатай үг. “Их Бхаратын удмынхны дайны тухай тууль” гэсэн нэр нь их гэсэн утгыг илэрхийлнэ. НТӨ 4 дүгээр зуунаас НТ-ын 4 дүгээр зууны хооронд бүтээгдсэн гэж үздэг. НТ-ын 5 дугаар зууны орчим эцсийн удаа боловсруулан бичигт тэмдэглэжээ. Вьяса гэдэг мэргэн арш зохиосон гэдэг домогтой. Гэхдээ үнэн хэрэгтээ олон хүний хамтын бүтээл гэж үздэг. 100 000 хос мөрт “шлок” буюу шүлгээс бүтдэг. Өөрөөр хэлбэл 200 000 мөр шүлэг гэсэн үг. Энэ туульсыг гурван удаа хайлсан тул гурван хувилбартай гэдэг. Хоёр дахь хувилбар нь 24000 хос мөртөөс, гурав дахь хувилбар нь 88000 хос мөрт шүлгээс бүтдэг. Монгол хэлэнд үргэлжилсэн үгээр найруулсан хувилбарыг нь товчлон орчуулсан байдаг. Махабхарата тууль нь 19 ботитой бөгөөд 1 мөр нь 16 авианаас бүтдэг байна. Хамгийн сүүлчийн ботийг хожим нэмсэн гэж үздэг. Энэ тууль нь том байдгийн нэг шалтгаан нь оруулга зохиол их байдагтай бас холбоотой.

Дөрөвний нэгийг л үндсэн агуулга нь гэж үздэг.



### УНШИХЫН ӨМНӨ

*Дэлхийн утга зохиолын сан хөмрөгт соёлт хүн төрөлхтний заавал уншиж, судалдаг цөөн хэдэн алдартай туульс байдаг. Үүнд:*

- Грекийн “Илиада”, “Одиссей”
- Арабын “Мянга нэгэн шөнийн үлгэр”
- Испаний “Сидийн дуулал”
- Германы “Нибелингүүдийн дуулал”
- Оросын “Игорийн хорооны үг”
- Хятадын “Тансан ламын үлгэр”
- Монголын “Гэсэр”, “Жангар”
- Энэтхэгийн “Махабхарата”, “Рамаяана”

*Эдгээр туульсаас алийг нь уншсан бэ? Зохиолуудын адил төстэй тал юунд оршино гэж ойлгодог вэ?*

### Товч агуулга:

“Махабхарата” тууль нь Энэтхэгийн их хаан Бхаратын удмын хаадуудын уг гарал, түүхэн амьдралаар эхэлнэ. Уг туульд маш олон дүрийн амьдрал, тэмцэл гарах бөгөөд захирагч Куругийн гэр бүл хэрхэн Каурынхан, Пандугийнхан хэмээх хоёр овог болж задарсан тухай өгүүлнэ. Энэ хоёр овог Дритараштра, түүний дүү Панду гэсэн хоёр ханхүүгээс үүсэлтэй аж. Ханхүү Дритараштра нь зуун хөвгүүнтэй. Хөвгүүдээс нь Дүрөдханагийн дүр тод дүрслэгддэг. Дритараштра сохор учраас хаан ширээнд суулгахаас татгалзсанаар гэр бүлийн энэ хагарал эхэлдэг. Түүний оронд Панду хаан ширээнд суух боловч хараал хүрсний улмаас үр хүүхэдтэй болж чаддаггүй аж. Гэхдээ бурхдын зарлигаар түүний эхнэр хөл хүндтэй болж, Юдхиштра, Бхимасен, Аржун, Нагула, Сахадев гэсэн таван

хүүтэй болжээ. Том хүү Юдхиштраг эрийн цээнд хүртэл сохор Дритараштра хаант засгийг удирдахаар болов. Тэд цэргийн эрдэмд суралцаж, сайн багшийн ачаар хүнлэг болж өсөцгөөжээ. Нэгэн удаагийн тэмцээнээр Пандугийн хөвгүүд мэргэн цэцнээрээ олныг гайхшируулж байсныг Дүрөдхана хараад атаархах сэтгэл нь өшөө хорсол болтлоо ассан байдаг. Энэ үед Юдхиштраг төрийн эрхийг залгамжлах хунтайжаар тунхаглах болсонтой холбоотойгоор Дүрөдхана тэнгэр тахих ёслол нэрээр Пандугийнхыг эхтэй нь хамт шатаах төлөвлөгөө гаргалаа. Аз болж урьтаж тэдэнд мэдэгдсэн учраас хонгилтой байшин барьж, оргон зайлж чаддаг байна. Сохор хаан Дритараштра, башир ханхүү Дүрөдхана нар өнгөн дээрээ уй гашуу боловч өрцөн дээрээ хөл хөөртэй байжээ.

Пандугийнхан оргон зайлнаас хойш ой ширэнгэд амьдран, мангастай тулалдан, эр зоригийнхоо хүчээр үзэсгэлэнт охинтой гэрлэн, зүсээ хувирган өглөг гуйн амьдарч, адал явдалтай учран, зовлонд унасан амьтан, хүн, таарсан хотынхоо иргэдийг элдэв аюулаас аварсаар нэр хүндийг олж авна. Шатсан гэж бодсон Дүрөдхана үүнийг мэдэн, хорсол нь улам буцалсан хэдий ч олон түмэн тэдний амьд гэдгийг мэдсэн учраас баяр ёслолтойгоор хотдоо авчирна. Дүрөдхана хаан болохын тулд эцгээ хүртэл ятгаж, элдэв бусармаг арга сэдэж тэднийг аль болох хөнөөх, нутгаасаа зайлуулахыг цаг ямагт хүснэ. Гэвч Пандугийнхан тэр байдлыг мэдсэн ч үл тоон, түүнийг өршөөн, Дүрөдханыг амь эрсдэхийн даваан дээр хүрсэн ч түүнийг аварч хайрлаж байдаг. Дүрөдхана ийм энэрэнгүй, уужуу сэтгэлтэй, сайн тулаанч баатар эрсийн байдалд улам атаархана. Юдхиштрад улсынхаа талыг өгсний дараа луйвраар л унагаах нь зөв гэсэн бодолдоо автан, хорон арга сэдэж, мөрийтэй тоглоом тоглоно. Мөрийд гэр орон, ард иргэд, хатнаа хүртэл алдсан Пандугийнхан шившигтэйгээр цөлөгдөнө. Цөлөгдсөн үед хүртэл Дүрөдхана элдэв туршуул явуулан, мөрдөж мөшгинө. Түүнээс хойш хэдэн жилийн дараа Пандугийн таван ах дүүс хаан ширээгээ эргүүлэн авахаар буцан ирснээр Курукшетрагийн цуврал дайнууд эхэлдэг. Пандугийн хөвгүүд цөллөгт явж ялаа дуусгасан учраас улсаа буцаан авахын тулд олон хүний амийг эрсдүүлэхгүйгээр, дайн хийхгүйгээр эвлэрэх хүсэлт гаргасан ч Дүрөдхана нэр төрөө бодон дайтахаар болно.

Пандугийн гурав дахь хөвгүүн Аржуна өөрийн дотно нөхөр Кришнаг сүйх тэрэгний хөтчөө болгон дайнд авч явдаг. Гэхдээ зөв үйлсийн төлөө дайтах нь таны үүрэг гэж Кришна өөрийг нь ятгасны дараа л Аржуна дуртай дургүй явна. Дайны талбар цусан далай болж, Дритараштра овгийнхны ихэнх нь үрэгдэн, цөөхөн хүн үлдсэн нь Пандугийн цэргүүдийг унтаж байхад нь хөнөөн өөрсдийн өшөөг авна. Энэ аллагаас ердөө ах дүү таван эр үлдсэн ч Дритараштрагийн хөвгүүдийг бүрэн дарж, газрын хөрснөөс арчина.

Юдхиштра эргэн хаан болсон ч, ялалт нь үр дүнгүй, учир утгагүй хэвээр үлдэж, дайны цаашдын хор хөнөөлийн аймшгийг дүрслэн үргэлжилнэ. Кришна буюу Вишну бурхны хувилгаан дүр санаандгүй хөнөөгдөж, Пандугийнхан диваажинг зорих урт, аюултай аяллаа эхэлнэ. Эцэст нь сүнслэг ертөнцөд ах дүүс эргэн нэгдэж, өөрсдийн үеэл Каурынхантай эвлэрнэ.

*Эх сурвалж: Хүүхдийн шилмэл зохиолын эрдэнэсийн сан 108. "Махабхарата (Куругийн хан хөвгүүдийн аугаа их тулалдаан)". "Соёмбо пресс" хэвлэлийн газар. Орч. Б.Баясгалан. УБ., 2017 он. (Товчлон авав.)*



Соёмбо Пресс УБ., 2017 он

Хүүхдүүдээ, дэлхийн алдартай энэ туульсыг бүрэн эхээр нь заавал уншин судлаарай. Эрх мэдлийн төлөө ах дүүс хэрхэн дайсан болсон түүх, Аржуна баатрын хүний төлөө гэсэн сайхан сэтгэл, өөрөө өөртөө үнэнч байх ухаан, багшаа хүндлэх ёс, хувь хүнийг таних ухаан, баатруудын хоорондох таатай болон таагүй харилцааны уур амьсгал, хүнд байнга өширхөж явдаг хүний амьдралын тавилан, уналт, бууралт зэргийг эндээс мэдэрч болно. Мөн тэвчээр, хүлээцтэй зан чанарын тухай, арга самбаагаараа элдэв аюулаас нөхдийгөө гэтэлгэж чаддаг Одиссей шиг баатрууд, бусдын амьд явах эрхийн төлөө өөрийнхөө хүүхдийг ч болов мангасын аманд өгч буй эх хүний зоримог үйл, шийдэмгий сэтгэл, юунд ч үл бэрхшээх эр зориг, хэлсэндээ хүрдэг эр хүн, хань нөхөртөө үнэнч гоо хатад, хийсэн үйл бүхэн нь сайн үйлс болдог Пандугийнхан, сорил болгоны өмнө хүн чанараа харуулдаг

дайчид, дайснаа хүртэл өршөөдөг энэрэнгүй сэтгэлийн тухай өгүүлсэн энэ зохиол нь санаанд оромгүй тохиолдол, зөрчлөөр дүүрэн, уншихад сонирхол татам домгийн үйл явдлуудтай юм. Бүрэн эхээр нь уншаад дараах даалгаврыг гүйцэтгээрэй.



### УНШИХ

**Нийгэм, соёлын хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлье.**

1. Уншсаны дараа ямар сэтгэгдэл төрөв? Энэ зохиол яагаад дэлхийн сонгодог бүтээл болсон бол?
2. Туульд нийгмийн ямар асуудлын талаар бичсэн байна вэ? Хаадуудын хоорондын тэмцлийг та нар юу гэж бодов?
3. Оюун болон эдийн соёлын талаар үзэл бодлоо илэрхийлээд, зохиолд хэрхэн илэрч байгааг жишээ татан ярина уу.

**Дэмжлэг болох асуулт:**



Бхарат хааны үр удам  
оюуны болон соёлын  
хувьд юу юу бүтээв?



#### 4. Зохиолын баатрын үзэл бодолтой харьцуулан, өөрийн үзэл бодлыг илэрхийлээрэй.

Ус мөрний савдаг Яакшагийн асуулт	Юдхиштрагийн хариулт	Та нарын хариулт
Хүний хамгийн сайн нөхөр юу байж болох вэ?	Тэсвэр тэвчээр	
Салхинаас ч хурдан зүйлийг нэрлэ.	Бодол санаа	
Хүний хамгийн муу нөхөр юу байж болох вэ?	Уур хилэн	
Хамгийн баян хүнийг нэрлэ.	Шуналаа гэсэн хүн	
Хүний амьдралын хамгийн гайхмаар зүйл юу вэ?	Одогсдоо чандарлах гэж явахдаа гэгээрсэн хутагтууд шиг байдаг ч оршуулгын дараа огтын өөрчлөлтгүй, нүгэлт хүн хэвээр байх нь хамгийн үл ойлгогдох зүйл.	


#### Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн уялдаа холбоог тодорхойлъё.

1. Зохиолоос та бүхэн юуг ойлгов? Ялангуяа Пандугийнхны зан чанараас юуг өөртөө тусган авав?
2. “Сохор хүн гэж нүд нь цийсэн хүнийг бус доторх ухаан нь цайсан хүнийг хэлдэг” гэж мэргэний хэлсэн үг аль дүрийн үзэл санаанд тохирч байна вэ?
3. Энэ зохиол дайныг эсэргүүцсэн утга санаатай билээ. Дритараштра хаан нэгэн мэргэн хүнээс “Үхэл гэж байдаг уу, байдаггүй юу?” гэж асуухад “Үхэл байдаг, бас байдаггүй. Аль аль нь зөв. Эгэл ертөнцийн элдэв таашаалыг эдэлж, эзэгнэхийн төлөө эцэс төгсгөлгүй шунан тэмүүлнэ гэдэг үхлийн өөр нэг дүр билээ. Тиймээс л дорд хүмүүс үхлийг энэ хорвоогийн хамгийн хүчирхэг зүйл гэж мунхаглацгаадаг. Гэвч бусдын нөлөөнд үл автах, үнэн мөнийг барих, өөрийгөө захирч сурах, төлөв төвшин, эгэл даруу аж төрөх зэрэг нь үхэл гээч зүйлийг үгүйсгэн тонилгох хүчирхэг зэвсэг юм” гэж хариулжээ. Энэ харилцан ярианд ямар хам сэдэв хөндөгдсөн байна вэ? Энэ ойлголтын талаар юу гэж бодож байна? Бүдүүвчийг ажиглаарай.





2. Үйл явдал нь газарт өрнөхөөс гадна тэнгэрийн орноос бурхад, арш нар, тэнгэрүүд бууж ирж, хүний үйл, хувь тавиланг бүтээж оролцдог. Зохиогчид нь яагаад ийм орчныг бүрдүүлж зохиосон юм бол? Та нар юу гэж бодож байна вэ?
3. Юдхиштрагийн ордныг хүний оюун ухаан, ур цэцээс хэтийдсэн зүйл байхаар барьж босгожээ. Дөрөвдүгээр бүлгийг уншаад, ордны орчныг ямар үг хэрэглэн зохиосныг судалж уншаарай. Энэ ордонд Дүрөдханы атаархуу сэтгэл хэрхэн хөдөлсөн бэ? Түүнийг шоглон ярилцаарай.
4. Дүрүүдийн хоорондох харилцааны сэтгэл зүйн уур амьсгалыг тодруулаарай. Тодруулахдаа бүдүүвчийн дагуу ажиллаарай.



## ИГОРИЙН ХОРООНЫ ҮГ (тууль)



## УНШИХЫН ӨМНӨ

- Эртний Энэтхэгийн “Махабхарата” туулиас юугаараа ялгаатай, юугаараа төстэй бол? Тунгаан бодож уншаарай.
- Эртний соёлт улс үндэстэн бүрт өөрсдийнх нь түүх, ёс заншил, сэтгэлгээ, амьдрал ахуйн өвөрмөц онцлог тэргүүтнийг нь нэвтэрхий тусгасан туульсын том хэмжээний бүтээл байдгийн нэг нь 10 дугаар зуунд зохиогдсон гэж үздэг, Оросын ард түмний гайхамшигт бүтээл болох “Игорийн хорооны үг” буюу “Игорийн цэрэглэсэн тууж” нэрээр алдаршсан тууль билээ. Энэхүү туульсын зохиолын үргэлжлэлийг та бүхэн “Монгол бичиг”-ийн хичээл дээр унших эх зохиолын хэсгээс үндэсний бичгээр уншиж танилцах боломжтой. Тэрчлэн энэ бүтээлийн үргэлжилсэн үгийн хувилбарыг нь манай нэрт эрдэмтэн зохиолч Х.Пэрлээ орчуулсныг уншиж харьцуулаарай.

**Товч агуулга:** Игорь ноён цэргээ дагуулан Половчуудтай дайтахаар явж байтал гэнэт нар хиртэв. Үүнд ихэд сэжиглэсэн боловч зорьсноосоо буцахгүй байхаар шийджээ. Удалгүй дүү Всеволод нь ирээд эргэлзэх хэрэггүй гэж зоригжуулсан тул тэд замдаа шуударчээ. Дон мөрөнд тэднийг Половчууд отож байгаад, үүрээр гэнэт довтолсныг Игорийн цэргүүд няцаан дарж, авсан олз нь үлэмж учраас ачиж барахгүй хаялж явав. Половчуудын дайралтад дахин өртөж нутгаасаа хол, дайсанд бүслэгдсэн орос цэргүүд эцсээ хүртэл тулалдан ялагдаж, Игорь дүүгийн хамт олзлогдов. Оросын олон ноёдод Игорийг аврахын төлөө уриалга түгнэ. Игорь үнэнч дагуулын хамт оргон гарч, нутагтаа ирснээр тууль төгсөнө.

**Эхлэл хэсгээс**

Хутаг – Алдар ноёны хүү  
Игорь вангийн гунигт туужийг  
Хууч үгээр эхэлж хэлбэл  
Таатай биш үү, дүү нар аа!  
Боян туульчийн сэтгэснээр  
Туужаа эхлэхийг байя.  
Бодит одоогийн явдлаар  
Туужаа анхалж өгүүлье!

Магтан хүнийг дуулах гэвэл  
Маш мэргэн Бояны сэтгэл нь  
Ой модон дээгүүр  
Оргилон түгээд  
Хөх бор бүргэд мэтээр  
Үүлэн доогуур нисээд  
Хөх боохолдой мэтээр  
Талд дүүлэн явдаг.  
Анхан цагийн дайн дажныг  
Ахин дахин Боян дурсдаг билээ.  
Ариун хунгийн сүрэг  
Арван шонхор  
Аль нэг гүйцэгдсэн нь

Аялан домог өгүүлж  
Эртний Догшин - Алдарыг  
Эрхэмлэн дурсан дуулж  
Хасаг цэргийн өмнө  
Хаан Редедийг хороосон  
Хүчит Өсөх – Алдарыг  
Хутаг – Алдар ноёны хүү  
Сайхан Роман ванг  
Сайшаан дуулдаг билээ.

Өнгөрсөн цагийн Боян  
Өнөр хунгийн сүрэгт  
Арван шонхор тавьдаггүй  
**Аялгуут хуурын чавхдасанд**  
**Уран хуруугаа хүргэмэгц**  
**Уянгат тэрхэн чавхдас нь**  
**Ван ноёдын алдрыг**  
**Бадруулан хангинуулдаг сан.**

Балар эрт цагийн байсан  
Ван Ертөнцийн эзнээс эхлэн  
Одоо цагт эрэлхгээр  
Орос нутгаа өмгөөлөгч

Идэрхэн өмөг цэргээ  
Кипчак газар хошуучлан  
Идтэй хавтай явдлаар  
Сэтгэл зүрхээ үзүүлэн  
Оюунаа бат хөгжөөж яваа  
Одоогийн Игорь ван хүртэлх  
Энэ цагийн туужаа  
Эхэлж хэлье, дүү нар аа!

**Тэр цагт Игорь ван  
Тэнгэрийн нарыг хяламхийхэд  
Бараан сүүдэр нарнаас бууж  
Баатар цэргийг бүрхсэнийг үзээд**  
“Олзлогдсоноос үхсэн нь дээр биш үү  
Өмөг цэрэг дүү нар минь  
Хөлөг хурдан мориндоо мордож  
Хөх Доныг үзүүлье” гэж  
Ноён вангийн сэтгэл нь  
Ноцтой хүсэлдээ автаж,  
Мундаг Доноос амсах хүсэл нь  
Муу ёронд торон тогтсонгүй  
Орос хөвгүүн та нартай  
Очих Кипчак газарт  
Барьсан жадаа хугачиж,  
Баатар толгойгоо өгнө.  
Үгүй бол Дон мөрнөөс  
Усыг нь дуулгаараа ууна” гэжээ!

Аль эртнээс цуутай  
Алтан гургалдай Боян минь  
Сэтгэлийн найлзуур модоор  
Сэлүүцэн дэвхцэн явж  
Огторгуйн үүлэн доогуур  
Оюун билгээр нисэж,  
Энэ цагийн хоёр хугасыг  
Эвлүүлэн зүйж, Алтан гургалдай минь  
Эдгээр баатар цэргийг  
Эгшиглэн магтаасай чи минь.

Трояны замаар хээрийг эмжин  
Толгод уулаар даван явж,  
Трояны ач Игорийн дууг  
Тохилон байж дуулсан нь:  
“Шонхор шувуудын  
Шороон шуургыг  
Агуу их талаар  
Авчирсангүй билээ.

Алагтууны сүрэг  
Арвин Дон өөд гүйнэ.  
Сула голын тэртээ  
Агт нь янцгаалдан  
Сүртэй их алдар нь  
Киевт хангинана.  
Бүрээ Шинэ – Балгадад татаж,  
Путивль хотод туг босгов” гэж

Бошигт Тэнгэрийн ач хүү  
Боян хэлж дуулуштай,  
Итгэлт ах Даян - Эзэнийд  
Игорь ван хүлээж байжээ.  
Догшин бух гөрөөс мэт  
Даян - Эзэн Игорь ванд:  
“Орь ганц дүү минь!  
Онц гэрэлт Игорь минь!  
Хоёул бид  
Хутаг - Алдарын хүү.  
Агтын хурднаа эмээллэ, дүү минь  
Ахын нь цэрэг бэлэн бий.  
Курийн өмнө эмээллээстэй бий.  
Кур хотын дайчид минь  
**Байлдааны бэлэн дуунаар  
Манцуйлуулж,  
Баатар дуулган доор  
Бүүвэйлүүлж,  
Жадны үзүүрээр угжуулсан,  
Жавхлант баатар эрс болсон юм.**  
Замаа тэд мэддэг юм.  
Жалгаа тэд таньдаг.  
Нум нь хөвчлөөстэй  
Сум нь зэхээстэй  
Сэлэм нь ирлээстэй.  
Нэр төр өөрсдөдөө эрж  
Нэр алдар ноёндoo хайж  
Хөх чоно мэтээр  
Хөдөө талд давхина гэжээ.  
Алтан дөрөөгөө Игорь ван дөрөөлж  
Ариун талаар аялан оджээ.

“Зулзаган шонхрыг  
Гуа охиноор аргамжвал,  
Зулзага охинтой  
Зугтаж алга болоод,  
Жигүүртэн биднийг  
Кипчакийн хөдөө талд

Жинтэй нанчих болно” гэж  
Хаан Гзак, Кончактаа  
Хариу хэлсэн байна.

Хуучин Догшин - Алдарын үеийн  
Хутаг - Алдарын дуу бүтээгч  
Ван Олегийн хайрлагч  
Билигт Боян, Ходына хоёр  
**Хүзүү байхгүй бол,  
Хүнд нүсэр биз биенд нь  
Игорь ван байхгүй бол,  
Ийм болно, Орос газар гэжээ.**

“Огторгуйг нар гийгүүлж байна,  
Оросыг Игорь гэрэлтүүлж байна” гэж  
Дунай мөрөн дээр  
Дуулсан охидын дуу нь  
Хөх тэнгисээр дамжиж  
Киев балгадад дуурсаж байна.  
Хутагт тэнгэр төрөгч  
Хурим гийчийн зүг  
Ван Игорь тань  
Боричевт явж байна.  
Олон гацаа баяртай

Орон хот цэнгэлтэй.  
Хуучин вангуудын дуулсан дууг  
Хожим залуу ванд зориулж  
дуулахдаа:

“Хутаг- Алдар вангийн  
Хувьтай хүү Игорь  
Догшин бух гөрөөс  
Даян - Эзэн ван,  
Игорь вангийн хөвүүн  
Ертөнцийн - Эзэн нарын  
Сайхан алдрыг нь  
Сайшаан магъя гэжээ.

Эзэн вантангууд  
Эрэлхэг өмөг цэргүүд  
Христосын шашны төлөө  
Хөнөөлтний цэргийг тэмцэн  
Эсэн мэнд эрүүл болтугай!  
Эзэн ван нарын  
Алдрыг магъя!  
Өмөг цэргүүдийн  
Өнөр гавьяаг магъя!  
Тийн болтугай!...

Эх сурвалж: “Өрнө дахины уран зохиолын дээж бичиг”  
1 дүгээр дэвтэр. Эмхэтгэсэн С.Хөвсгөл,  
С.Энхбаяр. УБ., 2010 он. 297-300 дугаар тал



## УНШИХ

**Нийгэм, соёлын хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлье.**

1. Туульс хэмээх төрөл зүйлийн талаарх үзэл бодлоо илэрхийлнэ үү.

**Дэмжлэг болох асуулт:**



- Хэний тухай огуулдэг вэ? Тол баатартаа хүний ямар ямар зан чанарыг шингээдэг вэ?
- Үйл явдал нь ямар байдаг вэ?
- Хэтрүүлэлт гурслэлтүү нь ичүүлгийн шинжийг илэрхийлж чадах уу?
- Эхлэхдээ бусад зохиолоос ялгаатай юу?

2. Энэ зохиолд гарч буй “Алтан гургалдай Боян минь” гэж ямар дүр вэ? Энэ дүрд хандаж буй өгүүлэгчийн дотнотлох хандлагыг тайлбарлана уу.

3. Орос орны нийгмийн байдлыг хэрхэн төсөөлж уншив? Уншиж байхдаа бодогдсон зүйлээ бусадтайгаа хуваалцаарай.

4. Эхлэл хэсгээс Игорь вангийн тухай юу мэдрэв? Тэр зоригтой юу? Түүний тухай хүмүүс юу хэлэв? Түүнд сул тал байна уу?

**Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн уялдаа холбоог тодорхойлъя.**

1. “Игорийн хорооны үг” зохиолын үндсэн агуулга, утга санаа, дэвшүүлсэн асуудал зэргийг Монгол ардын баатарлаг тууль “Гэсэр”, “Жангар” болон Энэтхэгийн их туульсын зохиол “Махабхарата”-тай харьцуулж, утгын хувьд адил төсөөтэй тал болон ялгаатай байдлыг хэлэлцэнэ үү.

	Гэсэр	Жангар	Махабхарата	Игорийн хорооны үг
Гол баатар нь юуны төлөө тэмцэж байна вэ?				
Гол баатар нь бусад дүрээс юугаараа онцлог байна вэ?				
Дайныг эсэргүүцсэн утгатай зохиол аль нь вэ?				
Шашны утга шингэсэн агуулгатай юу?				
Нийгмийн амьдралыг тусгасан уу?				
Хүмүүсийн амьдрал ахуй, соёлын талаар хэр зэрэг тусгасан бэ?				

2. “Огторгуйг нар гийгүүлж байна, Оросыг Игорь гэрэлтүүлж байна” хэмээх хоёр шатад илрэх утга санааг тайлбарлана уу. Игорийн ямар зан байдлыг юутай адилтгасан бэ? Ингэснээр зохиолч юу хэлэхийг хүссэн бэ?

**Зохиолын далд утгыг тайлан тайлбарлая.**

1. “Зулзаган шонхрыг  
 Гуа охиноор аргамжвал  
 Зулзага охинтой  
 Зугтаж алга болоод  
 Жигүүртэн биднийг  
 Кипчакийн хөдөө талд  
 Жинтэй нанчих болно” гэж  
 Хаан Гзак, Кончактаа  
 Хариу хэлсэн байна” гэсэн хэсэгт шонхроор хэнийг далд утгаар хэлсэн бэ?  
 Яагаад ингэж бичив?

**Дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлъя. Зохиолын утга санаанд нөлөөлж байгааг дүгнэе.**

1. Үндэсний монгол бичгээр бичсэн эхийг уншаад, Игорь вангийн бусдаас онцгой, дахин давтагдашгүй зан чанарын талаар ярилцаарай.
2. Бусад орны туульсын зохиолын баатруудтай харьцуулаарай.

	Нийтлэг эерэг тал	Нийтлэг сул тал	Бодгаль буюу өөрийн давтагдашгүй зан чанар
Гэсэр			
Жангар			
Одиссей			
Махабхарата туулийн Аржуна			

**Зохиолын хэл, уран дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөллийг үнэлье.**

1. Эхлэл хэсэгт тодруулсан хэсгийг ажиглаарай. Бусад мөр шадаас юугаараа ялгаатай байна вэ?
2. Тодруулсан хэсэгт юуг яаж хэтрүүлсэн байна вэ? Хэрхэн тайлбарласныг ажиглаарай.

Бодит амьдралд байдаггүй ямар хэсэг байна вэ?	Юуг хэтрүүлж бичсэн бэ?	Ямар зорилгоор хэтрүүлсэн бэ?	Хэтрүүлж сонгосон үгс нь уншигчдад хэр нөлөөтэй болсон бэ?
Жишээ тайлбар ...Тэр цагт Игорь ван Тэнгэрийн нарыг хяламхийхэд Бараан сүүдэр нарнаас бууж Баатар цэргийг бүрхсэн...	Игорь вангийн хүч чадлыг	Байгалийн хүчийг хүртэл өөртөө ашиглаж чаддаг машинд хүчтэй баатар гэдгийг гаргах зорилгоор хэтрүүлжээ. Мөн цэргүүдээ ангаж цангаж байгаа гэж боддог, бусдын төлөө сэтгэлтэй удирдагчийн тухай хэлэхийг хүсэж ийнхүү бичжээ.	Хяламхийх гэдэг үг хүчтэй сэтгэгдэл төрүүлж байна. Учир нь “харахаар юм уу ширтэхээр” гэж бичсэн бол уншигчдын сэтгэлийг тэр бүр хөдөлгөхгүй байх гэж бодож байна.
Бие даан ажиллана уу.	..... .....		

3. Игорь вангийн хүч чадал, эрдэм ухааныг адилтгасан мөрийг зохиолоос олоорой. Ямар зорилгоор юутай адилтгасан байна вэ?
4. Баатар эрсийн дайн, тулаанд бэлэн байдаг гэдгийг илэрхийлэхдээ ямар үгийг сонгон хэрэглэсэн байна вэ?
5. “...Байлдааны бэлэн дуунаар  
Манцуйлуулж,  
Баатар дуулган доор  
Бүүвэйлүүлж,  
Жадны үзүүрээр угжуулсан,  
Жавхлант баатар эрс...” хэмээх дүрслэлүүдийг өнөө цагийн хүүхдүүд юм уу эсвэл өнөөгийн хүмүүст хамаатуулж хэрэглэж болох уу? Болох, эс болохыг тайлбарлана уу.





**СОНСОХ-ЯРИХ**



**Уншсан зохиолын хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн хэлэлцье.**

1. Уншсан хоёр туулиас сонгоорой.
2. Эх зохиолыг бүрэн эхээр нь уншаад хэлэлцэхэд бэлдээрэй.
3. Хаад, эрх мэдэлтнүүдийн хоорондох зөрчлийг туулиудад хэрхэн гаргасныг эргэцүүлж уншаарай.

**Дэмжлэг болох асуулт:**

- ?
- Хаад, эрх мэдэлтнүүд юунаас болж зөрчилдөж байна вэ?
  - Хаад ёс зүйн харилцааны зөрчилд орсон уу?
  - Өнөө цагийн эрх мэдэлтнүүдийн зөрчил, харилцааг юу гэж бодож байгаагаа илэрхийлээрэй.

**4. Хэлэлцэхдээ:**



Бусдын үзэл бодлыг хүндэтгэн, анхааралтай, хүлээцтэй, идэвхтэй сонсоорой.

**5. Хэлэлцэх чадвараа дараах шалгуураар дүгнээрэй.**

	Маш сайн	Хангалттай	Дахин сайжруулах шаардлагатай гэж бодож байна.
Хэлэлцсэн асуудлын хүрээнд үзэл бодлоо илэрхийлсэн үү?			
Үзэл бодлоо баримт, жишээгээр баталж ярьсан уу?			
Бусдын үзэл бодлыг хүндэтгэн сонссон уу?			
Нийгэмд эерэг зөв харилцааг бий болгох асуудалд саналаа нэмэрлэсэн үү?			

ХЭРХЭН СУРАЛЦСАНАА ҮНЭЛЬЕ.

Мэдлэгээ үнэлье.

1. Уран зохиолын ямар төрлийг тууль гэдэг вэ? Зөвийг сонгоно уу.
  - Баатарлаг үйл явдалтай, аман зохиолын төрөл зүйл.
  - Баатарлаг үйл явдалтай, бичгийн уран зохиолын төрөл зүйл.
  - Адал явдалтай, амаар дамжиж ирсэн зохиол.
2. Туулийн баатрын шинжийг тодруулан тоочно уу. Дасгалыг гүйцээгээрэй.
  - Эр зоригтой
  - Энэрэнгүй сэтгэлтэй
  - Дайныг.....
  - .....
  - ..... ГЭХ МЭТ
3. Кур хотын дайчдыг юунд бүүвэйлүүлсэн гэж бичсэн бэ? Зөвийг сонгоно уу.
  - Байлдааны бэлэн дуунд
  - Цэргийн хувцсанд
  - Баатар дуулган доор
  - Жадны үзүүрт
4. “Игорийн хорооны үг” туульд гол баатрын эр зоригийг дүрслэхдээ ямар дүрслэх хэрэглүүрийг хэрэглэсэн бэ?

Адилтгал  
Хэтрүүлэл

Ёгтлол  
Ихэсгэл

Бэлгэдэл  
Багасгал

Чадвар, хандлагаа үнэлье.

1. Эх зохиолуудыг бүрэн эхээр нь уншсан уу?
2. Үзэл бодлоо илэрхийлэхдээ уншсан зүйлээсээ үндэслэлээ авч сурсан уу?
3. Зохиолын утгыг, дүрийн зан чанарыг мэдэрч ойлгож уншиж сурсан уу?
4. Туульсын зохиолын дүрслэлийн гол онцлог нь хэтрүүлж дүрсэлдэг гэдэгтэй санал нэг байна уу? Жишээгээр саналаа илэрхийлнэ үү.
5. Зохиолуудыг уншихдаа бэрхшээж байсан уу?
6. Туульсын дүрүүдээс юу суралцав? Тоочин бичнэ үү.
  - а.....
  - б.....
7. Ярих чадварын ерөнхий шаардлагыг судалж, өөрийгөө үнэлээрэй.

Бусдын анхаарлыг таттал,  
сонирхолтой илтгэн ярих

Тод, чанга, цэгцтэй,  
ойлгомжтой, өөртөө  
итгэлтэй ярих

Үгийг зөв сонгож ярих,  
бусдыг хүндэтгэн соёлтой үг  
хэрэглэх

Ярих чадвар

Бусдын яриаг ойлгож  
сонсох, дэмжих,  
асуулт асуух, санал  
хэлэх

8. Ярих чадвараа хэрхэн сайжруулах вэ? Саналаа бичээрэй.
  - а. ....
  - б. ....
  - в. ....
  - г. ....ГЭХ МЭТ

# 2

## ДЭЛХИЙН СОНГОДОГ ЯРУУ НАЙРАГ

### ХОЁРДУГААР БҮЛГИЙН ЗОРИЛГО:

- Дэлхийн сонгодог яруу найргийн дотоод төрөл зүйлийн талаарх мэдлэгтэй болно.
- Яруу найргийг уншин, задлан шинжлэх чадвартай болно.
- Өрнө, дорнын яруу найргийн хэлбэр, бүтцийг дуурайн, тодорхой сэдвийн хүрээнд санаагаа хөгжүүлэн, дүрсэлж бичиж туршина.
- Яруу найргийн үг хэллэг, дүрслэлээр дамжуулж, гоо сайхныг мэдрэн, сэтгэл хөдлөлөө илэрхийлж сурна.

**ГАЛИДАС**

(Нийтийн тооллын 4-5 дугаар зууны орчим)

Галидасыг дэлхийн соёлт хүн төрөлхтөн сайн мэддэг. Харин түүний намтар их бүдэг.

Энэтхэгийн эрдэмтэд Галидасыг нийтийн тооллын өмнөх 2-1 дүгээр зууны үед амьдарч байсан гэж үздэг. Зарим нь нийтийн тооллын 6 дугаар зууны үеийн хүн гэдэг. Түүнийг нийтийн тооллын 4-5 дугаар зууны үед амьдарч, бүтээж туурвиж байсан гэх нь илүү их үндэслэлтэй юм.

Галидас эгэл жирийн малчин байгаад хожим нь эрдэм номд хичээнгүйлэн шамдаж, хэтэрхий мэргэн болсон хэмээн үлгэр домогт хэлэлцдэг. Түүний “Шакундалааг таних тэмдэг”, “Маалвия Агнимидра хоёр”, “Зоригоор авсан Урваший” зэрэг жүжиг нь их алдаршжээ.

**УНШИХЫН ӨМНӨ**

1. “Үүлэн зардас” гэж юу гэсэн утгатай бол? Таамаглаарай.
2. Зохиолоо уншсаны дараа өөрийн таамгийг эргэцүүлээрэй.

**ҮҮЛЭН ЗАРДАС (найраглал)**

**Эхлэл:** Сэрэмж алдсан нэгэн ягшас, хилэнт эзний бошго зарлигаар  
Сүр жавхлангаа бууруулан, үзэсгэлэнт амрагаасаа жилээр хагацаад  
Сэтгэлд тааламжит гүнжийн угаалд ариудсан мөрний ойр  
Сүүдэр төгөлдөр галбарварас модот Рамын уулнаа суун авай.

**Зангилаа:** Амраг хонгороосоо олон сар хагацан уйдаж суусаар турж  
Алтан бугуйвч царвуунд тогтохгүй, Бүрвасад сар төгсөх өдөр  
Агуу заан, соёогоор уул мөргөн наадах мэт бөхийсөн  
Алсын үүл, уулын оргилд налан наалдсаныг ажин үзвэй.

**Өрнөл:** Энэлгэтнийг тэтгэгч үүлэн чи, хайртад минь мэдээ хүргээч  
Эзэн Гүвираагийн зарлигаар хагацсан намайг энд гэж хэлээч,  
Ягшасын эзний Алага балгасанд очиж, цэцэрлэгийн дунд  
Шива тэнгэрийн магнайн саран туяанд гийгч орд харшид

Чиний явах сайн замыг, үүл чамдаа зааж өгье би  
Чихэнд шингээж захих үгээ дараагаар нь хэлж өгье  
Алжаан ядрах цагт уулсын оргил түшин амсхийгээрэй  
Ангах цангах цагт нуур голоос ундлан шамдаарай.

Сэгхийгээд чанагш одохдоо, ойн голын эргийн гүнд цэцгийг  
Сэрүүн дуслаараа сэргээгээд, цэцэг түүгч сайхан охидыг  
Сэрвэгэнэн савирах хөлсөө арчсаар чихний линхув чилснийг  
Сэрүүцүүлэн хоромхон ч гэсэн амрааж өгөөрэй.

Янаг минь, чилгэр залуу, шүд хурц, уруул бямба улаан,  
Бэлхүүс нарийн, хүйс гүн, гуя зузаан, алхам алгуур,  
Хөх том, нүд нь цочсон янзаганы нүд мэт хөөрхөн,  
Эсрэн тэнгэрийн заяасан гоо хатагтайн манлай билээ.

Удалгүй чи түүнийг харамз. Эсвэл залбирч суугаа,  
Эсвэл, хагацан турсан намайг цээжээр зурж байгаа байх,  
Эсвэл тор дахь шрига бялзуухайн жиргэн донгодоход нь,  
Чамд хайртай нөхрийг минь, чи ер санадаг уу гэж асуудаг биз ээ.

Хувьтай чи, бэлэвсэн бус, чиний нөхрийн сайн нөхөр үүл  
Чамд түүний сэтгэлийн үгийг уламжлах гэж ирснийг тань!  
Гэргийн сүлжсэн гэзгийг нөхрөөр нь тайлуулах гэж  
Аянгын дуугаар аянчныг шавдагч үүл би байна гээрэй.

Тэр үг сонсоод, чиний зүг сэтгэл тэсгэлгүй яарч хараад,  
Үнэр хөлөглөгчийн хүүг Шита үзсэн адил харж хүндэтгэм заа  
Тэгээд чамайг сонсох нь, эмэгтэй хүнд нөхрийн мэдээ  
Нөхрөөс нь сонсохдоо, амраг лугаа учран нийлсэнтэй бараг нэг бий.

*Туйл:* Аяа, наснаа төгөлдөр! Бусдын тус бүтээвэл өөрийн тус бүтнэ.  
Миний үг сонсон дамжуулахдаа, амраг чинь Рамын ууланд  
Чамаас хагацан, амьд бөгөөд чиний мэндийг асууна гээ  
Тэр үг хагацах зовлонд учрагсдын ам нээж асуудаг үг.

Бие алсалж, үйлс буруутсан нөхөр чинь, нарийхан, туранхай,  
Уйлж гансарсан, халуурсан биетэй чинь эцэж турсан, уй гашуу болсон  
Амьсгаадсан хөөрхий биеэрээ нийлэн учирч байгаатай адил  
Дотроо сэтгэн санаж суугаа гэж хайртад минь хэлээрэй.

*Төгсгөл:* Бас нэмж хэлсэн нь: Намайг хүзүүдэн тэврээд унтаж байснаа  
Гэнэт хашхиран сэрж билээ чи. Дахин дахин асуухад,  
Ай давхар санаат! Чамайг ондоо авгайтай цэнгэлээ гэж  
Зүүдэнд орлоо гэж мишээн хэлснээ санам уу чи?

Аяа, хар нүдэт минь, тэр зүүднийх шиг намайгаа бодоод  
Элдэв юм битгий сана! Хагацахад сэтгэл хөндийрнө гэж  
Амьтны хэлэлцдэг тэр үг түмэн худал! Хагацахад  
Хайртай сэтгэлийн хүсэл хурсаар улам ч ихэддэг!

Аяа үүлэн, хагацал зовлонт намайг өрөвдөх нөхөр сөн  
Аль нэгэн сэтгэлээр миний өчүүхэн хүслийг гүйцэлдүүлээд,  
Хурын улирал ойртсоны сайхныг бадруулж ажран одохдоо,  
Агшин зуур ч цахилгаан хатагтай лугаа үл хагацах болтугай.

*Эх сурвалж: Шри Галидас. Үүлэн зардас. Орч.Б.Ринчен. УБ., 1964 он.  
(Товчлон авав.)*



**УНШИХ**

**Зохиолын талаарх сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлье.**

1. Сэрэмж алдсан ягшас яагаад үүлэнд хандав? Түүний дотоод сэтгэлийн тухай үзэл бодлоо илэрхийлээрэй.
2. Та нар зохиолоос юу мэдрэв? Аль үг хамгийн хүчтэй нөлөөлөв?
3. Байгалийн гоо сайхныг мэдэрч байгаа хэсгийг сонгон тэмдэглэнэ үү. Зохиолч ямар үг хэрэглэсэн бэ?
4. Зохиолыг уншиж дуусаад ямархуу сэтгэгдэл төрснөө ярилцана уу. Тухайлбал, хагацаж салсан хүмүүсийн уйтай байдлыг илэрхийлсэн, үүлэнд үгээ дайж байгаа нь үнэхээр их санагалзсаных гэх мэтээр өөр өөрийн сэтгэгдлийг зохиолын мөр бадгаас эшлэн ярьж болно.

*Зохиолыг дахин уншин, даалгаврыг гүйцэтгээрэй.*

**Зохиолын сэдэв, утга санааг тодорхойлъя.**

1. Хугацаатай цөлөгдөн алс хол суухдаа ард үлдсэн үзэсгэлэнт гэргийгээ дурсан гуниглаж, умар зүг нүүх үүлэнд хандан гэргийдээ сэтгэлийн үгээ хэлүүлэхээр цэцэг барин гуйж буй тухай, мөн тэрхүү үүлний дайрч өнгөрөх нутаг усыг зураглан гайхамшигтай урнаар өгүүлдэг. Энэ зохиолд ямар асуудал дэвшүүлсэн гэж тайлбарлаж болох вэ?
2. Бүдүүвчийг хэрхэн ойлгож байна вэ? Үүл, ягшас хоёрыг зохиолч гэж үзэж болох уу? Зохиолч юуг уншигчдад мэдрүүлэхийг, хэлэхийг хүссэн бэ?



**Зохиолын гадаад орчныг тодруулж, дүрийн зан төрхөд хэрхэн нөлөөлж байгааг дүгнэе.**

1. Ягшасын үүлэнд хандан хэлж байгаа мөр, бадгуудад байгалийн үзэгдэл, уул ус, хүн амьтан, юмсын талаар хэрхэн дүрсэлсэн бэ? Байгалийн гоо үзэсгэлэнг өгүүлсэн дүрслэл нь дүрийн дотоод сэтгэлтэй хэрхэн уялдаж байгааг бадаг, мөр бүрээр задална уу.
2. Уг бүтээлд гадаад, дотоод орчин хэрхэн дүрслэгдсэн бэ? Эсвэл дотоод орчныг уу, нэг бол гадаад орчныг илүү чухалчилсан уу? 10 дугаар хуудсанд буй түлхүүр нэр томъёог судлаарай.

**Яруу найргийн хэлбэр, бүтцийг шинжилье.**

1. Найраглалыг уншихад үргэлжилсэн хэлбэртэй байна уу, шүлэглэсэн хэлбэртэй байна уу? Хэлэлцээд, дүгнээрэй.
2. Өмнө уншсан Монгол найраглалаас хэлбэр бүтцийн хувьд юугаараа ялгаатай байна вэ?

## ОМАР ХАЙЯМ

(1048 – 1122)



Эдүгээгээс мянгаад жилийн тэртээ Ираны Нишапур хотноо мэндэлж, аж төрж асан Омар Хайям бол "Рубай" хэмээх дөрвөн мөрт шүлгийн хаан гэж алдаршсан нэгэн юм. Омар Хайям яруу найрагч төдийгүй гүн ухаантан, тоо зүйч, одон оронч, зурхайч, хөгжим судлаач, эмч бөгөөд "Үнэнийг нотлогч", "Өрнө, Дорнын гүн ухаантнуудын хаан" хэмээн цоллогддог хүн байжээ. Яруу найрагч тэрбээр баахан адайр зантай бөгөөд бурхан тэнгэр, мухар сүсэгт үл автан, тэр ч бүү хэл Аллах тэнгэртэй "заргалдаж", зад шүүмжилж, амраг хонгор, амтат дарс, эгэл ваарчин, энгүй урчууд болон өөрийн амьдралын амтат үнэн, гашуун зовлон сэлтийг өөртөө болон нөхдөдөө зориулан шүлэглэн бичдэг байв. Түүний тэрхүү рубайнууд нь хэдийгээр ил гарч байгаагүй боловч аль хэдийн ард олны дунд аман зохиол мэт түгэн дэлгэрдэг байжээ.

Омар Хайям наян насыг зооглоод, өөрийн багш Ибн Синагийн "Анагаах судар"-ыг барьж, шүдний алтан чигчлүүрээ завсарт нь хавчуулаад "Тэнгэр бурхан минь таныг таних гэж чадлаараа зүтгэв, тантай арцалдаж явсныг минь өршөө, таныг таних тусам танд ойртдог юм шүү" хэмээн хэлээд тэнгэрт хальсан гэдэг билээ.

## РУБАЙ

Яс мах, бие цогцсыг бүрдүүлэгч, бүхнээс хүчит бурхан  
Яагаад бидэнд мөнх нас бэлэглэхийг хүсээгүй юм бол?  
Хэрвээ бид төгс төгөлдөр юм бол юунд үхдэг билээ  
Хэрвээ төгс бус бол хэн тэгээд гологдлыг бүтээсэн юм бол?

хх хх хх

Эзэд ноёд энд хоргой торгонд хөлбөрч байсан  
Эднүүст элч нар хар хурдаараа ирдэг байсан  
Өдгөө энэ бүхэн баларч, нурсан балгасны ормон дээр  
Өнчин хөхөө ганцаараа гүүг гүүг донгодно.

хх хх хх

Үхэх төрөхийн утга учир оньсого мэт  
Үзтэл мэргэд утга учрыг нь олж чадсангүй  
Битүү цагаригийн эхлэл, төгсгөл хаана байнам  
Бид хаанаас ирсэн, хаашаа одох вэ?

Эх сурвалж: "Бүх цаг үеэс сонгосон дэлхийн яруу найргийн дээж  
"Гурван зуун шүлэгт". Эмхэтгэсэн Г. Мэнд-Ооёо. УБ., 2013 он. 82-84 дүгээр тал



## ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО:

Рубай гэдэг нь дөрвөн мөрт, гүн ухааны утга агуулгатай, онч мэргэн санаатай шүлгийг хэлнэ. ААББ, АААА гэсэн хатуу тогтсон загварын холбоцтой байна.



### Зохиолын талаарх сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлье.

1. Шүлгийг уншаад юу гэж ухаарч болохыг эргэцүүлэн бодож, санаагаа бусдадаа хэлнэ үү. Яагаад тийнхүү бодсоноо итгэл үнэмшилтэйгээр тайлбарлахыг хичээгээрэй.
2. Өөрийнхөө ойлгож, ухаарсныг бусдын санаа бодолтой харьцуулж, ижил болон ялгаатай байдлыг харьцуулна уу.
3. Шүлгийг уншаад шууд төрсөн сэтгэгдэл, бусадтайгаа санаа бодлоо солилцсоны дараах сэтгэгдэл хэр ялгаатай байна вэ?
4. Рубай шүлгээс юу юуг сурч мэдэж болох вэ? Та нарын үзэл бодол, хандлагад хэрхэн нөлөөлж болох вэ?

### Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн уялдаа холбоог тодорхойлъё.

1. Гүн ухааны сэдэвтэй шүлэг гэдэгтэй санал нийлэх, эсвэл нийлэхгүй байгаагаа жишээгээр батлан хэлнэ үү.
2. Эхний Рубай дахь “Яагаад бидэнд мөнх нас бэлэглэхийг хүсээгүй юм бол?” гэсэн асуултад хариулж ярилцаарай.
3. 2 дахь рубай шүлгийг дахин уншаад, зохиолчийн дэвшүүлсэн асуудлыг хэлэлцээрэй.
4. Битүү цагариг гэж юуг хэлэв? Зохиолчийн хэлсэнчлэн “Битүү цагаригийн эхлэл, төгсгөл” хаана байна? Та нар юу гэж бодож байна?
5. Дээрх Рубай шүлгийг Монголын “Авах гээхийн 4 мөрт” шүлэг, Японы Хайку шүлгүүдтэй утгын хувьд харьцуулаарай.



Нүцгэн мөчир дээр  
Хэрээ суув.  
Намрын үдэш.

Хүүхдүүд ээ, та нар Хайку шүлгийн тухай сонссон уу? Японы алдарт зохиолчийн нэгэн шүлгийг тайлбарласныг сонирхон уншаарай.

Навчаа гөвчихсөн үхмэл, нүцгэн мөчир дээр суугаа ганц хэрээ нэг л ер бусын, энэ хорвоогоос тасран одсон мэт сэтгэгдэл төрүүлдэг. Намрын үдэш, орой гэсэн үгээр дуусаж, төгсөж байгаагийн үнэр ханх татна. Хачин нууцлаг, ёроолгүй ангал шиг хязгааргүй уудам энэ амьдралыг ингэж мэдрэхэд олон үг, урт найраглал хэрэггүй.

Энэ нь ч уртдаж байх шиг. Яг л бидний дээр ярьсан, бийрийн ганц шүргэлт шиг бүхнийг илэрхийлж чадаж байгаа биз? Яруу найрагч уудам амьсгаа аваад л, дотоод оюун ухааны эрчим хүчийг тав зургаахан үгээр хэлчихжээ. Хамгийн чухал нь, мөнхүү шүлгийг жинхэнэ яруу найраг болгож буй чанар үүнийг бичсэн оюун ухаан энэ амьдралаас нэгэнт ангижирчихсанд буй хэрэг.

Эдгээр хайкуг ганцхан ингээд л тайлбарлачихдаг гэж ойлговол бас өрөөсгөлдөнө. Яаж ч тайлбарлаж болно. Бас огт тайлбарлахгүй байх нь илүү зөв ч байж мэднэ.

Зэн – буддизмын үүднээс, магадгүй, хэчнээн буруу ойлгоно, төчнөөн сайн. Учир нь нэг л маягийн тайлбараар хашчихвал эдгээр хайкуны үнэ цэн буурчихна, гажчихна, хязгааргүй биш болчихно.

Г. Аюурзана



## МАЦУО БАШЁ (1644 – 1694)



Хүн төрөлхтний яруу найргийн цэцэрлэгт хүрээлэнд “Хайку” хэмээх шүлгийн дэг горимыг боловсруулан төгөлдөржүүлж, өөрөөсөө хойших үеийн хайкучдын багш нь болсон даяанч шүлэгч Мацуо Башё бол бүхий л цаг хугацааг эзэлсэн суут яруу найрагч юм. Түүнийг дагагч, дэг сургуулийг нь баримтлагч үй олон яруу найрагч Япон улсад төрсөн бөгөөд тэр бүхний эхлэл нь Башёгийн сургууль билээ. Хайку нь тав, долоо, тав буюу арван долоон үеийн бүтэцтэй бөгөөд заавал дөрвөн улирлын аль нэгийг төлөөлсөн үг орсон байх ёстой. Түүнээс бус гурван мөр шүлгийг хайку гэж бодвол эндүүрэл болно. Башё “Хайкуг сэтгэлд мэдрэгдмэгц бичих хэрэгтэй, ухаан мэдлэг дундуур орж амжихаас өмнө урьтах хэрэгтэй” гэдэг байсан нь шүлгийн энэ төрлийн онцлогийн тухай хамгийн зөв тодорхойлолт юм.

## ХАЙКУ

Хуучин цөөрөм рүү  
Хөөрхий мэлхий дэвхрэхэд  
Усны чимээ гарав.

хх хх хх

Нүцгэн мөчир дээр  
Нэвсгэр хэрээ сууж байгаа нь  
Намрын үдэш санж.

хх хх хх

Аймшигт ядуу эр  
Амуу цайруулахаа болиод  
Онгон сарыг ширтэв.

хх хх хх

Яг замын хажууд  
Ягахан цэцэг дэлгэрчээ.  
Яая гэхэв, морь минь идчихлээ!

хх хх хх

Хэрвээ би явган явсан бол  
Хээрийн энэ толгод дээр  
Мориноосоо юу гэж унах вэ дээ.

Өвч биеийн сүүдэр  
Эмээл дээрээ царцах нь  
Өвлийн нарны илч аж.

хх хх хх

Аяа, хувь зохиол гэж хачин юм даа  
Алдарт энэ дуулган дотор эдүгээ  
Адгийн хүрэлзгэнэ дуугарч байна шүү.

хх хх хх

Мөчрөөс мөчирт  
Мөлхөн урсах нь  
Хаврын бороо ажээ.

хх хх хх

Өвлийн өглөө анхны цасан дээр  
Өөдгүй хэрээ ч  
Өнгө засжээ.

Эх сурвалж: Хөвсгөл.С. “Өрнө дахины уран зохиол  
(Түүхэн найрууллууд)” УБ., 2013 он. 183-188 дугаар тал



**УНШИХ**

**Зохиолын талаарх сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлье.**

1. Хайкуг уншаад чи юу мэдрэв? Ямар ямар агшныг буулгасан байна вэ?
2. Хайкуг гүн ухааны шүлэг гэж хэлж болох уу?
3. Хайкуд зохиолчийн мэдлэг, ухаан бодол, эргэцүүлэл чухал байна уу, мэдрэмж чухал байна уу? Юу бодогдож байна?

**Зохиолын далд утгыг тайлан тайлбарлая.**

1. Дараах шүлэгт ямар далд утга байж болох вэ? Багаараа ярилцаж, тайлан тайлбарлана уу.

Тайлбарлахдаа үг бүрийн цаадах үндсэн утгыг эргэцүүлээрэй.

“Хуучин цөөрөм рүү  
Хөөрхий мэлхий дэвхрэхэд  
Усны чимээ гарав”

2. Яруу найрагч Б. Явуухулан хэрхэн тайлан тайлбарлав? Эргэцүүлээрэй.

“Хуучин цөөрөм” хайку нь хаврын тухай шүлэгт холбогдох бөгөөд яагаад гэвэл “мэлхий” гэдэг нэр бол хаврын улиралд их яригддаг “улирлын чанартай үг” юм. Япончуудын зан заншил ёсоор мэлхийн дууг хамгийн сайн сайханд тооцдог ажээ. Алтан гургалдайн дуу ямар сайхан юм бэ, түүнтэй нэгэн адил үзэж хаврын мэлхийн анхны дууг япончууд тэсэж ядан хүлээдэг байна. Энэ нь зуны эхэн сарын хөхөөний анхны дууг монголчууд тэсэж ядан хүлээдэгтэй яг адил юм.

**Зохиолын гадаад орчин нь “би баатар” -ыг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг дүгнэе.**

1. Хайку шүлэгт ямар орчин ихэвчлэн дүрслэгдэж байна?
2. Зохиолчийн намтар, үзэл бодлыг С. Хөвсгөл, Г. Аюурзана нарын номоос дэлгэрүүлэн сурвалжилж уншаарай. Яагаад байгалийн сэдвийг хөндөж, тийм орчныг бичдэг болох талаар хэлэлцээрэй.
3. Хэлэлцэх чадвараа дараах шалгуураар үнэлээрэй.

	Тийм	Үгүй	Сайжруулах саналтай байна.
Хэлэлцэхдээ шинэ санал дэвшүүлсэн үү?			
Бусдын хэлснийг хүлээцтэй сонссон уу?			
Ээлж дараатай ярьж чадсан уу?			
Хэлэлцүүлгээс дүгнэлт гаргасан уу?			

4. Орчныг дүрсэлснээр нь Мацуо Башёг хувь хүнийх нь хувьд тодорхойлоорой.
5. Та нар байгалийн элдэв үзэгдлийг ажигладаг уу? Ажиглаж мэдэрснээ гурван мөр, арван долоон үед багтааж бичиж туршаарай.

**Яруу найргийн хэлбэр, бүтцийг шинжилье.**

1. Рубай шүлгээс хэлбэрийн хувьд юугаараа ялгаатай байна вэ?
2. Хэдэн мөр, хэдэн үеэс бүтсэн байна вэ?
3. Хайку шүлгийг өөрийнхөөрөө тодорхойлж, бусдад таниульга гэвэл яаж илэрхийлэх вэ?

## ФРАНЧЕСКО ПЕТРАРКА (1304 – 1374)



Сэргэн мандалтын үеийн Италийн агуу их яруу найрагч, эрдэмтэн, гүн ухаантан, дипломатч, аялан жуулчлагч. Эртний Ромын эзэнт гүрний алдарт туульсын хэв маягаар эх оронч үзэл, Италийн эв нэгдлийг эрхэмлэн дуулж, латин хэлээр туурвисан “Африк” хэмээх туульсын найраглалаараа яруу найрагчдад олгодог дээд шагнал “Лаврын алтан титэм” хүртжээ.

Ф.Петрарка хайр сэтгэлийн уянгын олон зуун сонет туурвисны дотор Лаура хэмээх эмэгтэйд өгсөн насан туршийн, эхний бөгөөд эцсийн дурлалдаа зориулж бичсэн нь нэн алдартай. Тэрбээр гэр бүлтэй Лаура хүүхэнд 1348 онд анхны харцаар дурлаж, цөөхөн удаа нүүр учрах төдий явснаас бус уулзаж, ярилцаж, ойр дотно танилцаж байгаагүй ажээ. Өөрийн эр нөхөртөө 11 хүүхэд төрүүлж өгсөн, тулхтай, журамт эзэгтэй Лаура Ф.Петраркаг анх харснаас хойш 21 жилийн дараа таалал төгсжээ. Яруу найрагчид энэ мэдээ асар их уй гашуу авчирсны улмаас өөрийн үнэнч хайр сэтгэлдээ зориулсан уянгын гайхамшигт сонетуудаа бичсэн түүхтэй.

### СОНЕТ

Удам угсаа сайтынх – төлөв даруухан  
Ухаан оюун саруулынх – сэтгэл ариухан  
Намба төрх сайхных – цаг ямагт цэвэрхэн  
Нас биед хүрснийх – цэл залуу цэцгэн

Энэ бүсгүйд од гараг нь өгөөмөр ханджээ  
Эргэлзээгүй, хан хорвоо өндрөөс соёрхжээ  
Эрхэм дээд төрөлтний бүхий л чанар бүрджээ  
Их найрагч ч өөрийн эрхгүй өвдөг сөгджээ.

Хайр сэтгэл, шударга үнэнийг хан тэнгэрээс  
Харамгүй хүртээж, энэ л бүсгүйд цогцлуулжээ.  
Хараад ханашгүй гоо үзэсгэлэнг цэцэглүүлжээ.

Жин үдийн гэрлийг шөнө дөлөөр ч олж харах  
Жимс шарилж хоёрын жинхэнэ амтыг ялгах  
Жирийн бус амьдралд хараатай л яваасай билээ.

*Эх сурвалж: “Бүх цаг үеэс сонгосон дэлхийн яруу найргийн дээж “Гурван зуун шүлэгт”.  
Эмхэтгэсэн Г. Мэнд-Ооёо. УБ., 2013 он. 103 дугаар тал*



**УНШИХ**

**Зохиолын талаарх сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлье.**

1. Шүлгийг уншихад ямар санагдаж байна вэ? Ийм төрлийн шүлэг уншиж байсан уу?
2. Зохиолчийн сэтгэл хөдлөлийг мэдрэв үү? Ямар үг, дүрслэл онцгой санагдав?
- 3 Шүлгийн аль хэсэг таалагдав? Яагаад?
4. Эмэгтэй хүнийг хайрлах, бахархах санаагаа илэрхийлэхдээ ямар үг сонгосон байна вэ?
5. Энэ нь уншигчдад ямар сэтгэгдэл төрүүлж байна?
6. Хэрвээ төгсгөлийн мөрийг бүтээгээгүй бол уншигчдад ямар сэтгэгдэл үлдээх бол?
7. “Жин үдийн гэрлийг шөнө дөлөөр ч олж харах”, “жимс шарилж хоёр” гэх мэт үгсийг сонгон хэрэглэсний учир юу вэ?

**Зохиолын сэдэв, утга санааг тодорхойлъё.**

1. Хайр сэтгэлийн тухай өгүүлэхээс гадна төгсгөлийн бадагт ямар асуудлыг хөндөж бичив?
2. Дүгнэлтийг уншаад, шүлгийн бүтцийг утга санаатай холбон ажиглана уу.

Ф.Петраркагийн сонет нь 1 наймт буюу 2 дөрөвт, 1 зургаат шүлгээс бүрдэх бөгөөд наймт шүлэгтээ асуудлаа дэвшүүлж, санал сэтгэгдлээ хуваалцдаг бол зургаат шүлэгтээ ялангуяа сүүлийн гурван мөртөд гэнэт эргэлт хийн, хэлэх гэсэн санаагаа илэрхийлдэг.

**Яруу найргийн хэлбэр бүтцийг шинжилье.**

1. Хүснэгтэд сонетийн тухай томъёолж, тодорхойлж туршина уу.

Дэмжлэг болох асуулт:



- Сонет гэдэг нь хэдэн мөрийн шүлгийг хэлдэг вэ?
- Хайр, рудайлаас ялгаа нь юунд байна?
- Бадаг бүрийн зүйгэн ялгааг ажиглаад, сонетийн бүтцийг тодорхойлно уу.



**ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО:**



## БИЧИХ

**Яруу найргийн хэлбэр, бүтцийг дуурайн, тодорхой сэдвийн хүрээнд санаагаа хөгжүүлэн, дүрслэн бичье.**

### Сонгож ажиллах дасгал

Рубай шүлгийн хэлбэр бүтцийг дуурайн зохиож турших зорилготой бол:

1. 23 дугаар хуудсан дахь Рубай шүлгийн хэлбэр, бүтцийг дахин ажиглаарай
2. Амьдралын утга учрын тухай, хүн яаж амьдрах ёстойн тухай эргэцүүлэн бодсоны үндсэн дээр зохионо уу.
3. ААББ, АААА гэсэн загвараар толгой холбох шаардлагатай. Заавал 4 мөрт шүлэг байна гэдгийг анхаараарай.

Хайку шүлгийн хэлбэр бүтцийг дуурайн зохиож турших зорилготой бол:

1. 25 дугаар хуудсан дахь Хайку шүлгийн хэлбэр, бүтцийг дахин ажиглаарай
2. Ямар нэгэн юмны тухай эргэцүүлэн бодсоноо, эсвэл мэдэрсэн мэдрэмжээ буулгахыг эрмэлзээрэй.
3. 3 мөр, 17 үенд санаагаа багтаагаарай.

Сонет шүлгийн хэлбэр бүтцийг дуурайн зохиож турших зорилготой бол:

1. 27 дугаар хуудсан дахь Сонет шүлгийн хэлбэр, бүтцийг дахин ажиглаарай.
2. Эхний 8 мөрөнд ямар нэгэн зүйлийн тухай асуудал дэвшүүлэн, сэтгэгдэл, мэдрэмжээ бичих бол сүүлийн 3 мөрөнд хэлэх гэсэн санаагаа илэрхийлээрэй.

	Маш сайн	Хангалттай	Сайжруулах шаардлагатай
Сонгосон шүлгийнхээ тогтсон хэлбэр, бүтцийг сайн ажиглаж, дуурайж чадсан уу?			
Шүлэг зохиож туршигдаа ямар нэгэн зүйлийн тухай эргэцүүлэн бодож, шүүн тунгаасан уу?			
Үгээ оновчтой сонгож, утгын хувьд зөв холбосон уу?			
Ноороглон, алдаагаа сайн зассан уу?			

### Хосоороо ажиллаж болно.

1. Уншсан шүлгүүдээс аль нэгийг дуурайн бичих зорилгоор сонгоно уу. Зохиох шүлэгтээ юуны тухай өгүүлэхээ төлөвлөөрэй, хэлэлцээрэй.
  2. Бичсэн шүлгээрээ дамжуулан уншигчдад юу хэлэхийг хүсэж байна вэ? Хэлэлцээрэй.
  3. Хэдэн мөртэй, хэдэн бадгаас бүтсэн байж болохыг төлөвлөөрэй.
  4. Зохиоходоо ямар үгийг сонгож бичихээ бодоорой.
  5. Ноороглож бичээд бусадтайгаа зөвлөж ярилцаарай.
  6. Ноороглноо сийрүүлэн бичиж засварлаарай.
  7. Үсгийн дүрмийн болон найруулгын алдааг хянаарай.
- Найруулгын алдааг засахдаа дараах шалгуурыг хэрэглэнэ үү.

	Тийм	Үгүй	Сайжруулах саналтай байна.
Уншихад ойлгомжтой байна уу?			
Үгийн үндсэн утгыг шилжүүлж, өөр утгатай үгээр сольсон уу?			
Үг нэммээр байна уу? Ямар үг нэмэх вэ?			
Үг хасмаар байна уу? Ямар үг хасах вэ?			
Үгийн байрлалыг солимоор байна уу?			

**ХЭРХЭН СУРАЛЦСАНАА ҮНЭЛЬЕ.**

**Мэдлэгээ үнэлье.**

1. Хайку, сонет, рубай гэж ямар шүлгийг хэлдэг вэ? Тодорхойлно уу.
2. Зохиолчдын намтрын талаар ярилцана уу.

**Чадвар, хандлагаа үнэлье.**

1. Шүлгийн утга, дүрслэх үг бүрийг мэдэрч, ойлгон уншиж сурсан уу?
2. Хайку, сонет, рубай шүлгүүдийн ялгааг жишээгээр тайлбарлана уу.
3. Яруу найрагт далд утга илэрдэг гэдэгтэй санал нэгдэж байна уу? Яагаад?
4. Уран дүрслэлийг зохиолоос таньж чаддаг болсон уу?
5. Яруу найргийг унших нь жүжгийн зохиол, хүүрнэл зохиолыг уншихаас ялгаатай юу? Ялгаа нь юунд оршиж байна?
6. Шүлгийг уншихад сэтгэл чинь хэр хөдөлж байна?
7. М.Ю.Лермонтовын “Уйтгартай ч байна, гунигтай ч байна” шүлгийг уншаад, сэдэв, утга, далд утга, хам сэдвийн онцлог, уран дүрслэлийн онцлог, гадаад дотоод орчныг тодруулан асуулт боловсруулаарай.  
 Үймрэн тачаадсан гүн зовлонт үед  
 Санаж сарвайх ч хүнгүй  
 Уйтгартай ч байна, гунигтай ч байна  
 Хүсэж зорих уу?  
 Үргэлж дэмий хүсэж тэмүүлсний хэрэг юу билээ?  
 Үнэтэй сайхан он жил өнгөрсөөр л байна.  
 Амраглаж дурлах уу?  
 Дурлая гэхэд хэндээ ч дурлах билээ?  
 Хэсэгхэн зуур дурлаад ч яах юм билээ,  
 Хэзээд мөнхийн дурлал гэж байдаггүй шүү дээ.  
 Балран арилж мөргүй болсон өнгөрсөн явдлаа дурсахад  
 Баясан хөөрч, зовон гиюүрч явсан минь юухан ч билээ дээ...  
 Тачаал хүсэл ч гэсэндээ  
 Эрт орой хэзээ нэгэн цагт эргэцүүлж бодохтой зэрэг л  
 Аль сайхан бүхэн нь арилж үгүй болно шүү дээ.  
 Хүйтэн харцаа тусгаж орчин тойрныг ийн ажихад  
 Хүний амьдрал гэдэг чинь мунхаг, хоосон, шог юм байна.

Эх сурвалж: “Бүх цаг үеэс сонгосон дэлхийн яруу найргийн дээж “Гурван зуун шүлэгт”.  
 Эмхэтгэсэн Г. Мэнд-Ооёо. Орч. Хасбаатар.Ц, УБ., 2013 он. 180 дугаар тал

# 3

## ХҮҮРНЭЛ ЗОХИОЛ

### ГУРАВДУГААР БҮЛГИЙН ЗОРИЛГО:

- Монголын болон дэлхийн хүүрнэл зохиолын сан хөмрөгтэй танилцаж, баялаг мэдлэгтэй болно.
- Хүүрнэл зохиолыг уншиж, задлан шинжлэх чадвартай болно.
- Уншсан зохиолын хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн хэлэлцэж сурна.
- Зохиолын утга, бүтцийн онцлогийг задлан шинжилж бичихдээ холбогдох нэр томъёог хэрэглэж сурна.
- Уншсан зохиолын баатруудын зэрэг, сөрөг зан чанарыг үнэлж, сайнаас суралцана.



Эх сурвалж: “Цагаан дара эх” XIX зуун шороон будаг, даавуу, 154\*120см, №76.

16.395

Г. Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей



## УНШИХЫН ӨМНӨ

Хүүхдүүд ээ, та нар “Цагаан дара эх”, “Ногоон дара эх”, “Хорин нэгэн дара эх” гэж сонссон л биз дээ. Магадгүй, “- Ээ, Дара эх минь!” гэж уулга алдаж байгаа эмээ, “Дара эх”-ийн ном гүрэм уншиж байгаа лам хуврагтай тааралдсан л байх.

Цагаан дара эхийг эх хүний дүрээр заларсан насны гурван бурхны нэг гэдэг бөгөөд хамаг амьтны насыг уртасгах их ерөөл тавьсан бурхан хэмээдэг ажээ. Зохиогдох үеийн нийгмийн байдал, шашны үзэл бодол зохиолд илрэх хэдий ч эрдэм ном, энэрэл хайр, нигүүлсэнгүй сэтгэлийн эх булаг бол тусч өгөөмөр, хүнлэг энэрэнгүй, үнэнч шударга, оюун ухаант хүний зөв сэтгэл, зөв үйл гэдгийг та нар зохиолоос мэдрэх болно.

Та бүхэн одоо “Нарангэрэл дагины тууж” буюу “Цагаан дара эхийн тууж” хэмээх сонирхолтой зохиолын хэсэгтэй танилцах гэж байна. Эх зохиолыг бүрнээр нь уншаарай.

## НАРАНГЭРЭЛ ДАГИНЫ ТУУЖ

(Цагаан дара эхийн тууж оршвой)

Үнэнийг өгүүлэгч хойт гэргий авсан  
нэгдүгээр зүйл

Эрт Жин улсын цагт Нантай голын эхэнд Нанжин нэрт балгасанд Гау нэрт баян өвгөн сартваахь байжээ. Түүний хөвүүний нэр нь Үнэнийг өгүүлэгч бөлгөө. Тэр цагт Лянхуа гэрэл нэрт газарт Мон нэрт баян сартваахь байжээ. Түүнд өөр үр хүүхэд үгүй, ганц охинтой ажээ. Тэр охин өнгө сайт, маш үзэсгэлэнт, номд ихэд гийсэн, ааль номхон, сэтгэл зөөлөн, чин зориг нь гайхамшигт, нэр нь Нарангэрэл. Тийм нэг охиныг сонсоод Гау нэрт баян одоод гуйн авч, хөвүүндээ гэргий болгож өгөв. Төдий эр эм хоёул маш хайрлалдан эцэг эх хоёртоо их хүндлэлт ажгуу.

Тийн яван атал нэг өдөр Гау нэрт баян Үнэнийг өгүүлэгч хөвүүнээ дуудаад сургаж өгүүлрүүн: - “Аяа, хөвүүн минь. Хөгшин хүний сургасан үгийг сонс! Орчлонгийн явдал зүүд гилбэлгээн мэт. Төрөх, өвдөх, үхэх, өтлөх энэ дөрвөн их далайг яахин гэтлэх бид. Эдүгээ миний олсон эд агуурс, хүн, мал, гэр балгас эцэст барагдмуй за. Чи дээд гурван эрдэнэ бурхны үсэгт номуудыг сурах хэрэгтэй. Орчлонгийн ноён баян болох бичгүүдийг сурах хэрэгтэй. Басхүү хүний есөн эрдмийг сурах хэрэгтэй. Хөвүүн ээ, миний үг зөв болох бөгөөс би бэрх үнийг өгч, багш нарыг хурааж, эрдмүүдийг сургая” хэмээв. Хөвүүн алгаа хамтатгаж, үнэн сүсэг сэтгэлээр хариу өгүүлрүүн: - “Их нигүүлсэгч өвгөн эцэг, эмгэн эх минь таны өгүүлснээр болтугай” гэв. Төдий эцэг эх нь тэр үгийг нь сонсож баясаад төгс эрдэмт их багш нарыг урин ирүүлж, бэрх үнийг хайрлалгүй өгч, хөвүүнээ сургав. Тэр Үнэнийг өгүүлэгч хөвүүн төдөлгүй хамаг эрдмийг гайхамшигтай сурав.

Тийн яван атал Гау нэрт баян сартваахь насны энд хүрч үхэв. Түүний хойно улам улмаар машид үгүйрэв. Тэр цагт “Жин улсын хаан төрийг барих эрдэм



билигт хүнийг эрж байна” хэмээн их бичгийг тэр улсад тунхаг тархаав. Эх нь сонсоод хөвүүндээ өгүүллүүн: -“Авай минь, тэнгэрийн хөвүүний зарлигийг сонсов уу, чи минь. Сурсан эрдэм билгээ хааны хотод одож үзүүлээсэй. Гурван эрдэнэ үнэн бөгөөс хэр ноён болох мэдээ үгүй. Энэ үгээгүй дутуу явахаас дээр буюу” хэмээв. Хөвүүн нь тэр эхийнхээ сургасан үгийг сонсоод өгүүллүүн: -“Их нигүүлсэгч эх минь ээ, язгуурын баян сайн үгүй болов. Гэргий минь өчүүхэн. Намайг хааны хотод одсоны хойно чамайг хэн тэжээх” хэмээн эс болов. Гэргий нь Нарангэрэл бас сургаж өгүүллүүн:

“Нөхөр минь, чиний сурсан эрдэм чинь маш их буюу

Эдүгээ хааны хотод одож ноён болоод

Эртхэн эцэгт чинь залгамж

Энэ биед чинь алдар нэр их

Эх, эм хоёрт чинь ашдын хүнс буюу” хэмээв.

Үнэнийг өгүүлэгч мөн үг өгүүлээд эс болов. Түүний хойно нэг айл мэт суух Жэу нэрт өвгөн ирж, Үнэнийг өгүүлэгчийг ятган хот руу явуулахаар болов. Үнэнийг өгүүлэгч уйлаад, хариу өгүүллүүн:

Эцэг мэт өвгөн минь сонс!

Эх минь насанд хүрсэн буюу

Эм минь өчүүхэн, эд агуурс барагдав.

Эзэн хааны хотод одсоны хойно

Яван ядах эхийг минь хэн тэтгэх

Идэх өмсөх хэн өгнө

Ил эчнээ зовох жаргахыг хэн өчнө

Ямагт миний бие одож үл болох” хэмээв.

Жэу өвгөн өгүүллүүн:

“Ай хөвүүн минь ер эх, эмийн тул бүү зов

Аран боол би өгье

Их бага идэх өмсөх би өгье

Авай минь чи одож, ноён болоод

Ашдын хүнс олж

Ачит эцэг эхийн

Ач хариулж, нэрээ дэлгэрүүлбэл сайн бөлгөө” хэмээх үгсийг Үнэнийг өгүүлэгч сонсоод, хэтэрхий бишрэн баясан өгүүллүүн:

Гийсэн өвгөн асрах үнэн бөгөөс

Хэв хэзээ эцэг минь чи болох буюу

Тийн зөвшөөн тархав.

...Үнэнийг өгүүлэгч Жин улсад очтол ноён нь Үнэнийг өгүүлэгчийн эрдмийг сайшааж, дотоод яамыг мэдэгч ноён болгов.

Тийн яван атал тэр цагт Жин улсын хаанд төрийг баригч бас нэг Лүгэ нэрт их ноён байв. Тэр Лүгэ нэрт ноён үргүй, ганц охинтой бөлгөө. Үнэнийг өгүүлэгчийг эрдэм ихт гэж ноён болсныг сонсоод, хурим бэлдэж, Үнэнийг өгүүлэгчийг дуудав. “-Хүргэн чи бол, чамд охиноо өгье” гэтэл Үнэнийг өгүүлэгч үл таалан хариу өгүүллүүн: -“Лүгэ ноён, чи сонсогтун! Миний гэрт тавьж ирсэн хөгшин эх минь бий. Салхин газарт тавьсан зул унтрах ойр. Бас өчүүхнээс учирсан гэргийгээ тэвчиж, учиргүй бас эм авбаас муушаах нэрийг авч энэ орчлонд алдарших биз” хэмээв. Лүгэ ноён маш их хилэгнэж өгүүллүүн:

Маргааш чиний эх, гэргий хоёрыг авч ирээд хамтаар жаргалдъя гэв. Үнэнийг өгүүлэгч тэр үгэнд итгэж хариу өгүүллүүн: -“Их ноён оо! Хайрлах чинь үнэн бөгөөс мөн төрүүлсэн эцэгт адил” хэмээсэнд Лүгэ ноён баясаад их хурим бэлдэж, үр саднаа хурааж, охин Тонолжингоог засаад, Үнэнийг өгүүлэгчид өгөв. Үнэнийг өгүүлэгч хойд гэргий авсан нэгдүгээр зүйл төгсөв.

**Үгийн тайлбар:**

сартваахь – зам заагч, удирдагч, жолоодогч, тэргүүн  
 гилбэлгээн – цахилгаан мэт, түр зуурын  
 ил, эчнээ – ил болоод далд  
 аран – ард  
 хурдан – үтэр  
 янагш – нааш  
 мунасан – өтөлсөн, мунгинасан  
 тэнгэрийн хөвүүн – хаан  
 исэр дэвсгэр – түшлэггүй мухар сандал, ор дэр, дэвсгэр  
 монгүй – олон утгат  
 нуган - хүү  
 ааль – зан ааш  
 тойн – ламын хүндэтгэл нэр, язгууртан гаралтай лам  
 адистид – соёрхол, өршөөл, аврал, хишиг, адис, жанлав

1. Дүрүүдийг нэрлэнэ үү.
2. Гау нэрт баян өвгөн хүүдээ юу захиж сургаж? Та нар байсан бол Гау нэртийн хэлснийг хэрхэн хүлээн авах вэ?
3. Үнэнийг өгүүлэгч гэр бүлээ ямар байдалтай орхиж явав? Тэр явахгүй байж болох байсан уу?
4. Жин улсад ирээд Үнэнийг өгүүлэгчид юу юу тохиолдов?
5. Яагаад өөр ноёны охинтой гэрлэх болов? Энэ шийдвэр зөв байсан уу?

**Нарангэрэл хулгайчийн гараас гарч явсан  
 хоёрдугаар зүйл**

Үнэнийг өгүүлэгчийн язгуурын гэргий Нарангэрэл нулимсаа асгаруулж өгүүллүүн:

Эх минь өтлөв

Өвчинд басхүү дарагдав

Гэрт юм үгүй

Гэрийн эзэн минь одсоор дөрвөн жил болов.

Хэрвээ эхийн минь өвчин хөдөлж үхвээс

Гээх цаас, барих буянгүй яах билээ хэмээн гаслан уйлаад эхийнхээ дэргэд одоод асуув.

“Өвчинг чинь эмнэж болох буюу?” хэмээсэнд эх нь өгүүллүүн:

Өвчин минь байсаар байнам

Сэхээгүй муу хөвүүний тулд

Санасаар өвчин олов, би

Сайн бэр чи мах олох бөгөөс

Сааралгүй гуйж ир, би идье.

Бэр нь дуугүй гараад гасалж өгүүллүүн:

Зүдэх цагт бусад хэн ч мах үл өгнө  
 Их онгоц далайд даруулга нь хугарсан мэт  
 Зовлонт энэ бие минь  
 Юуны арга хийж үл болно хэмээгээд хүж зул шатааж, их нигүүлсэгч Хонсим  
 бодисадвад залбираад:

**Хурц хутга барьж**

**Хувьт өөрийн мөрний зузаан газраас**

**Хурдан нэг хэсэг мах огтолсонд**

**Хотол үхэдхийж, газарт унав.**

**Урссан цус нь булаг мэт болж байв.**

**Үзэгч Хонсим бодисад нигүүлсээд**

**Үнэн чин зоригоор ухваас**

**Удалгүй яр нь анагаав.**

**Эрдэмт Нарангэрэл махаа**

**Элдэвчлэн амталж чанаад**

**Эхдээ өргөв.**

**Эх нь аваад удалгүй идэв.**

**Эх нь өгүүлрүүн:**

**Энэ амтат мах идээд**

**Өвчин минь хөнгөн болов.**

**Эрдэмт сайн бэр минь**

**Бас буй бөгөөс идье.**

Бэр нь биеэ бөхийж хариу өгүүлрүүн: “Барав, мах үгүй билээ”. Эх нь уурлаад  
 харааж өгүүлрүүн:

Би өвчтэй хүн

Бядан мах гуйж авсан нэрийг

Бэлэн хоосноор хүлээж аваад

Бирд мэт бэр чи

Мах хулгай хийж идэх юув. Чиний мэт ачгүй бэрийг тэжээж юуны тус хэмээн  
 мод барьж элдээд ийн өгүүлрүүн: “Миний өвчин энэ мах идсээр харин эдгэрэв.  
 Миний хөвүүн одох цагт магад чамайг над ганцаар орхисны тул муу өшөө барив,  
 чи” хэмээгээд нарийн дээс авч хүлж элдэхэд төдий асрах Жэү өвгөн хаалгыг  
 нь өшиглөж орон, их дуугаар өгүүлрүүн: “Бэрийгээ ямар гэмд эрүүдэв?” хэмээн  
 асууваас эх нь өгүүлрүүн: “Тэжээсэн ачгүй хөвүүний тул санасаар даашгүй  
 өвчин олов, би” хэмээн бэрээ жанчсан шалтгааныг дэлгэрэнгүй өгүүлэв. Жэү  
 өвгөн өршөөх сэтгэл төрж, хүлсэн дээсийг тайлаад, зөвөөр явах Нарангэрэлийн  
 гараас хөтөлж, Жэү өвгөн гэртээ авч одоод асууруун: “Нарийн шулуун авирт авай  
 минь, чи мах хулгай хийж идсэн чинь үнэн үү?” Нарангэрэл нулимсаа асгаруулж  
 өгүүлрүүн:

Ээ өвгөн чи сонс!

Эр минь одсоор дөрвөн жил болов.

Эхийгээ тэжээхийн тулд

Өмссөн зүүснээ цөм худалдаж барав.

Эх минь гэнэт маханд дурласанд

Эдүгээ над аргагүйн тул

Өөрийн махнаас хэсгийг огтолж

Эхдээ идүүлэв би.



Иймийг үл мэдэн мах хомс хэмээн элдэнэ.  
Ил өгүүлбээс эхийн минь өвчин нэмэх болно  
хэмээн зовж эс өгүүлсэн тэр билээ. Энэ үгийг эхэд минь бүү өгүүл, ачит өвгөн  
минь”. Жэу өвгөн нулимсаа асгаруулан өгүүлрүүн:

Ай хөөрхий  
Ийм бодь сэтгэлт бэрийг  
Үүрд хулгайчид адил эрүүдэх юув?  
Эртнээс ачит нэрийг чихэнд сонссон билээ.  
Нүдээр үзсэнгүй билээ.  
Эрт Жансан нэрт хөвгүүн  
Эхийгээ өвдсөнд  
Загасны мах идье хэмээсэнд  
Жансан нэрт хөвүүн дээлээ тайлж

Мөсөн дээр хэвтэж загас эрэх цагт лусын хаад түүнийг ухаж нэгэн загас  
өгөв гэлээ. Тэр ачаар зуун үед хүртэл жаргав гэлээ. Бас Тайсун хаан эхийгээ  
өвдсөнд хулс мод тулж уйлсанд тэнгэр нар чин үнэнийг мэдэж сэтгэлийг  
нь гэгээн болгов гэлээ. Эвий, энэ чин сэтгэлийг чинь тэнгэр хайрлана биз  
хэмээн уйлаад Нарангэрэлийг эхийн дэргэд авч одоод ийн өгүүлрүүн:

Бэрийгээ ташаарч элдэв чи  
Бэрийн махыг идэж эс ханаад  
Бас ясыг нь идье гэж элдэв үү  
Барсан муу гүлтгэр гэж донгодов.

Эх нь өгүүлрүүн: “Тийм бөгөөс над хутга өгтүгэй. Бэрийн махыг огтолж үзье,  
би”. Жэу өвгөн бас харааж өгүүлрүүн “Чиний гарын махыг огтолжөө. Чи үл өвдөх  
үү?”. Эх нь өгүүлрүүн “Миний гарын мах огтолбоос өвдөх үнэн. Бэрийн махыг  
огтолбоос үл өвдөх буюу”. Жэу өвгөн өгүүлрүүн:

- “Бэрийн чинь чин зориг үнэний тул их нигүүлсэгчийн адистааар бэр чинь  
эс өвдсөн биз”. Эх нь бас хилэгнэж өгүүлрүүн: “Ай бэр чиний огтолсон ярыг би  
үзье” хэмээсэнд эрдэмт Нарангэрэл баруун гараа үзүүлбэл ил сорвигүйн тул эх  
нь их дуугаар инээгээд ийн өгүүлрүүн: “Чивэлт бэр минь чиний хуурсан худал  
буюу. Чин үнэн бөгөөс чиний огтолсон яр хааш одов? Бэр зүүн гараа үзүүлбээс  
яр нь үнэн аж. Эх нь үзээд бэрийгээ тэвэрч, цээж нь дүүрээд уйлж үл чадан амь  
нь гарав. Нарангэрэл эхийгээ татаж үзвээс амнаас хөөс гараад үхэв. Түүнээс  
нэг хэдэн сар барсны хойно Нарангэрэл “Эрийнхээ хойноос одсугай” хэмээгээд  
хааны хотод одохоор шийдэв.

Жэу өвгөн хариу өгүүлрүүн:  
Эрдэмт авай чиний одох зөв  
Эдүгээ гэр барааг чинь би хадгалъя.  
Энэ өчүүхэн мөнгийг авч одоод  
Өлсөх ундаасах цагт хүнсэл  
Зам явах цагт ихэд сэргэж явтугай.  
Ихэс мэт танхай хүнтэй ерөөсөө битгий ханил.  
Барсын цусыг зуурч болно.  
Барсын ясыг зуурахад бэрх гэлээ.  
Хүний царайг таньж болно.  
Хүний сэтгэлийг ухахад бэрх гэлээ.  
Хайран сайхан авирт чи минь

Ганцаар зорчих цаг чинь болов.  
Газар хол, шавар ус их  
Халуун хүйтэн их, явган яаж хүрнэ.  
Ачгүй Үнэнийг өгүүлэгч хөвүүнийг  
Алимад эд таваарын тул орж  
Ачит эхийгээ мартаад  
Асар ийм хилэнцэт хүнийг эс үзэв, би хэмээн уйлаад Нарангэрэлийг үдэж  
явуулав.

*Эх сурвалж: Дамдинсүрэн Ц. "Монголын уран зохиолын дээж зуун билиг оршив" УБ., 2001 он. "Цагаан дара эх" Төвд эхтэй харгуулж, монгол бичгээс хөрвүүлж, тайлбар хийсэн Д.Сумьяа. УБ., 2016*

### Үгийн тайлбар:

**Бирд** – Тогоон чинээн гэдэстэй, хялгас шиг нарийн хоолойтой, үргэлж идэж уухыг сэтгэлдээ шаналж байдаг ч хоолойгоор нь юм ордоггүй амьтан учир мөнхийн авах идэх шуналд шатаж байдаг гурван муу заяаны нэг

**Лус** – Буддын шашны ёсоор газар усны эзэн бөгөөд тэнд орших хүн бусын амьтан

**Донгодох** – зэмлэх, буруушаах

**Чивэлт** – нүгэлт

**Гүлтгэр** – хүлтгэр

**Огоот** – мартахгүй, огт, ер мартахгүй

**Бигэр** – алтны хэмжээ

1. Үнэнийг өгүүлэгчийн эх яагаад өвдсөн бэ?
2. Үнэнийг өгүүлэгчийн эх, эхнэр хоёр хэрхэн амьдарч байв?
3. Нарангэрэлийн эхийгээ өрөвдөж хайрласан сэтгэлийг ямар үйл явдлаар илрүүлж дүрсэлсэн бэ?
4. Эх нь юунаас болж Нарангэрэлийг үзэхгүйд хүрэв? Зөв байсан уу?
5. Жэү өвгөн Нарангэрэлд юу юу захив? Тэр ямар зан чанартай хүн бэ?



### УНШИХ

- Зохиолд, түшмэлийн шалгалт өгч хааны орд харшид алба хааж байгаа нөхрийнхөө эзгүй үед дутагдах гачигдахын зовлон туулж, хадам эхээ хүний дээдээр асран, бэрхийг даван туулсаар эцэстээ цэргийн жанжин болж, нөхрөө олж авч байгаа нэгэн үзүүрт сэтгэлтэй, журамт эхнэрийн тухай өгүүлдэг.
- Нигүүлсэнгүй сэтгэлийн эх булаг болсон дагины тухай голлон өгүүлсэн энэхүү тууж нь аман ба бичгийн уламжлалаар өргөн дэлгэрсэн зохиол учраас дэлгэрэнгүй хураангуй олон хувилбартай ажээ

### Зохиолын талаарх сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлье.

1. Зохиолоос хамгийн сайхан сэтгэгдэл төрүүлсэн дүр, үйл явдлыг ярина уу.
2. Нарангэрэлийн сэтгэл, бие хоёрын аль нь илүү өвдсөн бол?
3. Нарангэрэлд хандаж байгаа хадам эхийн харилцаанаас юу мэдрэв?
4. Кино зохиол бичихээр бол дүрүүдэд ямар хүнийг тоглуулмаар байна?
5. Үнэнийг өгүүлэгчтэй Нарангэрэл уулзах болов уу? Таамаглаарай.
6. 35 дугаар хуудас дахь зохиолоос тодруулсан хэсгийг уншихад чамд ямар сэтгэгдэл, мэдрэмж төрж байгааг ✓ гэж тэмдэглээрэй. Яагаад? гэдгийг баримтаар нотлон ярина уу. Энэ үйл явдлаар юуг илэрхийлж байгааг өөр өөрсдийн үзэл бодлоор илэрхийлээрэй.


айх	гайхах	уурлах	өрөвдөх	инээх	баясах	бахархах	үзэн ядах	өширхөх	хайрлах	түгших

**Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн уялдаа холбоог тодорхойлъё.**

1. Сэдэв, утга санааг хэрхэн тодорхойлсныг задлан шинжлээрэй. Зохиолоос жишээ татна уу.



2. Лүгэ ноёны дүрээр юуг илэрхийлснийг бодож, санаа бодлоо харилцан ярилцаарай. Ингэхдээ Лүгэ ноён



гэдгийг сайтар тунгаан бодоорой.

3. Нийгмийн хам сэдвийг хөндсөн болохыг батална уу.
4. Уншсан хэсгээсээ энэхүү журамт гэргийн хүнлэг нинжин сэтгэлийг харуулсан үйл явдлыг зохиолд өгүүлснээр нь жагсааж бичээд, дэлгэрүүлэн тайлбарлана уу.

Зохиолд өгүүлснээр	Тайлбарласан нь
а. Төдий эр эм хоёр маш хайрлалдан...	Үнэнийг өгүүлэгч, Нарангэрэл хоёр бие биедээ маш их хайртай (Нарангэрэл нөхөртөө чин сэтгэлээсээ хайртай)
б. ...эцэг эх хоёртоо их хүндлэлт ажгуу.	Хадам аав ээжээ Нарангэрэл ихэд хүндлэн хайрлаж, асарч халамжилдаг.....
в. ....	.....


**Өгүүлэгдэхүүн, зохиомжийн уялдаа холбоог шинжилье.**

1. Зохиолын өрнөл хэсэг дэх дүрүүдийн харилцан ярианаас зохиолын ямар утга тодорч байна вэ? Зөв харгалзуулаарай.

А. Жэу өвгөн, Нарангэрэл хоёрын яриа	А. Ард олны амьдрал ядуу зүдүү байсныг харуулсан утгатай
Б. Жэу өвгөн, Үнэнийг өгүүлэгч хоёрын яриа	Б. Эд агуурснаас илүү эрдэм ном сурах нь чухал болох тухай өгүүлсэн
В. Гау нэрт баян, Үнэнийг өгүүлэгч хоёрын яриа	В. Эрдмээс илүү цэг эхээ хайрлахын чухлыг дээдэлсэн утгатай.
Г. Нарангэрэл, эх хоёрын яриа	Г. Хүнийг танихын тухай сургасан утгатай

**Дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлъя. Зохиолын утга санаанд нөлөөлж байгааг дүгнэе.**

1. Онолын мэдээллийг уншаад, ойлгосноо бататгаарай.

 **ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО:**

Нийтлэг дүр гэдэг нь тухайн үеийн нийгмийн хүмүүсийн зан суртахууны нийтлэг шинжийг хадгалсан дүрийг хэлнэ.

Бодгаль дүр гэдэг нь хувь хүний давтагдашгүй зан чанар, бусдаас ялгагдах өвөрмөц шинжтэй дүрийг хэлнэ.

2. Нарангэрэлийн дүрийн тухай эргэцүүлнэ үү.

Бусад эмэгтэйчүүдэд байдаг нийтлэг ямар зан төрх илэрч байна вэ?

- а. ....
- б. ....
- в. .... гэх мэт тоочоорой.

Харин бусад эмэгтэйчүүдээс ялгарах дахин давтагдашгүй бодгаль ямар зан төрх, харилцаа хандлага илэрсэн бэ? Санал солилцоорой.

- а. ....
- б. ....
- в. .... гэх мэт тоочоорой.

3. Дүрүүдийн сэтгэл санааны байдлыг тэдний харилцан яриагаар зохиолд хэрхэн илэрхийлснийг сайтар ажиглаад, түүнийг илтгэх үгсийг зохиолоос онцлон тэмдэглэж, чамд энэ нь хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлаарай.

Эшлэл	Чамд үзүүлэх нөлөө
Гийсэн өвгөн асрах үнэн бөгөөс Хэв хэзээ эцэг минь чи болох буюу...	Жэу өвгөний Үнэнийг өгүүлэгчид хандан хэлж буй үгээс түүний тусч, энэрэнгүй сэтгэлийг, Үнэнийг өгүүлэгчийн сэтгэлийн баяр хөөрийг мэдэрсэн... <i>гэх мэт</i>

## ОНОРЕ ДӨ БАЛЬЗАК

(1799-1850)



Нэрт зохиолч Оноре дө Бальзак Францын Тур хотод эгэл жирийн тариачны гэр бүлд мэндэлжээ. Бальзак бага насаа хөдөө нутагт өнгөрүүлжээ. Түүний эцэг нь Францын хувьсгалын үед баяжсан бөгөөд хүүгээ сайн өмгөөлөгч болгох хүсэлтэй байв. Иймд эцгийнхээ хүссэнээр 1806 онд коллежид элссэн боловч залуу Бальзак ном унших их дуртай болж, номын амтанд орсоор өөрөө бичиж найруулдаг болж эхэлжээ. 1819 онд төр эрхийн сургуулийг төгсөөд хуулийн мэргэжилтэн болсон хэдий ч энэ ажлаа хийлгүй утга зохиолд амьдралаа зориулжээ.

Бальзакийн олон зохиол нь кино болж, үзэгчдийн хүртээл болжээ. Зохиол бичиж эхлэхийнхээ өмнө нийтлэлч, улс төрч, бизнесмэн, шүүмжлэгч болох гэж оролдож байсан боловч амжилтад хүрээгүй бөгөөд туулж өнгөрүүлсэн амьдрал нь түүний зохиол бүтээлд тусгалаа олсон байдаг.



### УНШИХЫН ӨМНӨ

- Бальзакийн “Эцэг Горио” зохиолыг та бүхний үе тэнгийн нэгэн сурагчийнуншаад бичсэн сэтгэгдлийг толилуулъя. Та нар зохиолтойгоо танилцсаны дараа өөр өөрсдийн бодол дүгнэлтээ бичээд, харьцуулан ярилцаарай.

*“Эцэг Горио”-д эцэг хүний энэрэнгүй сэтгэлийг өгцүлэхээс гадна тухайн үеийн Парисын амьдралыг дүрслэн харуулсан. Энд тэр үеийн Францын ахуй амьдрал, хүний оюун санааны ялзарсан байдлыг, хөрөнгө мөнгөнөөс болоод эцгээ энэрч хайрлахгүй байгаа хатуу сэтгэлт охидоор төлөөлцүлэн үзүүлжээ. Хайр гэдэг тэр дундаа эцэг эхийн хайр халмгийн эрхэм, тэр л хайр биднийг бусдыг хайрлахад сургадаг гэж би боддог.*

*Зохиолч Бальзак нь уг зохиолоороо Францын нийгмийг тийм ил тод биш ч хурцаар илүүмжилсэн байна. Үлэрээр, хүн гэдэг мөнгөнөөс, шуналаас болоод адгууснаас дор болдгийг үзүүлжээ.*

*Зохиолыг унших явцад бодол санаа, аливааг харах өнцөг олон болно. Зохиолд “Онч мэргэн үгс” гэмээр санамж, сургамж болмоор олон сайхан үг сургаал гардаг. Жишээ нь: Хүчхэд эцэг эхдээ хайргүй бол юм бүхэн нурна. Мунал гэдэг зүйл хүнийг араатнаас ч дор амьтан болгодог, үр хүчхдийг ч шилмэгч хорхой шиг болгодог”... гэх мэт.*

*Үнэхээр л, гэр бүлийн үнэ цэн гэдэг эцэг эх, үр хүчхдийн хоорондын харилцаа, хайраас ихээхэн халааралтай гэдэгт би бат итгэлтэй байдаг бөгөөд үүгээр л хүлүүцсийн хүлүүжил төлөвшдөг гэж бодож байна...*

*Үнийслэлийн нэгдүгээр сургуулийн 11а ангийн сурагч  
Золжаргалын Мягмардорж*



## ЭЦЭГ ГОРИО (туужийн хэсгээс)

Зохиолд гарах дүрүүд: Горио – Дельфина (хатагтай Нусенен), Анастаси (хатагтай Ресто) хоёр охины эцэг, Растиньяк – ядуу оюутан, Воке – дэн буудлын эзэн



Эх сурвалж: <http://www.pechora-cbs.ru/content/news/642/1005132417.jpg>

Энэ зохиолд Вокегийн ядуухан буудалд амьдардаг хөөрхийлэлтэй хүмүүсийн амьдрал болон Гориогийн хоёр охины амьдрал, дээдсийн хүрээлэнгийнхний тухай өгүүлнэ. Горио бол Францын хувьсгалын үед баяжсан, гоймонгийн үйлдвэрийн эзэн хүн. Охидоо нэр төртэй хадамд гаргаад, өөрөө зовж, хоосорч байгаа Гориогийн сүүлийн үеийн амьдралын тухай гарах бөгөөд хуримтлуулсан хамаг хөрөнгөө хоёр охиныхоо төлөө зарцуулсан хэдий ч охид нь дээдсийн хүрээлэнд байр сууриа алдахгүйн тулд өнгө мөнгөний хойноос хэт хөөцөлдөн эцгээ ч хайхрахгүй байгаа үйл явдал зохиолын гол агуулга юм.

Хүүхдүүд та бүхэн уг зохиолтой бүрэн эхээр нь танилцаж, жинхэнэ эцэг хүний мөн чанар, эцгээ хайрладаггүй хүний жигшим дотоод ертөнц зэргийг уншин, амьдралын их сургуулиас суралцана гэдэгт итгэж байна.

### Зохиолын эхлэлээс

Воке гэгч хижээлдүү бэлэвсэн авгай Парисын Нев-Сент-Женевьев гудамжнаа гэр бүлээрээ суух буудлын газрыг дөчин жил хэртэй эзэмшиж байгаа ажээ. “Вокегийн байшин” нэртэй тэр буудалд өвгөд, залуус, эрэгтэй, эмэгтэй ямар ч хүн ороход чөлөөтэй боловч тэрхүү эрхэм газрын зан заншил ямар нэгэн үг ярианд орж байгаагүй юм. Дэн буудал байх гудамжинд хамгийн амарлингуй хүн ч энд гунигт автагддаг байлаа. Тэрэгний түржигнэх чимээ чийртэй, байшингууд нь харахад гунигтай бөгөөд бөглүү, баргар өнгийн хана туурга нь гяндангийн байдлыг санагдуулна. Энд санамсаргүй ирсэн Парис хүн, гэр бүлийн буудал буюу сургуулийн амьдралын хөгжил дүүрэн боловч аргагүй хөдөлмөрлөх ёстой залуустай л тааралдахаас өөр юу ч олж харахгүй билээ. Парист түүнээс илүү аймшигтай, түүн шиг үл ажиглагдам хороо байхгүйг тэмдэглүүштэй. ... Гаслангаа барсан энэ улсын дунд ганцхан Воке л нийтэд зориулсан хувийн газартаа ноёрхож жаргалтай байлаа...

... Өвгөн Горио одоо 69 настай бөгөөд ажил хийхээ больсныхоо дараа 1813 онд хатагтай Вокегийн дэн буудалд ирж суух болжээ. Тэрээр одоо хатагтай Кутюрын суух болсон байранд суурьшиж, зуун франк илүү буюу дутуу төлөхийгөө юман чинээ санахгүй хүн шиг 1200 франк төлдөг байжээ. Гөлгөнүүр даавуун хөшиг, маажиндсан мод бүхий даавуун бүрээстэй түшлэгтэй сандал, нутгийн дэн буудлын эздийн голж хаясан цаас, хэдэн муусайн зураг бүхий тэр гурван тасалгаагаа хатагтай Воке бүрмөсөн шинээр сэлбэн засаж өгөөд, уг зүйлийн өртгийг урьдчилан авчээ. Ажил хэргээ орхисон ч өөрийгөө юугаар ч гачигдуулахыг хүсдэггүй арилжаа наймааны хүний хувьд Горио олон сайн хувцас хунар, зүйл бүрийн сайхан эд агуурсыг авчирчээ. Хатагтай Воке Голландын нарийн сайхан даавуугаар хийсэн 18 цамцыг үзээд гайхан биширч сүйд болсон бөгөөд том гэгчийн доржпалам чулуу бүхий

холбоогоор холбосон зүү хатгасан нь тэдгээр цамцны эдийн онц сайныг улам тодруулах мэт ажээ. Үйлдвэрийн эзэн түүнийгээ битүү зангидсан жабо дээрээ зүүдэг байв. Ерийн байдалд Горио цэнхэрлэсэн хөх өнгийн фрак өмсөж өдөр бүр цагаан даавуун хантааз солих ба цүдгэр гэдэснийх нь цүдгэнэхэд есөн бусын юмаар чимэглэсэн бүдүүн алтан холбоо санжганана. Тамхины сав нь хүртэл алт бөгөөд хүний сэтгэлийг шархлуулсан янаг сэтгэлийн ялалтыг нь илчлэх мэт хэсэг үс агуулсан зүүлт хадгалаастайг эзэгтэй авгай үзээд сэтгэл булаагч гэж нэрлэсэнд Горио сүрхий баярлаж, бэртэгчин хүний хөгжүүн инээмсэглэл уруул дээр нь тодорч билээ. Түүний шүүгээ нь урьдын аж ахуйгаас нь үлдсэн хоол ундны мөнгөн сав суулгаар пиг дүүрэн ажээ. Бэлэвсэн авгай тэр бүхнийг задалж эв дүйг олоход нь туслахдаа алт түрхмэл халбага, хоолны хэрэгсэл, том жижиг сав суулга, хэд хэдэн цар, иж бүрэн хийсэн нэлээд жинтэй, өвгөний хагацах дургүй тэр бүх юмыг үзээд шагшин гайхаж ихэд шохоорхжээ. Эдгээр бэлэг, айл гэр байх үеийн баясгалантай сайхан цагийг санагдуулна. –“Энэ бол бидний хуримын нэг жилийн ойгоор эхнэрийн минь өгсөн анхны бэлэг юм” гэж таган дээрээ үнсэлдэж байгаа хоёр тагтаатай бяцхан аяга, жижиг цар хоёрыг гартаа авч хатагтай Вокед үзүүлэн, “Хөөрхий хонгор минь үүнд охин байхдаа хуримтлуулсан юмаа зарцуулсан юм. Хатагтай Воке та сонсоно уу, энэ бүх юмнаас салахын оронд улаан гараараа газар ухсан минь дээр гэж боддог. Энэ аягаар би насаа бартал өглөө бүр кофе ууна. Надад гомдох юм алга, амь зуух юм нэлээд бий...” гэж хэлжээ. Хатагтай Воке, байсаар байгаад соргог харцаараа дансных нь том дэвтэрт байсан хэдэн тэмдэглэлийг үзэж амжаад, эрхэмсэг ноён Горио жил бүр наймаас арван мянга орчим орлоготой юм гэж мэдэж авчээ.

1. Горио ямар орчинд нүүж ирэв? Яагаад ийм дэн буудалд ирсэн бол? Таамаглаарай.
2. Гориогийн хэрэглэж байгаа эд зүйл нь юу илэрхийлж байна вэ?
3. Вокегийн тухай юу бодов?

### Зохиолын төгсгөлөөс

...- Би тавгүй муу байна, найран дээрээс буцах замдаа салхинд цохиулсан бололтой. Уушгины цусан хатгалга болох вий гэж айж байна. Тэгээд эмч ирэхийг хүлээж байна... гэж тэр хүүхнийг хэлэхэд нь: - Таны өмнө эрлэгийн элч ч ирээд байсан яаж ийж байгаад эцэгтээ очих ёстой. Тэр таныг ирээч гэж байна. Таны сонорт түүний хамгийн сулхан ёолох нь сонсогдвол л та өвчнөө даруй мартах санжээ гэж Растиньяк үгээ гүйцэд хэлэхийг нь хүлээлгүй үгийг нь тасалж хэлэв.

Эжен, миний эцэг таны хэлж байгаатай адил тийм их өвчтэй биш байж магадгүй боловч би ямар нэг талаар өчүүхэн ч болов танд гэж хэлэхэд буруутай гэж өөрийгөө үзнэ. Эцэг маань, хэрэв миний өвчин ингэж явснаас аюултай болж эргэвэл сэтгэлийн зовлонд унаж үхэх болно. Би түүнийг сайн мэдэж байна. За яая гэх вэ, би эмчээ ирэхийг хүлээгээд очъё. Үгүй, таны цаг чинь яасан бэ? гэж цагны нь холбоо байхгүй байгааг хараад асуув.

Эжен час улаан болов. - Эжен, Эжен! Хэрэв та түүнийг худалдсан юм уу гээгдүүлсэн бол таны зүгээс их эвгүй хэрэг шүү! гэсэнд окуутан, Дельфинагийн хэвтэж байсан орон дээгүүр нь бөхийж чихэнд нь:

- Та мэдэхийг хүсэж байна уу? Тэгвэл танай эцэг өнөө орой өөрт нь шаардагдах бие ороох цагаан даавуу ч худалдаж авах юмгүй байна шүү. Таны цагийг барьцаанд өгсөн. Надад өөр юу ч алга даа гэв.

Өвгөний охидын нэг нь ирнэ гэдэг мэдээг нас барах болсон өвгөнд хэлэх болсондоо баяртай явсан Эжен Нев-Сент-Женевьев гудамжинд бараг сэтгэл тайвширсан сайхан байдалтай ирээд нөгөө хөлсний тэрэгчинд хөлсийг нь өгөх гэж мөнгөний савыг нээсэнд тийм баян, тийм дэгжин хээнцэр залуу эмэгтэйд ердөө далхан франк байсныг үзэв.

Шат өөд гүйж гараад харсанд өвгөн Гориог Бьяншон түшиж, эмнэлгийн газрын бага эмч дэргэд нь бөхийж байгаа харагдлаа... Горио өвгөн: -Та юм мэдэж байна уу, ирнэ биз? – Тийм ээ, Дельфина миний хойноос ирж яваа гэж Эжен хариулав.

- За харав уу? Бас л охидынхоо тухай ярьж байна. Шор модонд өлгүүлсэн хүн ус ууя гэж гуйдгийн адил үргэлж охидоо л дуудаж байх юм гэж Бьяншон хэлэв... Бьяншон, бага эмч хоёр амь тавих гэж байгаа өвгөнийг нөгөө хиртэй бохир дэвсгэр дээр нь хэвтүүлэв. - Энэ хүний дотуур хувцсыг сольж өгвөл зүгээр юмсанжээ. Найдваргүй ч гэсэн, хүн гэсэн нэрийг нь эрхиш хүндэтгэх нь зүйтэй. Би дахиж ирнэ гэж Бьяншонд их эмч хэлээд, хэрэв дахин өвдөж байна гэвэл цээжийг нь хар тамхиар норгоорой гэж хэлсээр бага эмчтэйгээ гадагш гарлаа.

- За Эжен, зүрхээ барь хүү минь гэж Бьяншон, Растиньякт хоёулаа үлдэхдээ хэлээд, цэвэрхэн цамц өмсүүлээд ор дэрний нь даавууг сольё, чи Сильвияд очиж, орны даавуу авчраад бидэнд тусал гэж хэл гэв.

Эжен хоол иддэг өрөөнд бууж очсонд хатагтай Воке, Сильвия хоёр ширээгээ засаж, хоолны сав суулга өрж байв. Растиньякийг үг хэлж эхэлмэгц бэлэвсэн авгай хүнд итгэдэггүй, мөнгөө ч алдчих вий, худалдан авагчаа ч уурлуулчих вий гэсэн урвагар бөгөөд нялуун царайтай худалдаачин авгайн дүрээр Растиньякийн дэргэд хүрч ирээд: -Хайрт ноён Растиньяк аа, өвгөн Гориогийн өвөрт дахиж сохор зоос ч алга болсныг та надаас доргүй мэднэ шүү дээ. Хойд төрөлдөө очихыг завдан буй хүнд орны даавуу өгнө гэдэг, бас нас барсны нь хойно биеийг нь орооход бас нэгийг өгөх болохоор бүүр алдана гэсэн хэрэг шүү дээ...

Эжен нас барах гэж байгаа өвгөний дэргэд очоод түшиж байхад нь Бьяншон цамцыг нь тайлах гэсэнд өвгөн их өвчинд нэрвэгдсэн адгуус амьтан ёолж ёхолсон дуу гаргаж байгаа юм шиг тун гаслантай үл мэдэгдэх авиа гаргаж, цээжин дээрээ нэг юм тогтоож ядсан маягаар хөдөлсөнд Бьяншон “Аа энэ өвгөн маань бид сая нурууг нь төөнөж байхдаа хүзүүнээс нь мулталж авсан, үсээр хийсэн холбоотой бяцхан гууг эрж байгаа бололтой. Хөөрхий, түүнийг нь өгөх хэрэгтэй. Өнөөдөх нь задгай галын зуухан дээр байгаа” гэж хэлэв.

Эжен, өвгөний талийгаач эхнэрийн цагаан шар үсээр сүлжсэн бололтой холбоог авсанд уг гууны нэг талд нь “Анастази”, нөгөөд нь “Дельфина” гэж бичээстэй байв. Энэхүү сэтгэл зүрхний нь бэлгэ тэмдэг цээжинд нь хэзээд хамт явдаг байжээ. Тэнд байгаа хэсэг үс охидынх нь нялх багын үс бололтой. Тэр гууг цээжиндээ хүрэхийг барьж үзээд өвгөн урт гэгчийн санаа алдсан нь үнэхээр сэтгэл ханамжтай болсныг илтгэсэн боловч тэнд байсан хүмүүсийн яс хавтаймаар байлаа.

...Ийм байдалд тэр хэдэн цаг байгаад амь тавина. Тэр хоолойгоо ч дуугаргахгүй өнгөрнө. Уураг тархи нь зогсонги болсон бололтой. Яг тэр үед нэг их амьсгаадсан залуу эмэгтэйн алхаа шатан дээр сонсогдов. - Арай хожигдож дээ гэж Растиньяк хэлэв. Гэтэл тэр нь Дельфина биш тэдний аягачин хүүхэн Тереза байлаа... Ноён Горио нэгэнт ухаан алджээ. - Хөөрхий хайран хүн, юун зовлонтой хүн билээ гэж Тереза хэллээ. Тэр, шатны дээд хэсэг дээр Гүнгийн хатан дө Рестотой мөргөлдөх шахав. Гүнгийн хатан ирсэн явдал тун сүртэй бөгөөд аймшигтай байлаа. Тэр,

өчүүхэн ганцхан, сүүмэлзсэн лааны гэрэлд эцгийнхээ арай л амь тасраагүй царайг хараад ухаангүй уйлахад, Бьяншон аягүйрхэн холдов.

Хатагтай дө Ресто эцгийнхээ гарыг барьж үнсэж байхдаа... - Эцэг минь уучилж өршөөнө үү? Та миний дууг сонсоод булшнаасаа ч босно гэдэг байсан. Тийм бол агшин зуур ч буцаж ирж, нүглээ наманчилж байгаа охиндоо ивээл үзүүлнэ үү? Та намайг сонсооч! Яасан хэцүү юм бэ? Ганцхан та л намайг одоогоос хойш элбэрэн өршөөх сөн. Намайг бүгдээрээ үзэн ядах юм. Та л ганцаараа надад хайртай юм. Намайг өөртэйгөө авч явна уу? Би таныг халамжлан асарна... Намайг сонсож дуулахгүй байна... Би галзуурах нь... гээд сөгдөж унаад, амь тавьж байгаа хүн өөд галзуурсан хүний царайтайгаар ширтэн харав. - Би цаглашгүй их зовлонтой байна гээд Растињьяк өөд харж, -Ноён дө Трай асар их өр үлдээгээд далд орон зугтжээ. Бас би, тэр надад үнэнч биш байсныг мэдэв. Миний нөхөр намайг хэзээ ч уучилж хүлээхгүй. Би түүнд миний хөрөнгийг мэдэж байх эрхийг олголоо. Би ер нь сэтгэл хуурах юмгүй боллоо. Еэ бурхан минь, намайг гэж амь тавьж байсан ганцхан зүрхийг (эцэг рүүгээ зааж) би хэнээр солив оо? Би эцгээ хүлээж ойшоохгүй хэчнээн их зовлон учруулж байв, ээ бүү үзэгд. Хүний үнэргүй амьтан юм аа би! гэж хэллээ...

- Аав минь нас барчихлаа! гэж гүнгийн хатан бархирлаа.

Маргааш нь Бьяншон, Растињьяк хоёр арга буюу үд дундын үед нас барсан тухайг хотын захиргаанд очиж мэдэгдээд, баталгаа нь ч гарчээ. Бас дахин хоёр цаг өнгөрсөн боловч нэг ч хүргэн нь ирсэнгүй, мөн тэдний нэрийн өмнөөс ч хүн ирсэнгүйд Растињьяк нөгөө сахисан ламын барьцыг өөрөөсөө барив. Сильвия талийгаачийн цогцсыг угааж цэвэрлэн даавуунд боож ёслохын төлөө арван франк авна гэсэнд Эжен, Бьяншон хоёр талийгаачийн төрөл садан юунд ч оролцохгүй бол тэр хоёрын мөнгө бүх зардлыг нь дарж чадахгүй шахам юм байна гэж тооцоо гаргаад, эмч болох оюутан хүүрийг нь өөрөө ядуучуудын авсанд хийх болж, эмнэлгийн газраас хямд үнээр аваачуулахаар учрыг нь олж зохицуулав.

Эжен охидын гэрт нь ирсэн боловч хаалгаа тайлсангүй. Хүргэд болон охид нь чиний зарцуулсан зардлыг чинь нөхөж төлөхгүй гэвэл, булшны нь чулуун дээр: “Энд, хоёр оюутны зардлаар оршуулагдсан гүн дө Рестогийн хатагтай ба бээл дө Нусингений хатагтайн эцэг ноён Горио нойрсож байна” гэж бич гэв. Эжен Парисын ихсийн хэсэг хүрээг сайн мэддэг байсан учир орохыг шаардах нь дэмий гэдгийг ойлгов. Ийнхүү Дельфинагийн орж чадахгүй болсондоо сэтгэл зовсноос зүрх нь догдолжээ. “Танай эцгийг эцсийнх нь оронд төв төлөв үдэхийн тул ямар нэгэн гоёл чимэглэлээсээ худалдахгүй юу?” гэж хаалгачийн өрөөнд нь сууж бичив. Тэр, зурвасаа битүүлж эвхээд бээлийн хатагтайд Терезагаар дамжуулахыг хүссэн боловч хаалгач нь уг зурвасыг бээлд өгчихсөн тул бээл түүнийг галд хаяж орхижээ.

Бүх явдлын тушаал зааврыг өгөөд Эжен өдрийн гурван цагт буудлынхаа газар ирээд, хүнгүй хоосон гудамжнаа хоёр сандал дээр тавьж арай чарай хүрэлцэх төдий хар цэмбээр бүрхсэн авс гадна хаалганы дэргэд байхыг хараад, биеэ барьж чадалгүй нулимсаа асгаруулав. Хэн ч гар хүрээгүй хямдхан шавшуур багц, рашаантай мөнгөн царан дээр байв. Үүдийг нь ч хар цэмбээр бүрхсэнгүй байв. Энэ бол ядуу хоосон хүний сүр жавхлангүй үхэл бөгөөд ах дүү, амраг садангүй үхэл байв...

*Эх сурвалж: “Дэлхийн сонгодог утга зохиолын чуулган” тавин боть.  
Ред. Г. Аким. Орч. Д. Батсүх. УБ., 2009 он*

**Үгийн тайлбар:**

**Маажиндах** (мод) – тослогдсон мод

**Фрак** – эрэгтэй хүний европ өмсгөл

**Жабо** – хүзүүний алчууран зангиа

**Цар** – төмөрлөг зүйлээр хийсэн, дэлбэгэр том амсартай гялтгар том таваг

**Франк** – Францын мөнгөн тэмдэгт

**Доржпалам** – ихэвчлэн талст хэлбэртэй байдаг, өнгөгүй тунгалаг бөгөөд шар, ногоон, цэнхэр, хүрэн, улаан ягаан өнгөтэй, хамгийн үнэтэй, маш хатуу эрдэнийн чулуу

**Фабрик** – үйлдвэр

1. Эцэг Гориогийн нас барсан үеийг уншаад ямар сэтгэгдэл төрсөн бэ?
2. Түүний оршуулгын зардлыг хэн гаргав? Хэн гаргах ёстой байсан бэ?
3. Охин Дельфина, Эжений цаганд санаа зовдог. Охины дүрийг үнэлнэ үү. Тэр юунд санаа зовох ёстой байсан бэ?
4. Гүнгийн хатан дө Рестогийн гэр бүл нь түүнийг хуураагүй, хаяж яваагүй байсан бол эцэг дээрээ тэр ирэх байсан уу? Та нар юу гэж бодож байна?
5. Өвгөн амьсгал хураахын өмнө юу эрж, юу барьж, уртаар санаа алдсан бэ? Яагаад “хүмүүсийн яс хавтаймаар” гэж бичсэн бэ?
6. Зохиолч яагаад ийнхүү төгсгөв? Та нар юу ойлгов?
7. Та нар эцэг Гориог өрөвдөж байна уу? Эсвэл түүнд өөр зүйлийг хэлэх байсан уу?



**УНШИХ**

**Зохиолын талаарх сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлье.**

1. Зохиолоос юуг мэдрэснээ тулгуур үгээр бичиж, зохиолын үг хэллэгийг ашиглан ярилцаарай.

Зохиолоос юу мэдрэв?	Зохиолоос юуг харав?	Зохиолоос юуг сонсов?

2. Охидоо сайхан өсгөсөн эцэг, хөрөнгөжиж баяжсан эцэг хөлсний хямд байранд орсныг уншаад гайхаж байна уу? Яагаад зохиолч үйл явдлыг ингэж бичив? Зорилго нь юу байв?
3. Хоёр охины хийсэн үйлийг дахин уншаад, үзэл бодлоо илэрхийлээрэй.
4. Чи аав, ээжээ хэрхэн хайрладаг вэ? Тэднийхээ ач тусыг хариулах талаар юу гэж боддог вэ?

**Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн уялдаа холбоог тодорхойлъё.**

1. “Эцэг Горио” зохиолын сэдэв ба санааг тодорхойлж бичээрэй.



2. Зохиолын сэдэв ба санаа, түүний нэгдлийн талаар өөр өөрсдийн бичсэнээ тайлбарлаж, ярилцаарай.
3. Эцэг Гориогийн амьдрал, үзэл бодол, үйл хэргээр зохиолч ямар санаа гаргахыг зорьсон бэ?
4. Жинхэнэ сайн эцэг хүний тухай өгүүлэхээс гадна нийгмийн хам сэдэв хөндөгдсөнийг тодруулна уу. Нийгмийн ямар асуудлыг зохиолч хөндөв?
5. Түүний хоёр охины дүрийг өөр өөрсдийн үзэл бодлоор тайлбарлахдаа зохиолд дүрслэгдэж буй үеийн Францын нийгмийн амьдралыг өөрсдийн амьдарч байгаа өнөөгийн нийгэмтэй харьцуулаарай.
6. Бодит байдал дээр Гориогийн охид шиг хүмүүс байдаг болов уу? Өнөөгийн охид эцэг эхдээ хэрхэн ханддаг вэ? Баримт цуглуулан хэлэлцээрэй. Хэлэлцсэнээ дараах шалгуураар үнэлээрэй.

Шалгуур	Тийм	Үгүй	Сайжруулах шаардлагатай
Хэлэлцэхдээ баримт татсан уу? Баримт нь оновчтой байсан уу?			
Эцэг эхээ хайрлах асуудлыг хэлэлцсэн үү?			
Ээлж дараатай ярьсан уу?			
Бусдын хэлснээс тодруулж асуусан уу?			
Санаа бодлоо ойлгомжтой, соёлтой илэрхийлсэн үү?			
Хэлэлцүүлэгт идэвхтэй оролцсон уу?			

**Дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлъё. Зохиолын утга санаанд нөлөөлж байгааг дүгнэе.**

1. Гориогийн дүрийг судалж, асуултад хариулаарай.

Эцэг Гориогийн бодгаль ба нийтлэг шинж

- Гориогийн дүрээр эцэг хүний ямар нийтлэг талыг харуулсан бэ? .....
- Түүнд ямар өвөрмөц зан төрх илэрч байна вэ?.....

2. Гориогийн дүрийн боловсруулалт нь зохиолын утгад нөлөөлж байна уу? Дүгнээрэй.
3. Зохиолын дүрийг илэрхийлсэн гол гол үгсийг үйл явдлын дарааллаар бичнэ үү.

Дүр	Гадаад төрх		Дотоод шинж		Сэтгэгдэл
	Тулгуур үгээр	Зохиолын үгээр	Тулгуур үгээр	Зохиолын үгээр	
Горио					
Воке					

**Зохиолын гадаад ба дотоод орчныг шинжлэн, дүрийн зан төрхөд нөлөөлж байгааг үнэлье.**

1. Зохиолыг бүрэн эхээр нь уншаад, эцэг болон охидын харилцааны таатай, таагүй уур амьсгалын тухай ярилцаарай.
2. Хатагтай дө Ресто үнэхээр аавдаа хайртай болохоор ирсэн үү? Эсвэл амьдралынх нь нөхцөл байдал өөрчлөгдсөн болохоор ирсэн үү? Зохиолч ингэж бичсэнээрээ юу хэлэхийг хүсэж байна вэ?
3. Горио ямар орчинд насан эцэслэв? Тэр үеийн нөхцөл байдлыг зохиолч яаж дүрслэв? Гүйцээгээрэй.  
 Воке авгай даавуугаа харамласан.  
 Охин нь.....  
 Түшиг болж байгаа хүн охидоос өөр хүн байсан.  
 Горио охидоо.....
4. Онолын мэдээллийг уншин, дүрийн мөн чанарыг тодруулахад орчин нөхцөл хэрхэн нөлөөлж байгааг жишээ баримтаар нотлон тайлбарлаарай.

**•• 🧐 ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО: •••••**

Зан төрх бүрэлдэх орчин ахуйг нөхцөл байдал гэнэ. Баатруудын амьдрах тохиромжтой орчин, нөхцөл байдал гэж бий болгохгүйгээр уран дүрийн зан төрх бүрэлдэх, илрэх бололцоогүй. Нөхцөл байдал нь баатрын зан төрхийн өвөрмөц давтагдашгүй хэв шинж, тэдгээрийн хоорондын холбоо хамаарал, нийтлэг ба тусгайлаг шинжийг тодруулах орчин тойрны цогц орон зай, эд юмс юм.

**Зохиолын дүр дүрслэл, найруулгыг шинжилье.**

1. Сүүлчийн амьсгалаа хураахын өмнөхөн ч үр хүүхдээ гэсээр байгаа эцэг Гориогийн үйл хөдлөл, дүр дүрслэлийг зохиолд хэрхэн дүрслэв? Үүнийг зохиолч ямар үг, өгүүлбэрээр илэрхийлэн гаргасан бэ?
2. Зохиолын дүр дүрслэл, гол санаанд тохирох зүйр цэцэн үгийг олж ✓ гэж тэмдэглээрэй.

	Гориогийн том охин	Гориогийн бага охин	Эцэг Горио	Воке хатагтай
Зүйр цэцэн үг				

3. Охидынхоо тухай Эцэг Гориогийн ярьсан ярианд хэн, юу гэж хэлсэн бэ? Энэ хэсэгт юуг юутай адилтгасан бэ?

**Зохиолын хэл, үг сонголтыг судалцгаая.**

1. Уншсан хэсэгт Горио үг дуугарч байна уу? Түүний дүрийг зохиолч яаж бүтээв? Ажиглаад, дүгнээрэй.
2. Хоёр охиндоо хайртай эцэг хүн байна гэдгийг ямар үгээр илэрхийлсэн бэ?
3. Хоёр охины хэлж буй үгийг дахин уншиж, яагаад ингэж зохиосныг ярилцаарай. Зохиолч уншигчдад юу хэлэхийг хүссэн бэ?
4. Эцэг эхийн ач тус, үр хүүхдийн халамж хандлагын талаар өөрсдийн мэдэх бүтээлийн дүр, утга санаатай харьцуулж ярилцаарай. Жишээ нь: Эхийн ачийг хариулсан “Молон тойны намтар” –ын Молон тойн, “Лир ван” жүжгийн Эдмонд, “Гладиатор” киноны дүр... гэх мэт



### АЛЬФОНС ДОДЕ (1840 – 1897)

Францын зохиолч Альфонс Доде 1840 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Францын Наймес хотод төрсөн. Тэрээр 1897 оны 12 дугаар сарын 16-нд 57 насандаа Парист нас баржээ.

А.Доде олон жил багшилсан бөгөөд сургуулийн амьдралд өнгөрүүлсэн он жилүүдээ хожим зохиол бүтээлдээ тусгасан байдаг. Амьдралынхаа сүүлийн жилүүдэд багшлахаа больж сэтгүүлчээр ажиллажээ.

Түүний бичих, туурвих авьяасыг үр хүүхдүүд нь уламжлан авчээ. “Сүүлчийн хичээл” хэмээх өгүүллэг нь түүний амьдралтай салшгүй холбоотой.



#### УНШИХЫН ӨМНӨ

- “Сүүлчийн хичээл” гэхээр та нарт юу бодогдож байна вэ? Энэ зохиолд юуны тухай өгүүлсэн болохыг таамаглаарай.
- Эх орон, эх дэлхий, эх хэл, байгаль эх... гэж ярьдаг. Яагаад “эх” гэдэг үгийг эдгээр үгтэй холбодог юм бол? Энэ тухай санал бодлоо харилцан солилцоорой.

#### ОРЧУУЛГЫН ЗОХИОЛЫГ УНШИХДАА:

- Орчуулгын хэл найруулгыг нягтлан үзэх
- Монгол орчуулгын хэл найруулга нь монгол сэтгэхүйд хэрхэн тусаж байгааг анхаарах
- Орчуулагчийн найруулах ур чадвар, үг сонголт ямар нөлөөтэй талаар анхаарах
- Гадаад үг хэллэг, нэр томъёог сайн ажиглаж, нэр томъёоны толь хөтөлж, үгийн баялгаа нэмэгдүүлэх

### СҮҮЛЧИЙН ХИЧЭЭЛ (өгүүллэг)

Тэр нэгэн өглөө би хичээлээсээ дэндүү хожимдож, тэр тусмаа Амель багшийн, үйлт нэрийн тухай биднээс асууна гэсэнд, ганц ч үг мэдэхгүйдээ тун ч их айж байлаа. Агшин зуур хичээлдээ очихоо болиод, талаар гүйдэг ч юм уу гэж бодлоо. Тэр өглөө цэв цэлмэг, аагим халуун байсныг ч хэлэх үү. Модны заводын цаадах, германчуудын жагсаалын бэлтгэл хийдэг Ринерийн нугад болон ойн захаар



хөөндэйн жиргэх дуун сонсогдоно. Энэ бүхэн үйлт нэрийн дүрмээс илүү миний дур сэтгэлийг татаж байсан боловч би тэвчиж, сургууль руугаа гүйсэн дээ.

Хотын захиргааны өмнүүр өнгөрөхдөө зарлалын самбарын дэргэд олон хүн цугларсныг харав. Сүүлийн хоёр жил энэ самбараас дайны ялагдал, албадан авах, комендатын тушаал гээд л өөдтэй биш мэдээг дуулдаг сан. “Бас юу болчхоо юм бол доо?” гэж бодоод зогссон ч үгүй. Талбайг хөндлөн гараад гүйж явтал, шавьтайгаа хамт зарлал уншчихаад буцаж байгаа төмөрчин Вахтер над руу:

-Сургууль руугаа битгий яар хүү минь, яарсан яараагүй адилхан гэж хашхирав. Би, надаар тохуурхаж байна гэж бодон, Амель багшийн хашаа руу аахилсаар орлоо.

Уг нь хичээлийн эхэнд шуугьж, тэр нь гудамжинд дуулдан, сандалт ширээний тагийг түс тас хийлгэн, чихээ таглан, сайн цээжлэх гэж хичээлээ чанга дуугаар бүгдээрээ хамт уншиж, багш шугамаараа ширээ тогшин “Жаахан чимээгүй” гэж байдаг сан.

Би энэ шуугианы дундуур суудалдаа сэмхэн суучихна гэж бодож байсан чинь тэр өдөр бүр нам гүм, яг л бүтэн сайн өдрийн өглөө шиг байсан шүү. Нээлттэй цонхоор харсан чинь нөхөд маань суудалдаа суучихсан, Амель багш аймшигтай төмөр шугамаа бариад цааш нааш холхиж байлаа. Ийм их нам гүм байдлын дунд хаалга нээж орох хэрэгтэй болов. Миний минчийтлээ улайж, дагжин чичирч байсныг та нар бод л доо! Тэгтэл юу ч болсонгүй. Амель багш намайг дөлгөөхөн хараад намуухнаар: -Франц минь, суу л даа, хурдан суучих. Бид чамгүйгээр хичээлээ эхэлчихсэн гэж билээ.

Би урд сандлыг давж алхаад, суудалдаа хурдан суув. Тэгээд дотор жаахан уужрахаар, багшийнхаа гоёлын ногоон цахлай цамц, хуниастай зангиа, хар торгоор шагласан тоорцог өмссөн байхыг нь мэдлээ. Багш маань шагнал хүртэх буюу байцаагчийн ирэх өдөр л энэ хувцсаа өмсдөг юм л даа. Манай ангийнхан цөм нэг л ер бишийн, баяр ёслолын байдалтай байх шиг. Тэгтэл бас, ер нь хоосон байдаг хойд талын урт сандал дээр гурвалжин малгайт Хаузер хөгшин, хотын хуучин дарга, хуучин шуудан зөөгч болон бас бус хүмүүс яг л бидэн шиг чив чимээгүй сууж байхад нь би гайхав. Хаузер хөгшин булан нь урагдчихсан хуучин үсэглэл өвдөг дээрээ дэлгээд, нүдний том шил хийчихсэн харагдана.

Энэ бүхнийг гайхаж байх зуур Амель багш индэр лүүгээ очиж, намайг угтаж авсан шигээ намуухан буурьтай дуугаар: -Хүүхдүүд ээ, би та нартай сүүлчийнхээ хичээлийг хийж байна. Эльзас ба Лотарингийн сургуулиудад зөвхөн герман хэл заах шийдвэр Берлинээс ирсэн. Шинэ багш чинь маргааш ирнэ... Өнөөдөр франц хэлний сүүлчийн хичээл. Анхааралтай суухыг хүсье гэлээ.

Энэ хэдхэн үг намайг донсолгочхов. Аяа, шившигт этгээдүүд! Үүнийг л хотын захиргааны самбарт бичиж л дээ. Миний франц хэлний сүүлчийн хичээл!... Тэгтэл би дөнгөж бичиж сурч байдаг! Энэ чинь би хэзээ ч сурахгүй нь ээ. Ингэж цаашдаа амьдрах хэрэгтэй гэж үү?... Би цагийг дэмий өнгөрөөн, Саарын мөсөн дээр гулгах юм уу, шувууны үүр эрж хичээлээ тасалж байсандаа их харамсаж байлаа. Саяхан хүртэл надад уйтгар төрүүлэн, авч явахад хүнд юм шиг байсан хэлний зүй, ариун түүхийн ном маань одоо хуучин найз нөхөд шиг санагдаж, тэднээс хагацна гэхэд их хэцүү байсан сан.

Харин Амель багшийн тухайд бол, би дахиад багштайгаа тааралдахгүй гэж бодоход шугамаар цохиж шийтгэдэг байсан нь мартагдаж билээ.

Хөөрхий амьтан! Тэр сүүлчийн хичээлээ хүндэтгэн, ням гаргийн гоёлын хувцсаа

өмсчөж, манай тосгоны хөгшчүүд хүрч ирээд арын урт сандалд сууцгаасны учир юу болохыг би ойлголоо. Энэ сургуульд дахиад ирэхгүйдээ харамсаж байгаагаа илэрхийлж байгаа нь энэ болой. Энэ нь дөчин жил идэвх зүтгэлтэй ажилласан багшид талархсаны илэрхийлэл бөгөөд холдох гэж байгаа эх орондоо хүндэтгэл хийж буй нь энэ ажгуу.

Миний нэрийг дуудахад энэ тухай бодол минь тасрав. Хичээл хариулах ээлж минь болж, үйлт нэрийн өнөөх улигт дүрмийг чанга, тод, ганц ч алдаагүй хэлж би яаж чадах вэ. Би эхний үгээсээ л бантаж, ширээнийхээ ард уйтгарлан, хөлөө солбичоод, эгц харж зүрхлэхгүй зогсож байв. Амель багш надад: -Бяцхан Франц минь, би чамайг зэмлэхгүй, энэ чинь чиний шийтгэл л дээ... Маргааш давтана гэдэг, тэгээд эцэст нь юу болж байгааг харахгүй юу... Аяа, Эльзасынхан юм сурахыг дандаа маргааш гэж хойшлуулдаг нь туйлын харамсалтай хэрэг. Тэд, бидэнд: -"Төрөлх хэлээрээ бичиж ч, ярьж ч чадахгүй байж өөрийгөө франц хүн гэгцээнэ. Энэ чинь яаж болох вэ?" гэж хэлэх эрхтэй улс болж дээ... Иймээс Франц минь, чи ганцаараа буруутан биш. Бидэнд, юунд ингэв дээ гэж өөрсдийгөө зэмлэх юм цөмөөрөнд минь бий. Та нарын эцэг эх чинь, сурч боловсроход дэндүү нарийлж байна. Тэд, та нарыг тариалангийн талбай юм уу ээрэх машин руу явуулж, хэдэн сохор зоос олуулахыг л сонирхож байна. Миний хувьд, өөрийгөө зэмлэх юм байхгүй гэж үү? Би та нарыг хичээлээ давт гэж явуулахын оронд хааяа цэцэрлэгээ услуулж байсан биш үү? Хулд загас эргүүлээд явахдаа та нарыг чөлөөлж байсан биш үү?...

Чингэсээр Амель багш, франц хэлний тухай, франц хэлний яруу уянгалаг, хамгийн тогтвортой, дэлхийн хамгийн сайхан хэл болох хийгээд хайрлан хамгаалж, хэзээ ч мартаггүй байхыг зөвлөв. Учир нь, боолчлогдон дарлагдаж байгаа ард түмэн эх хэлээ эзэмшинэ гэдэг бол гяндангийн түлхүүрийг барьж байна гэсэн үг... Дараа нь Амель багш хэлний зүй тайлбарлаж, бидэнд бүх хичээлээ уншиж өгөв. Жигтэйхэн сайхан ойлгож байгаадаа би бүр гайхаж байлаа. Багшийн тайлбарлаж байгаа бүгд л тун ч амархан санагдлаа. Үнэндээ ч, би хэзээ ч ийм анхааралтай сонсож, багш маань ч ийм тэвчээртэй хэзээ ч тайлбарлаж байгаагүй л дээ. Хөөрхий өвгөн багш маань явахынхаа өмнө бүхий л мэддэг чаддагаа бидний толгойд нэгмөсөн хийчих санаатай шиг.

Хэл зүйн хичээлийн дараа бичгийн ажил эхлэв. Тэр өдөр Амель багш бидэнд шив шинэ жишээ бэлдэж ирээд "Франц, Эльзас, Франц, Эльзас" гэж их л эвтэйхэн бичжээ. Үүнийгээ ширээ бүрт хатгасан нь яг л дарцаг хэлхчихсэн юм шиг байлаа.



Хүн бүр л чив чимээгүй байхыг хичээн байсан сан. Цаасан дээр үзэг чахрахаас өөр дуу огт гараагүй. Анги дотор хаврын цох нисэж байгааг ч мэдэхгүй, бүгд л жаахан хүүхдүүд ч гэсэн бийрээ чамбайхан барьчаад, хичээнгүйлэн бичиж байгаа нь аргагүй л франц хэлний хичээл ажгуу...

Байшингийн дээвэр дээр тагтаа аяархан гөвтнөлдөх нь дуулдахад би өөрөөсөө: - Энэ тагтаануудыг бас германаар ярь гэж албадах болов уу? гэж асуулаа.

Үе үе цааснаасаа нүд салган Амель багшийг харахад, эргэн тойрныг ажиглан, сургуулийн жижигхэн байшингаа дурсаж, индрийнхээ дэргэд хөдлөхгүй суух ажээ. Бод л доо! Дөчин жил энэ л ангид, энэ хашаанд суулаа шүү дээ, тэр. Зөвхөн сандал ширээ нь л элэгдэж хуучирсаар гөлгөр болчхож, хашаан доторх туулайн бөөрний моднууд томорч, зөрөг цэцэг нь одоо цонх, байшингийн дээвэр хүртэл хэржээ. Хөөрхий энэ хөгшинд энэ бүхнийг орхиод явах хэчнээн хэцүү байсан гээч... Дээд давхарт ... эгч нь аяны хайрцгаа хааж байгаа чимээ сонсогдоно. Эд маргааш энэ нутгийг үүрд орхин одох аж. Тэгсэн ч гэсэн Амель багш, бидэнтэй хичээлээ дуустал хийхээр зоригложээ. Бичгийн ажлын дараа түүхийн хичээл оров. Сүүлд нь хүүхдүүд: Ба, Бе, Би, Бо, Бу гэж бүгдээрээ уншлаа. Арын сандалд сууж байсан Хаузер хөгшин нүдний шилээ зүүчхээд, үсэглэлээ гартаа барьж, хүүхдүүдтэй хамт уншиж байв. Сэтгэл нь хөдөлсөндөө хоолой нь чичирчхэж, түүнийг сонсоход бид бүгдээрээ уйлмаар ч, инээмээр ч байлаа.

Үгүй шүү! Би энэ сүүлчийн хичээлийг мартажгүй...

Тэгтэл үд дунд болж, ханын цаг цохилон, мөргөлийн хонх дуугарав. Тэр агшинд бэлтгэлээсээ буцаж яваа герман цэргийн цуваа цонхны дэргэдүүр өнгөрлөө. Амель багш царай нь барсхийн суудлаасаа босов. Багш маань хэзээ ч ийм тод санагдаж байгаагүй сэн. - Найз нөхөд минь гэж хэлснээ, найз нөхөд минь, би... би... гэсээр юм хэлж чадсангүй. Тэгснээ самбар луу эргэн, цэрд авч, байдаг хүчээ шавхан, том үсгээр: “Франц мандтугай!” гэж бичив. Тэгээд толгойгоо хананд наан, хөдлөхгүй зогсож, юу ч хэлэлгүй гараараа: - “Одоо дууссан... явцгаа...” гэж дохиж билээ.

*Эх сурвалж: Францын шилдэг өгүүллэгүүд. Эмхэтгэсэн. Алтангүл.Б, Орч. Ц.Сүхбаатар. УБ., 2009 он*



## УНШИХ

### Зохиолын талаарх сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлье.

1. Та нар энэ зохиолыг уншиж байхдаа догдолсон уу? Сэтгэл чинь хэр хөдлөв? Аль хэсэг дээр юу мэдрэгдэв?
2. Ямар нөхцөл байдал дунд сүүлчийн хичээл оров?
3. Сүүлчийн хичээлд хэн хэн суув? Яагаад тэр хүмүүс хичээлд суув?
4. “Би баатар” юунд харамсав? Тэр юу юу бодов? Сүүлчийн хичээл түүнд ямар санагдав?
5. Тэр Амель багшийнхаа тухай юу бодов? Тэр багшдаа хайртай юу?
6. Хэрвээ чи франц хэлний сүүлчийн энэ хичээлд суусан бол чамд ямар санагдах байсан бол? Энэ тухай баг дотроо ярилцаарай.

Багаар ажиллахдаа

- Амель багшийн шавь нартаа хандаж хэлсэн үгийг дахин уншина уу.
- Баг багийн төлөөлөл нэг сурагч тайлбарлан ярихдаа зохиолын үг хэллэгийг ашиглан ярина уу. Багийн шийдвэрийг танилцуулсан хүүхдүүдээс бусад



	Ямар орчин, нөхцөл байдал дүрслэгдэж байна вэ?	Хүүгийн зан чанар, үйл хэргийн өөрчлөлтийг ажиглаад тэмдэглэнэ үү.
Эхлэл хэсэгт		
Гол хэсэгт		
Төгсгөл хэсэгт		

3. Дүрийн үзэл бодол ингэж өөрчлөгдсөн нь орчин, нөхцөл байдалтай холбоотой юу?
4. Ангийн сурагчид сүүлчийн хичээл дээр ямар нөхцөл байдалтай байгааг зураглан ярихдаа багш сурагчдын харилцааны уур амьсгалыг хэрхэн мэдэрч байгаагаа жишээ баримтаар тайлбарлан яриарай.
  - а. “Би баатар” хоцорч байх үеийн харилцаа.....
  - б. “Герман хэл заах шийдвэр Берлинээс ирсэн. Шинэ багш маргааш ирнэ” гэж хэлэх үеийн нөхцөл байдал дахь харилцаа.....
  - в. “Би баатар”-ын багшийн асуултад хариулах үеийн харилцаа.....

#### Зохиолын дүр дүрслэл, найруулгыг шинжилье.

1. Найруулга нь сэтгэл хөдлөлд хэрхэн нөлөөлж байна вэ? Тухайлбал: гуниглах, харамсах шинжийг тодруулсан хэсгийг олж бичээд, тайлбарлан ярилцана уу.
2. “Франц мандтугай!” гэж самбарт бичиж байгаа Амель багшийн, биеийн болон сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлэхдээ ямар үг хэллэгийг зохиолч сонгож, утга санааг тодруулсан бэ?
3. “Франц, Эльзас, Франц, Эльзас” гэж их л эвтэйхэн бичжээ. Үүнийгээ ширээ бүрт хатгасан нь яг л дарцаг хэлхчихсэн юм шиг байлаа” гэсэн хэсгийн уран сайхныг мэдэрч дахин уншаарай. Яагаад “дарцаг хэлхчихсэн юм шиг” гэж бичсэн бэ? Юуг юутай адилтгасан бэ?
4. Бидний үед эх хэлээ хэрхэн хайрлаж байна вэ? Төрөлх монгол хэлээрээ бичиж, ярихгүй байгаа жишээ баримт цуглуулан, асуудал дэвшүүлсэн эсээ бичнэ үү. Эсээгээ монгол хэлний хичээлээр судлах шалгуурын дагуу бичиж, туршаарай.

#### Зохиолын хэл, үг сонголтыг судалцгаая.

1. Амель багшийн эх хэлээ, эх орноо гэсэн сэтгэлтэйг харуулахдаа зохиолч ямар үг сонгон хэрэглэсэн бэ?
2. Сэтгэл хөдөлгөсөн, буруушаасан, зэмлэсэн, харамссан, эргэцүүлж ухаарсан ямар ямар үг хэллэг зохиолд байгааг түүвэрлэн бичиж, ярилцана уу.
3. “Энэ тагтаануудыг бас германаар ярь гэж албадах байх даа” гэж бодож байгаа “би баатар”-ын бодлоос юуг мэдэрч байна вэ?
4. Хүүд гүн сэтгэгдэл төрүүлсэн зүйл юу вэ? Зохиогчийн хэрэглэсэн үгсээс жишээ татна уу.



## АНТОН ПАВЛОВИЧ ЧЕХОВ (1860-1904)



Антон Павлович Чехов нь Оросын богино өгүүллэг болон жүжгийн нэрт зохиолч юм.

Тэрээр өмнөд Оросын Таганрогт 1860 оны 1 сарын 29-нд төрсөн. 1879 онд дунд сургуулиа төгсөж, Москвагийн Их сургуулийн Анагаах ухааны ангид элсэн оржээ. Энэ үеэс л Антоша Чехонте хэмээх нууц нэрээр богино хошин өгүүллэгүүд бичиж сэтгүүлд хэвлүүлж эхэлжээ.

Чехов мөн эмчээр ажилладаг байлаа.

1896 онд «Цахлай» хэмээх жүжгийн зохиолоо бичиж Санкт-Петербургийн Александрын драмын театрт тоглосон боловч амжилтад хүрээгүй тухай Оросын драмын жүжгийн түүхэнд тэмдэглэжээ. Харин хоёр жилийн дараа Москвагийн драмын театрт тоглосноор Чехов олон нийтэд алдаршив. 1899 онд Ялтад нүүн суурьшиж, энд «Нохой дагуулсан эзэгтэй» өгүүллэг, мөн 1899 онд Москвагийн драмын театрт тоглосон «Нагац ах Ваня», 1901 онд анхлан үзэгчдийн хүртээл болсон «Эгч дүү гурав» зэрэг жүжгийн зохиолоо туурвижээ.

Тэрээр богинохон амьдралдаа дөрвөн сонгодог зохиол болон зохиолч, шүүмжлэгч, уншигчдын хүндэтгэлийг хүлээсэн олон богино өгүүллэг бичсэн.



### Үгийн тайлбар:

**Хамелеон** – Африк тивд байдаг, ногоовтор өнгөтэй боловч орчны байдал дагаж өнгө нь хурдан хувирдаг, гүрвэлийн төрлийн амьтан

**Пин** – юм агуулах, хадгалах нарийн биш хийцтэй жижиг байшин, амбаар

**Хамжаар** – хүрэм цамц

**Зээл** – Зохиолд зах зээлийн газар гэдэг утгаар оржээ.

**Тошлог** – исгэлэн жимс, мөн ийм жимсгэнэтэй өргөстэй жижгэвтэр бут

## ХАМЕЛЕОН (өгүүллэг)

Цагдан байцаагч түшмэл Очумелов шинэ шинель өмсөөд гартаа боодолтой юм барьж, хотын зээлээр явж байна. Түүний хойноос шар царайтай цагдаа торгуульд хураасан тошлог жимсээр дүүргэсэн сагс барин дагалдана. Орчинд чимээ аниргүй ба зээлийн чөлөөгөөр нэг ч амьтан үзэгдэхгүй, үүдний хажуугаар гуйранчид ч харагдахгүй, дэлгүүр гуанзнуудын үүд өлсгөлөн араатны ам шиг ангайлдан байна.

Гэнэт “Бузар золиг, тэгж хаздаг буюу. Бариаарай, бариаарай. Одоо хүнийг зуух гэдэг хориотой биш үү?” гэж бархирах чимээ гарч, нохой гаслах сонсогдов. Очумелов эргэж харвал худалдаачин Пичугиний түлээний пингээс нэгэн доголон нохой гэдрэг харан харан зугтах ба түүний хойноос дотоод хамжаарын товчийг задгай тавьсан, цардмал даавуу цамцтай хүн хөөж явав. Тэр хүн нохойг хөөн гүйцэж, ухасхийн хойд хоёр хөлөөс шүүрэн баримагц газар уналаа.

...Төдөлгүй түлээний пингийн дэргэд газраас гэнэт ургах мэт олон хүн цугларав.

- Эрхэм түшмэл ээ, энэ бусчир явдлыг харав уу? гэж цагдаа хэлэхэд Очумелов хагас эргэж, цугларсан хүмүүсийн зүг алхлаа. Очиж үзвэл пингийн үүдний дэргэд хамжаараа задгай тавьсан өнөөх хүн баруун гараа дээш өргөж, цустай хуруугаа олонд үзүүлэн байв. Түүний хагас согтуу царайд хорсол илэрхий... Очумелов түүнийг ажиглавал, алтны дархан Хрюкин мөн аж. Тэдний дунд будлиан гаргасан, ууцан дээгүүрээ шар толботой, шөвгөр хоншоортой цагаан гөлгөн нохой бүх бие нь дагжин чичирч цогнойн сууна. Түүний нулимст нүдэнд айсан шинж илэрхий.

Очумелов олны дунд зүсэж ороод асуулаа.

- Ямар юм болов? Чиний хурууг яасан бэ? Хэн юу гэж бархирав?

- Эрхэм түшмэл ээ, би хэнд ч халдсангүй. Энгийн явж байтал гэж Хрюкин алгандаа ханиан хэлсэн нь: - Митрий Митричийн түлээний тухай явтал гэнэт энэ муу гөлөг учиргүй дайраад хуруу хазав. Та намайг өршөөж үз. Би энэ хуруугаар долоо хоногт хямд бус ажлыг бүтээж чадах тул надад төлж өгвөл зохино. Эрхэм түшмэл хянана уу. Ийм улианаас зовлон хүлээх хууль байна уу? Нохой бүр зуумхай бол ертөнцөд амьдрах аргагүй.

Очумелов: - Хм гэж ширүүн ханиаж, хөмсгөө хөдөлгөн хэлэх нь:

- За мэдлээ. Хэний нохой вэ? Би үүнийг зүгээр орхихгүй. Нохойгоо сул тэнүүлбэл юу болохыг би та нарт үзүүлэе. Би үүнийг ингээд зүгээр орхихгүй. Тогтоол дүрмийг хайхрахгүй ийм эрхмүүдийг анхааралдаа авах цаг болсон шүү. Нэг сайн торгоод авбал ийм жигшилтэй этгээд нохой ба зайгуул малаа дэмий тэнүүлбэл юу болохын учрыг сая мэдэх болно. Елдырин! гэж цагдааг дуудаж,

- Хэний нохой болохыг тогтоо. Тэгээд энэ нохойг үгүй хийх хэрэгтэй. Битгий хойшлуул. Энэ галзуу нохой ч байж болно. Хэний нохой вэ? гэж асуувал олны дундаас нэг хүн:

- Энэ генерал Жигаловын нохой бололтой гэж хэллээ. Цагдан байцаагч хэлэх нь:

- Энэ генерал Жигаловын нохой юу? Хм. Елдырин, чи миний пальтог тайлж ав. Ямар халуун юм бэ? Мөдхөн бороо орох гэж байгаа биз ээ. Ганцхан би нэг зүйлийн учрыг олохгүй байна гээд Очумелов Хрюкиныг харж хэлэх нь:

- Энэ нохой яагаад чамайг зууж чадсан юм бэ? Энэ чиний хуруунд хүрч хазсан гэж үү? Нохой ийм жаахан, чи ийм том эр, чи гараа лав хадаасанд ураад дараа нь худал хэлье гэж санаанд чинь орсон биз. Чи бол... Та нар мэдэхгүй биш, та шуламнуудын занг мэдэж байна гэтэл олны дундаас нэг нь:

- Эрхэм түшмэл ээ, энэ өөрөө инээдэм гаргахын тул тамхины гал хамарт нь хүргэтэл тэр гөлөг тэнэг биш тул хазсан биз ээ. Эрхэм түшмэл ээ, энэ алиа хүн шүү гэхэд Хрюкин:

- Хялар гайхал, чи битгий худал хэл. Харсангүй байж юунд худал хэлнэ вэ? Эрхэм түшмэл ухаантай хүн тул хэн нэгэн худал хэлж байгааг, хэн тэнгэрийн өмнө шударгаар үнэн үг хэлж байгааг мэднэ. Хэрэв би худал хэлсэн бол даруй шүүхэд аваачиж таслуул. Хууль дүрэм гэж байна. Одоо бүгд адил эрхтэй, миний ах цагдан хянах ажилтай. Хэрэв мэдье гэвэл...

Цагдан байцаагч:

- За битгий нуршаад бай.

- Үгүй энэ чинь генералын нохой биш, генералынд ийм нохой байхгүй. Тэдний ноход их төлөв хав нохой байдаг сан гэж их бодлогоширсон байдлаар хэллээ.

- Чи лав мэдэж байна уу?

- За за, би өөрөө мэдэж байна. Генералын нохой цөм сайн үүлдрийн үнэтэй ноход. Гэтэл энэ бол ийм өөдгүй, үс ч үгүй, зүс ч муутай, жигшмээр амьтан. Ийм нохойн оронцгийг ямар хүн авч байдаг юм бэ? Ийм нохой Петербург, Москва зэргийн их хотод тохиолдвол яах бол? Хуулийн бичиг үзэх ч үгүй, тэр дор нь амьсгалгүй болгоно. Хрюкин чи, хазуулсан хүн энэ хэргийг битгий орхи. Сургамж үзүүлэх хэрэгтэй цаг нь болсон.

Цагдаа санаснаа ил гаргаж хэлэх нь:

- Генералын нохой ч байж болох, хоншоор дээрээ бичиггүй юмыг хэн мэдэх вэ? Саяхан гадаа нь үүн шиг нохой үзэгдсэн. Бас олны дундаас нэг дуу сонсогдох нь:

- Магад генералын нохой мөн.

- Хамрелдва, чи пальтог минь өмсгө. Салхи сэнгэнээд байх шиг байна. Чи үүнийг генералынд аваачаад асуу. Намайг олоод илгээв гэж хэл. Гудамжинд битгий гаргаарай гэж хэл. Энэ үнэтэй цайтай ч нохой байж мэднэ. Хэрэв энэ гахайнууд тус бүр тамхины галаар хайрвал сүйд хийхэд холгүй. Нохой гэгч хэврэг амьтан. Аа, чи алиа гайхал гараа буулга. Хуруугаа дэмий гозгонуулах хэрэггүй. Чи өөрөө буруутай.

- Генералын тогооч явж байна, түүнээс асууя.

- Ай, Прохор наашаа ир. Энэ нохойг үз. Танай нохой мөн үү?

- Юун дэмий үг вэ? Манайд ер нохой байгаагүй гэхэд Очумелов хэлсэн нь:

- Олон үг асуух хэрэг огт байхгүй. Энэ золбин нохой мөн. Удтал ярих хэрэг ч үгүй. Хэрэв золбин нохой бол алах хэрэгтэй. Ондoo явдалгүй.

Тогооч Прохор үргэлжлүүлэн хэлэх нь:

- Энэ манай нохой биш, манай генералын дүүгийн нохой. Дүү нь саяхан ирсэн юм. Манай генерал ийм тайган нохойд дургүй. Гэтэл дүү нь их дуртай юм.

- Ээ, дүү нь ирсэн юм уу? Владимир Иванович үү? гэж Очумелов асуугаад бүх нүүр нь тааламж мишээлээр дүүрч,

- Ээш, тэнгэр минь. Би мэдээгүй байлаа, айлчилж ирээ юу?

- Тийм ээ, айлчилж ирсэн.

- Ээш тэнгэр минь, ахыгаа санаад ирж л дээ. Би мэдээгүй шүү. Тэгээд энэ тэдний нохой юу? За сайн хэрэг. Аваад яв. Зүгээр нохой байна. Сэргэлэн нохой. Үүний хурууг тавхийтэл хазсан байна. Хээ, хээ, юунд чичрээд байна вэ? Дрр, ррр, уур нь хүрч байна, гайхал чамайг.

Прохор нохойг дуудаж дагуулан түлээний пингээс холдов. Цугларсан хүмүүс



Хрюкинийг элэглэн инээлдэнэ. Байз, “Сайхан мэдээрэй” гэж түүнийг Очумелов занаад шинелээ яаран өмсөж, зээлийн чөлөөгөөр цааш явлаа.

Эх сурвалж: Цоодол, Д. Түүвэр зохиол. 4 дүгээр боть.  
Орч. Цоодол, Д., УБ., 2015 он. 150 дугаар тал



Эх сурвалж: Внеклассное чтение (Для среднего школьного возраста)  
Москва., 2007. стр 39, 42.

“Хамелеон”, зураач Владимир Юрьевич Черноглазов

### Утга зохиолын онолын мэдлэгээ сайжруулъя.

1. Онолын мэдээллийг уншаад юу ойлгосноо задалж, ярилцаарай.
2. Онолын мэдээлэл дээр тулгуурлан, сорил зохиож, мэдлэгээ сорьцгооно уу.



**ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁО:**

**Хошигнох аргууд**

Зан төрхийн хошигнол. Баатруудын зан төрх бол мөн ялгаагүй хошигнолын эх булаг болдог. Нэг хэсэг нь алиалж наргиж, нөгөө хэсэг нь гэнэн тэнэгээрээ хүний инээд хүргэж байдаг. Жишээ нь: Дээрх өгүүллэгт, хамелеон адил хувирах Очумеловын зан төрхөөр хошигнол бүтээжээ.

**Уран сайхны дүр**

Хүний амьдрал хэчнээн бодитой, сонирхолтой байдаг ч түүний мөн чанарыг бүрэн гүйцэд таньж мэдэж чаддаггүй. Харин түүнийг зөвхөн уран сайхны дүрээр нээн үзүүлэх боломжтой. Өөрөөр хэлбэл, бодит хүмүүст байгаа болоод байж болох зан чанарыг зохиолч зохиол бүтээлдээ урлан шингээж, дүрслэн амьдруулсныг уран сайхны дүр гэнэ. Жишээ нь: А.П.Чеховын “Хамелеон” өгүүллэгийн байцаагч түшмэл Очумеловын дүр бол өөрийн үзэл бодолгүй, бялдууч хүний хэв шинжит дүр юм.

**Зохиолын талаарх сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлье.**

1. Өгүүллэгийг уншаад таалагдаагүй дүр байна уу? Яагаад таалагдаагүй болохыг жишээгээр батална уу.
2. “- *Елдырин, чи миний пальтог тайлж ав. Ямар халуун юм бэ? Мөдхөн бороо орох гэж байгаа биз ээ... - Хамрелдва, чи пальтог минь өмсгөө. Салхи сэнгэнээд байх шиг байна...*” Эдгээр өгүүлбэр өгүүллэгт ямар үүрэгтэй орсон байна вэ? Үзэл бодлоо илэрхийлээрэй.
3. Хэрвээ чи энэ баатруудын хажууд байсан бол ямар шийдвэр гаргах байсан бэ?
4. Зохиолоос инээдтэй бас бодууштай хэсгийг түүвэрлээрэй. Яагаад инээдтэй бас бодууштай гэж үзэж байна вэ?

**Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн уялдаа холбоог тодорхойлъё.**

1. Нийгмийн асуудлыг илүү хөндсөн байна уу? Эсвэл хувь хүний харилцааны асуудлыг хөндсөн байна уу? Жишээгээр батлан мэтгэлцээрэй.
2. Мэтгэлцэх чадвараа үнэлээрэй.

	Тийм	Үгүй	Сайжруулах шаардлагатай. Яаж гэдгээ бичээрэй.
Асуудлыг олж дэвшүүлж чадаж байна уу?			
Дэвшүүлсэн асуудлаа жишээгээр баталж чадсан уу?			
Бусдын саналыг олон талаас нь эргэцүүлж чадсан уу?			
Бусдын үзэл бодол хүндэтгэлтэй хандсан уу?			
Ярьсан зүйлдээ итгэл үнэмшилтэй байна уу?			

**Зохиолын дотоод орчныг тодруулж, дүрд хэрхэн нөлөөлснийг тодорхойлъё.**

1. Зохиол дахь эхний нөхцөл байдлаас хойш өөр ямар нөхцөл байдал үүссэнийг гүйцээн жагсаан бичнэ үү.
  - а. Түшмэлийн араас цагдаа торгуульд хураасан жимсээр дүүрэн сагс барин дагалдана.

б. Нохойд хазуулсан хүн гарч ирсэн

в. ....

г. ....

2. Зохиолч ямар зорилгоор ийм нөхцөл байдлуудыг үүсгэв? Хэнийг шүүмжлэх зорилго тавив?
3. Очумелов хэдэн янзаар хувирав? Тухай бүрийн нөхцөл байдал нь түүний зан төрхөд нөлөөлж байна уу?
4. Баатруудын хоорондох харилцааг хэр мэдрэв? Очумеловын зан байдал өөрчлөгдсөн нь юутай холбоотой вэ? Зөвийг тэмдэглэнэ үү.
  - Өөрийн төрөлхийн зан байдалтай холбоотой
  - Генералын нохой байсантай холбоотой
  - Жирийн хүнийг дорд үздэг түшмэлийн зантай холбоотой
  - Хамелеон амьтантай адилхан болохоороо

**Зохиолын дүр дүрслэл, хэлний онцлог, үг сонголтыг судалж шинжилье.**

1. Өөрөөсөө дээш албан тушаалтанд тал засдаг хүнийг дүрслэхийн тулд ямар үг, өгүүлбэр хэрэглэсэн байна вэ?
2. Нохойг сонгож авсны учир юу вэ? Очумелов хэнийг нохойноос дорд үзэв? Зохиолчийн зорилго юу байв?
3. Очумеловыг хамелеон шиг болгосон үгийг зохиолоос сонгоно уу. Зохиолч уншигчдад юу илэрхийлэхийг хүсэж ийм нөхцөл байдал үүсгэв?
4. Зохиолыг шог болгож байгаа үг, өгүүлбэрийг сонгоно уу. Яагаад шог гэж үзэж байна вэ? Онолоос суралцаад, үндэслэлтэй тайлбар хийгээрэй.

👉 **ТҮЛХҮҮР НЭР ТОМЬЁ:** . . . . .

Хүн, нийгмийн элдэв гажуудал, дутагдлыг инээдэмт өнгө аясаар шүүмжилж хошигносныг шог зохиол гэнэ. Хошин зохиол нь шүүмжлэлт өнгө аясгүй байж болно.

5. Үндэслэлтэй тайлбар хийснээ дараах шалгуураар үнэлээрэй.

	Тийм	Үгүй	Нэмэлт асуулт	Сайжруулах шаардлагатай. Яаж гэдгээ хэлэлцээрэй
Онолын мэдээллийн утгыг ойлгож уншсан уу?			Шог зохиол нь хошин зохиолоос юугаараа ялгаатай вэ?	
Онолын мэдээллээс үндэслэлээ авахдаа “шүүмжилж хошигносон” гэсэн түлхүүр үгийг хэрэглэсэн үү?			“Шүүмжилж хошигносон” гэсэн түлхүүр үг нь шог зохиол мөн гэдгийг тодорхойлох уу?	
Зохиолыг шог болгосон гэж үзэж байгаа үг, өгүүлбэр чинь инээдэмт өнгө аясаар шүүмжилж хошигносон байна уу?			Зохиолоос “Энэ бол шог юм аа” гэж сонгосон үг өгүүлбэр чинь онолын мэдээллийг бататгаж байна уу?	



**СОНСОХ-ЯРИХ**

**Уншсан зохиолын хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн хэлэлцье.**


1. Уншсан хоёр туулиас сонгоорой.
2. Эх зохиолыг бүрэн эхээр нь уншаад хэлэлцэхэд бэлдээрэй.
3. “Эцэг Горио” зохиолд 19 дүгээр зууны үеийн Францын нийгмийн амьдрал, тэр дундаа хөрөнгө мөнгө, эрх мэдлийг гол зорилгоо болгосон дээдсийн хүрээлэнгийнхнийг зохиолч О.Бальзак шүүмжилж бичсэн байдаг. Хэлэлцэх сэдэв: “Хүн чанар ба мөнгө, эрх мэдэл”

**Дэмжлэг болох асуулт:**



- Хүн юунаас болж энэрэнгүй, нийгэмлэгэнгүй байх мөн чанараа алддаг вэ?
- Эцэг Горио охигоо хүн чанаргүй болгосон нь өөрийнх нь буруу юу, ийчхийн үеийн нийгмийн буруу юу?
- Өнөө цагийн хүн чанарыг эг хөрөнгө, мөнгөнхий их хэрэгцээ нөлөөлж байгаа юу?

**4. Хэлэлцэхдээ:**



Бусдын үзэл бодлыг хүндэтгэн, анхааралтай, хүлээцтэй, идэвхтэй сонсоорой.

**5. Хэлэлцэх чадвараа дараах шалгуураар дүгнээрэй.**

	Маш сайн	Хангалттай	Дахин сайжруулах шаардлагатай гэж бодож байна.
Хэлэлцсэн асуудлын хүрээнд үзэл бодлоо илэрхийлсэн үү?			
Үзэл бодлоо баримт, жишээгээр баталж ярьсан уу?			
Бусдын үзэл бодлыг хүндэтгэн сонссон уу?			
Эдүгээ энэ цаг үед бусдыг мэдэрч ойлгож, хүндэтгэж сурахын тулд юу хийх ёстой талаар хэлэлцэн шийдвэр гаргасан уу?			



**БИЧИХ ЧАДВАР**

**Зохиолын утга, бүтцийн онцлогийг шинжилж, тайлан тайлбарлаж бичихдээ холбогдох нэр томъёог хэрэглэе.**

1. Уншсан зохиолуудаас аль нэгийг сонгоно уу.
2. Уншсан зохиолынхоо утга санааны тухай эргэцүүлж, бичихэд бэлдэнэ үү.



- Өөрийн үзэл бодлоор тайлбарлана.
- Сэдэв, утга санаа, хүүрнэл, дүр, бүтэц, зохиогчийн үзэл бодол гэсэн онолын нэр томъёог хэрэглэнэ.

3. Уншсан зохиолынхоо бүтэц буюу эхлэл, гол, төгсгөл хэсгийн утгыг хураан бичнэ үү.
4. Үйл явдлын дарааллыг хэрхэн байрлуулсныг судалж тайлбарлаарай.
5. Ноороглож бичээд бусдадаа уншуулж, зөвлөж ярилцаарай.
6. Ноороггосноо сийрүүлэн бичиж засварлаарай.
7. Үсгийн дүрмийн болон найруулгын алдааг сайн хянаарай.

Найруулгын алдааг засахдаа дараах шалгуурыг хэрэглэнэ үү.

	Тийм	Үгүй	Сайжруулах саналтай байна
Уншихад ойлгомжтой байна уу?			
Зохиолын сэдэв, утгад өөрийн үзэл бодлоор хандсан уу?			
Уран зохиолын онолын нэр томъёо хэрэглэсэн үү? Яаж хэрэглэсэн бэ?			
Үг нэммээр байна уу? Ямар үг нэмэх вэ?			
Үг хасмаар байна уу? Ямар үг хасах вэ?			
Үгийн байрлалыг солимоор байна уу?			

ХЭРХЭН СУРАЛЦСАНАА ҮНЭЛЬЕ.

*Мэдлэгээ үнэлье.*

1. Дэлхийн сонгодог ямар зохиолыг мэддэг болсон бэ?
2. Зохиолууд юугаараа ялгаатай вэ?
  - Зохиолчийн үзэл бодол уу?
  - Дүрээ бүтээсэн байдлаараа юу?
  - Уншигчдыг татах үг хэллэг, дүрслэлээрээ юү?
  - Үйл явдлыг өрнүүлсэн орчин, нөхцөл байдлаараа юу?
3. Зохиолч Бальзакийн “Эцэг Горио” зохиол нь ямар төрөл зүйлд хамаарах вэ?
  - Өгүүллэг
  - Роман
  - Тууж
  - Туульсын найраглал
4. Амель гэж ямар зохиолын дүр вэ?
  - Эцэг Горио
  - Сүүлчийн хичээл
  - Махабхарата
  - Сүүлчийн даалгавар
5. Хамелеон Очумелов “Энэ генерал Жигаловын нохой бололтой” гэхэд ямар үйлдэл хийсэн бэ?
  - “Жигаловын нохой юм уу?” гэж хэлсэн.
  - Пальтогоо тайлсан
  - “Мөдхөн бороо орох гэж байгаа биз ээ” гэсэн
6. Очумеловын ийм үйлдэл хийсэн нь ямар зан чанартай холбоотой вэ?
  - Хэнэггүй
  - Бялдууч
  - Зусарч

*Чадвар, хандлагаа үнэлье.*

1. Зохиолын утга, дүрийн зан чанарыг мэдэрч уншиж сурсан уу?
2. Хүүрнэл зохиолыг хэрхэн, аль талаас нь шинжилж унших арга барилтай болсон бэ?
3. Орчин, нөхцөл байдлыг мэдэрч уншдаг болсон уу?
4. Уран дүрслэлийг зохиолоос таньж чаддаг болсон уу?
5. Зохиолын дүрүүдээс юу суралцав? Тоочин бичнэ үү.
  - а. ....
  - б. ....
  - в. ....
6. Унших чадварын ерөнхий шаардлагыг судалж, өөрийгөө үнэлээрэй.

Төсөөлөн, таамаглан унших

Ойлгож унших, өөрийн үзэл бодлоор хандаж унших

Унших чадвар

Зохиолыг дүр, орчин, нөхцөл, хэлний хэрэглээ, сэдэв, утгын талаас задлан шинжлэн унших

Гүйлгэн унших

7. Унших чадвараа хэрхэн сайжруулах вэ? Саналаа бичээрэй.
  - а. ....
  - б. ....
  - г. ....
  - д. ....ГЭХ МЭТ

# 4

## ДЭЛХИЙН СОНГОДОГ ЖҮЖИГ

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛГИЙН ЗОРИЛГО:

- Дэлхийн сонгодог жүжгийн зохиолыг уншиж, сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлж сурна.
- Жүжгийн зохиолыг уншиж, задлан шинжлэх чадвартай болно.
- Зохиолоос үг хэллэг, уран дүрслэл ашиглан ярьж сурна.
- Зохиолчийн санаа, дүрүүдийн зан чанарын талаар хэлэлцэж, үзэл бодлоо илэрхийлж сурна.







гэж боддог байв. Гэвч түүнийг өргөмөл гэлцдэг хов нэг л өдөр чихэнд нь хүрэлгүй яахав. Эдип хавь орчиндоо гайхагдсан Дельфийн мэргэч дээр очиж хэний хүү болохоо асуужээ. Дельфийн мэргэч “Чи хэний ч хүү байлаа гэсэн төрсөн эцгээ алж, төрсөн эхтэйгээ гэрлэх тавилантай юм байна” хэмээжээ. Эдип золтой л ухаан алдчихсангүй. Тэгээд Коринф руу буцаж очихгүй, харсан зүг рүүгээ тэнүүчилье гэж шийдэв.

Олон замын бэлчирт тэр сүйх тэргэнд тухалсан цөөвтөр бараа бологсод бүхий ихэмсэг өвгөнтэй таарчээ. Эдип зам тавьж өгөөгүй тул өвгөн түүнийг бэрээдээд авч. Хариуд нь Эдип барьж явсан таягаараа цохитол өвгөн үхэдхийн унажээ. Бараа бологсод нь Эдип рүү дайрч бага зэрэг зодоон болсны эцэст нэг нь амь зулбан бусад зарц нар нам цохиулсан байна. Хээрийн замд иймэрхүү явдал тохиолдох нь элбэг тул Эдип ч цааш замаа хөөжээ.

Тэр явсаар Фив хотод ирэв. Уг хотод аюул нүүрлээд байлаа. Хотын дэргэдэх уулан дээр арслангийн биетэй эмэгчин Сфинкс үүрлэж, замаар өнгөрсөн хүн бүхнээр оньсого таалгаад чадахгүй бол тасчин иддэг болжээ. Хаан Лайй мэргэн хүнээс тусламж гуйхаар яваад замдаа үл таних хүний гарт алагдсан гэнэ.

Сфинкс Эдипээр “Өглөө дөрвөн хөлтэй, өдөр хоёр хөлтэй, орой гурван хөлтэй. Тэр юу вэ?” гэсэн оньсого таалгах бөгөөд Эдип: “Энэ бол хүн. Нялхдаа мөлхдөг, дараа нь хоёр хөлөөрөө алхдаг, хөгшрөхөөрөө таяг тулдаг” гэж хариулна. Дийлдсэн Сфинкс хадны оройгоос хавцал руу үсрэн унаж үхсэнээр, Фив хот энх амгалан болжээ. Ард олон баяр хөөрт умбаж, цэцэн Эдипийг шинэ хаанд өргөмжлөн, Лаййн бэлбэсэн гэргий Иокастаг түүнд хатан болгон өгч, Иокастагийн дүү Креонт түшмэл нь болов.

Олон жил өнгөрсөн хойно, Фивд бурхны цээрлэл ирж, аймшигт өвчин тахал дэгдэн, мал амьтан нь хиарч, тариа нь ганд цохиулжээ. Ард олон Эдипт хандан: “Чи мэргэн ухаантай сан биш үү? Нэгэн цагт биднийг аварсан шигээ одоо аварч аль” хэмээв.

Софоклын эмгэнэлт жүжгийн үйл явдал ард олон ийн байгаагаар эхэлдэг бөгөөд Эдип хаан цугласан олны өмнө гарч ирнэ. “Би Креонтыг Дельфийн зөнч мэргэнээс зөвлөгөө авахуулахаар илгээсэн” гэнэ. Зөнч мэргэн “Энэ бол хаан Лаййг алсны төлөөх бурхны гэсгээл, алуурчныг олоод цээрлүүл” гэж хэлсэн аж. “Ингэхэд яагаад өнөөг хүртэл хааныг алсан хүнийг хайгаагүй байдаг билээ?” гэвэл хүмүүс: “Тэр үед цөм Сфинксийн тухайд л шаналж байсан юм” хэмээжээ. “За тэгвэл одоо энэ хэргийг би биечлэн шийдэх болно” гэж Эдип хаан мэдэгдлээ.

Ингээд Лаййг алсан хүнийг олоод алив бүхнээс тусгаарлаж, холын хязгаарт цөлөн, бурхдын хараалд идүүлэх тухай хааны зарлиг гарчээ. Чухамдаа өөрийнхөө эсрэг ийн зарлигдаж буйгаа тэр яахин мэдэх билээ?

Фивд сохор Тиресий гэгч үзмэрч аж төрдөг байжээ. Түүнээс алуурчны тухай асуухад “Надаас үүнийг л бүү асуу. Тэглээ гээд сайн юм болохгүй” гэв. Эдип үүнд байж ядталаа уурлаж “Тэгвэл чи өөрөө энэ аллагад оролцсон байх нь ээ?” гэвэл Тиресий дүрсхийн “Үгүй шүү, тиймдээ тулах юм бол, алуурчин нь чи, өөрийгөө л цаазал” гэжээ. “Ингэхэд арай Креонт хаан ширээнд санаархаад чамаар ингэж хэлүүлж байгаа юм биш биз?” - “Би Креонтод ч чамд ч үйлчилдэггүй, ариун бурханд л зүтгэдэг. Би сохор, чи хараатай. Гэхдээ л чи ямархан нүгэл дунд хутгалдсанаа, хэн чиний эцэг болохыг олж харахгүй л явна” - “Энэ чинь юу гэсэн үг вэ?” - “Өөрөө таа л даа, чи далд битүү оньсого таахдаа гарамгай сан”. Ингээд Тиресий яваад өгчээ. Найрал дуучид:



- Хэн алуурчин юм бол оо? Эдип гэж үү? Үгүй дээ, итгэхийн аргагүй юм гэлцэнэ.

Эдип өөрийг нь урвагч хэмээн сэжиглэж буйг сонсоод ихэд бухимдсан Креонт ордонд орж ирнэ. “Чиний хаан ширээ надад ямар хэрэгтэй юм бэ? Хаан бол эрх мэдлийнхээ боол шүү дээ. Харин над шиг хааны шадар туслах байх нь хавьгүй дээр”. Эдип тэр хоёр хатуу хорон үг чулуудалцана. Тэдний их дуугаар маргалдахыг сонсоод Креонтын эгч, Эдипийн хатан Иокаста гарч ирнэ. “Энэ намайг хуурмаг зөнчдийн үгийг ашиглан хөөн зайлуулах гэж байна” хэмээн Эдип хэлнэ. Хариуд нь Иокаста: “Бүү итгэ! Зөн бэлгэ, мэргэ төлөг бүгд худал байдаг юм. Лаийг төрсөн хүүгийнхээ гарт үхнэ гэж зөгнөсөн. Гэвч бидний хүү нялхдаа ууланд араатны идэш болсон юм. Харин Лаийг их замын бэлчирт үл таних тэнэмэл эр алсан” гэж яриу.

“Их замын бэлчирт гэнэ ээ? Хаана, хэзээ? Лаий ямар төрхтэй хүн байсан бэ?” - “Дельфи хүрэх бэлчирт, чамайг манай хотод ирэхээс өмнөхөн. Гадаад төрхөөрөө бол Лаий буурал, цэх нуруутай, ер нь чамтай төстэй байсан шүү” - “Яасан аймаар юм бэ? Надтай яг тийм явдал тохиолдсон шүү дээ! Арай би тэр тэнэмэл нь юм биш байгаа? Гэрч үлдсэн үү?” - “Ганц л гэрч бий. Тэрхүү гэрч болох хөгшин малчны араас элч зарсан” гэх нь тэр. Эдип догдолсондоо байж ядна.

Тэгтэл жүжгийн үйл явдалд эргэлт гарна. Тайзан дээр нэг үл таних эр гарч ирсэн нь хөрш Коринф улсаас ирсэн элч ажээ. Хаан нь нас барсан тул Коринфчууд Эдипийг хаан ширээ залгамжлуулахаар дуудсан хэрэг. Эдип хөмсөг зангидан: “Үнэхээр л зөн мэргэ гэдэг худал ажээ. Намайг төрсөн эцгээ ална гэсэн, хаан аав минь гэтэл өөрийн үхлээр оджээ. Гэхдээ намайг эхтэйгээ гэрлэнэ гэсэн юм байна шүү. Хатан ээжийгээ амьд дээр би Коринф руу буцаж болохгүй нь” гэж өгүүлэв. Коринфын элч:

“Хэрэв үүнээс л болоод явахгүй гэж байгаа бол тайвшир. Чи тэдний төрсөн хүү биш, өргөмөл шүү дээ. Би өөрөө чамайг нялхад чинь хааныдаа аваачиж өгсөн юм. Чамайг надад ууланд тааралдсан малчин эр өгсөн” гэж хэлжээ. “Хөөе, эхнээр! Арай тэр нөгөө Лаийн дэргэд байсан малчин чинь биш байгаа? Шалавлаач? Ингэхэд би хэний хүү болж таарч байна аа?” гэж Эдип дуу алдлаа. Харин Иокаста бүхнийг гадарлажээ. “Мэдэх гэсний хэрэггүй. Чамд л муу юм болно” гэж хэлээд хатан ордон руугаа явав. Найрал дуучид: “Магадгүй Эдип лусын дагины ч юм уу, ууланд нярайлсан бурхны хүү байж болно шүү дээ” гэж дуулалдана.

Гэвч үгүй ажээ. Хөгшин малчныг авчрахад Коринфын элч түүнд: “Чиний надад өгсөн нялх жаал чинь энэ шүү дээ” гэж хэлэв. Тэгэхэд өнөөх нь “Миний нүдэн дээр Лаийг алсан хүн энэ мөн байна” гэж дотроо боджээ. Тэр энэ тухайгаа хэлэхийг хүсээгүй боловч Эдип үнэнийг мэдэхээр зүтгэнэ. “Тэгээд хэний хүүхэд байсан юм бэ?”. “Лаий хааны хүү. Хэрэв энэ бүхэн үнэн бол чиний төрсөн чинь нүгэл байж, бидний чамайг аварсан нь ч нүгэл байж дээ” гэж өвгөн малчин хариуллаа.

Одоо л Эдип бүхнийг ойлгожээ. “Хүн болж төрснөө би харааж байна, нүгэл бүхнээ харааж байна, гэрлэснээ бас харааж байна” гэж Эдип чарлаад ордон руугаа гүйв. Найрал дуучид: “Хүний өндөр хэргэм зэрэг хоосон ажээ. Хорвоо дээр аз жаргалтай хүн алга. Эдип мэргэн, Эдип хүчирхэг хаан байлаа. Одоо тэгтэл хэн болж таарав? Эцгийнхээ алуурчин! Эхийнхээ амраг!” гэх аж.

Ордноос хиа гүйн гарч ирэв. Муу мэдээ. Эдипийн эх, хатан Иокаста өөрийгөө боомилж үхжээ. Байж ядсандаа Эдип хатныхаа алтан тээгийг аваад өөрийн нүгэлт муу үйлийг харахгүйн тулд нүд рүүгээ хатгасан байна. Ордны хаалга дэлгэгдэхэд Эдип цус бялдсан нүүртэй гарч ирнэ. “Би биш, хувь заяа ингэж шийдлээ. Би өөрөө

өөрийгөө яллалаа. Лаийг алсан алуурчныг хөөж цөлсүгэй. Эхийгээ эзэгнэсэн шившигтний нүдийг сохолсугай” гэж тэр хашхирав. Үнэнч Креонт урьдын гомдлоо мартан Эдипийг ордондоо үлдэхийг гуйж, “Дотно хүнийхээ зовлонг дотно хүмүүс нь л харах эрхтэй байдаг” хэмээлээ. Гэвч Эдип түүнээс өөрийг нь цөллөгөд явуулахыг гуйж, хүүхдүүдтэйгээ салах ёс гүйцэтгэлээ. “Би та нарыг харахгүй байна. Гэвч та нарыг юутай их өрөвдөнө вэ?” гэж Эдип цурхиран уйлна.

Эх орон нэгт фиванчууд аа!

Эдип хааныг харцгаа л даа!

Бэрх хэцүү оньсогыг таагч, хүчирхэг хаан

Бид бүгдээрээ л түүнийг атаархан харж байсан биш үү?

Амьдралынх нь төгсгөл ирээгүй байгаа хүнийг, тэгэхээр

Аз жаргалтай хэмээн дүгнэж болохгүй нь байна шүү.

Эх сурвалж: Аюурзана.Г. “Дэлхийн уран зохиолын 85 сод туурвил”.  
УБ., 2003 он. 40-46 дугаар тал



## УНШИХ

### Зохиолын талаарх сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлье.

1. Жүжгийн аль хэсэгт сэтгэл чинь хөдөлсөн бэ? Гайхсан уу? Догдолсон уу? Өрөвдсөн үү?
2. Зохиолын үйл явдал өрнөж байгаа байдал ямар санагдсан бэ?
3. Эдип юуны төлөө санаа зовсон талаар болон түүний шийдвэрийн талаар үзэл бодлоо илэрхийлнэ үү. Үзэл бодлоо илэрхийлэхдээ юунаас үндэслэсэнэ хэлээрэй.
4. Эдипийн дотоод сэтгэлийг чагнаж чадав уу? Дахин уншиж үзээрэй.
5. Хэрвээ та нар Эдипийн дэргэд байсан бол юу мэдрэх байсан бол? Зохиолын төгсгөл дэх Эдипийн харц ямар байсан бол?
6. Эмгэнэлийн тухай мэдээллийг уншаад дүгнэлт хийгээрэй.

Зохиолын эхнээс дуусах хүртэл сайн үйл хийж, (Фив хотынхоо ард олныг зовлон шаналлаас гаргахын тулд, Лаий хааныг алсан гэмт хэрэгтнийг олж гэсгээхийн тулд сэтгэл, зүрхээ зориулсан жинхэнэ ард түмнээ хайрладаг сайн хааны шинжтэй гэж дүрслэгдсэн, мэргэчийн хэлснээр эцгийгээ алж, эхтэйгээ суух хувь заяатай юм байна гэдгийг сонсоод ийм муу үйл хийхгүйн тулд эцэг эх, гэр орноо хүртэл орхиж явсан, ард олныг эмэгчин харгис Сфинксээс өөрийн ухаан билгээрээ аварсан) жинхэнэ хүнд байх нинжин сэтгэл, бусдын төлөө амьдарч чадах агуу их ухаантайгаар дүрслэгдсэн хэдий ч үйлийн үрээр хэний ч эдэлж болшгүй их нүглийг өөртөө үүрч, улмаар эх нутаг, ард олныг нь туйлдуулсан гол буруутан нь өөрөө байж байгаагаар зохиомжлогдсон нь уг эмгэнэлт жүжгийн эмгэнэлт санааг тодруулж байгаа юм.

Өөрөөр хэлбэл Эдип муу үйл хийхийг хүсдээгүй, өөрийн ухаанаараа үйлийн үрээсээ зугатсан ч тэр бүх муу зүйл нь өөртэй нь хамт байж, улмаар тэр бүхнээ өөрөө өөртөө буруу болгон хүлээн авч, өөрийгөө сохолж цээрлүүлж байгаа нь уг дүрийн шинжийг тодруулаад зогсоогүй хариуцлага гэж юу болохыг уншигчдад хүчтэй мэдрүүлж өгсөн гайхамшигт шийдэл болсон зохиол билээ. Хүн өөрөө өөртөө эзэн байна гэдэг бол их хариуцлага юм байна шүү гэдгийг сануулсан уг эмгэнэлт жүжиг зохиолын туршид уншигчийн хайр хүндэтгэлийг хүлээсэн эерэг дүрийн хувь заяагаар өрнөсөөр тайлал, төгсгөл хэсэгтээ үхэл хагацлаар төгсөж, уншигчийг хүртэл харуусч харамсахад хүргэж байгаа нь эмгэнэлээр ариусахуйн нэг сургууль болсон гэлтэй.



**Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн уялдаа холбоог тодорхойлъя.**

1. Зохиолчийн дэвшүүлсэн асуудлыг тунгаан бодож, гол сэдэв, утгыг тодруулаарай.
2. Гол сэдэвтэй холбоотой хам сэдвүүдийг сонгож, жишээгээр батална уу.



3. Эдип ямар ч буруугүй хэрнээ гол буруутан нь болж байгаа үйл явдал гарч байна. Үүгээрээ “Хүн хүсээгүй эрх чөлөөнийхөө төлөө ч гэсэн хариуцлага хүлээдэг юм шүү гэдгийг харуулсан утга санаатай зохиол” гэсэн тайлбартай санал нийлж байна уу? Нийлсэн бол яагаад? Нийлээгүй бол яагаад?

**Зохиолын далд утгыг тайлан тайлбарлая.**

1. Домгийн амьтан Сфинкс энэ жүжигт ямар үүрэгтэй оролцож байна вэ?
2. Таалгаж байгаа оньсого нь хүний тухай сэдэвтэй, хүний настай холбоотой байгааг та нар юу гэж бодож байна?
3. Чухам яагаад Сфинксийг хүнтэй адил сэтгүүлэн, хүний ямар шинж байдлыг тодруулах гэж ийнхүү урнаар зохиов?

**Дүрийн бодгаль ба нийтлэг шинжийг тодорхойлъя. Зохиолын утга санаанд нөлөөлж байгааг дүгнэе.**

1. Эдип хааныг бүтээсэн дүр байдлын талаар задлан шинжлээрэй.


Дүрийн нэр	Эерэг тал	Сөрөг тал	Дотоод бодлыг сонсоод үнэлгээ өгөөрэй.	Хэнтэй юу ярилцав? Ямар хүн гэж дүгнэмээр байна?	Зан чанарын хувьд давтагдашгүй, өөр дүрд илрээгүй ямар шинж чанар байна?	Бусад дүртэй ижил нийтлэг ямар онцлог илэрч байна?
Залуу Эдип						
Эдип хаан						

- Эдипийн хувь заяаны талаарх та нарын төсөөлөл?
- Яагаад Эдип өөрийнхөө амийг хорлосонгүй вэ? Нүдээ сохолсны учир?
- Залуу Эдип эрх чөлөөтэй байсан уу? Эсвэл Эдип хаан эрх чөлөөтэй байсан уу?
- Эрх чөлөө гэдэг нь хариуцлагатай байхын нэр мөн үү?
- Энэ жүжиг одоо болтол алдартай байгаагийн шалтгаан нь чухам ямар асуудлыг хөндсөнд оршиж байна вэ?

2. Эдипийн дүр эмгэнэлтэй юү? Яагаад эмгэнэлт дүр вэ? 64 дүгээр хуудсан дахь онолын тодорхойлолтыг уншаад, мэтгэлцээрэй.

**Зохиолын гадаад орчныг тодруулж, дүрийн зан төрхөд хэрхэн нөлөөлж байгааг дүгнэе.**


1. Цэгийн оронд үргэлжлүүлэн ямар үйл явдал болсныг нөхөж бичээрэй.



2. Дараа нь зохиолч гол дүр Эдипийн хувь заяаг хэрхэн шийдэх гээд, ямар зорилгоор үйл явдлыг хаана өрнүүлснийг зураглаад, зохиолчийн санааг тодруулаарай.

**Зохиолын дотоод орчныг тодруулъя.**

1. Дүрүүд хоорондоо юунаас, хэрхэн зөрчилдөж байгааг харилцан ярилцаарай.



2. Сүүлийн дөрвөн цогцолбор дахь үйл явдлыг дахин уншаад, дүрүүдийн хоорондох харилцааны сэтгэл зүйн уур амьсгалыг тодруулаарай.



### Зохиолдахь шүлгийн бүтэц, хэлбэрийг шинжилье.

1. Эх зохиолыг англи эхээр нь уншаад хэрхэн шүлэглэж орчуулсныг судлан шинжлээрэй.

Зохиолын эхэнд тахилчны хэлсэн үг:

Шуурганд нэрвэгдсэн хот маань яагаад ч  
 Шуугих цусан давлагаан дундаас  
 Тэргүүнээ өргөж чадахгүй нь ээ.  
 Мөнх үхэшгүй дээдэстэй чамайг  
 Мөр зэрэгцүүлж тавихгүй ч гэсэн  
 Тэнгэрийн эзэдтэй чамайгаа л ярина гэж  
 Тэнхээ мэдэн бид бүгд итгэнэ.  
 Эрийн дээд Эдип хаан минь  
 Энэрээч гэж бид чамайг гуйж байна.

Эдипийн хэлсэн үг:

Өөр өөрийнхөө л төлөө та нарын ер зүрх шаналж байхад  
 Хүн ард, хот, өөрийнхөө төлөө хөөрхий би чинь тарчлан байна.

Эдип, Лаий хаанаас төрснөө, хотынхондоо нүгэл хийснээ мэдэх үед найрал дуучид ийнхүү дуулжээ.

Бадаг 1

Хүмүүс, хүмүүс, ертөнцөд амьдрагсад!  
 Амь зууна гэдэг зэрэглээ биш үү!  
 Аз жаргалтай хэн золгосон бэ?  
 Заяа надад олджээ гэж  
 Бодож амжив уу, үгүй юу  
 Алга болдог юм биш үү, тэр?  
 Эдип хааны хувь тавилан надад их юм сургалаа.  
 “Хорвоод азтай хүн” гэж ер нь байхгүй байна шүү.

Бадаг 2

Үйлийн үрийн хүндийг үүрч аваад  
 Зовлон гаслангийн урьханд баригдан  
 Ингэж тамлагдах хүн бий болов уу?  
 Үүнээс азгүй хүн гэж байх уу?  
 Алдрын дээдэд хүрсэн Эдипийн  
 Амьдрал ийнхүү сүйрчээ.

Зохиолын төгсгөл хэсэгт Эдипийн нүдээ сохолсныг хараад, гэрийн хүн ийнхүү хэлэв:

Нүдээ ганц нэг хатгаагүй  
 Хэчнээн төчнөөн хатгахад нь  
 Цус дуслаар гараагүй  
 Хар хүрэн цусан гол  
 Газраар нэг урсах шиг болсон.  
 Өнгөрсөн цагий нь одоо санахад  
 Атаархам жаргалтай байсан биш үү?

## ХЭРХЭН СУРАЛЦСАНАА ҮНЭЛЬЕ.

### Мэдлэгээ үнэлье.

1. Tragedy гэдэг нь юу гэсэн утгатай үг вэ?
2. Эмгэнэлт жүжгийн гол баатрын шинжийг илэрхийлсэн онолын зөв тодорхойлолтыг сонгоно уу.
  - Эр зоригтой, энэрэнгүй, өөрийнхөө мөн чанарыг олж харсан хүн
  - Хүний хамгийн төгс сайхан шинжийг өөртөө шингээсэн, зохиолын төгсгөлд бусдын сайн сайхны төлөө тэмцсээр байгаад амь эрсэддэг хүн
  - Бусдын төлөө тэмцдэг баатарлаг хүн
  - Уншигчдад хайр харууслыг үлдээж чаддаг, хүний сайхан чанаруудыг өөртөө шингээсэн хүн
3. Эдип бүхнийг ойлгосны дараа найрал дуучид юу хэлсэн бэ?

### Чадвар, хандлагаа үнэлье.

1. Эх зохиолоо бүрнээр нь уншсан уу?
2. Гол баатрыг эмгэнэлт дүр болохыг батлаарай. Жишээг ашиглаарай.

...Хийсэн хэргийн муу муухайг  
Төлөөнөөс нь эдлэх зовлонг  
Энэ нүд үзэх ёсгүй.  
Нутгаа зовлонд учруулах гай гамшгийг авчирсан  
Гэмтэн, буруутан хэн ч байлаа  
Гэртээ битгий ойртуул  
Даруй хөөж явуул гэж би эс зарлиг болгол уу?  
Тэгээд өөрөө гай тарьчаад  
Олныхоо нүүрийг би яаж харах билээ.  
Хэрэв болдогсон бол би  
Чихээ ч бас хатгаж цоолоод  
Сохор дүлий болчхоод тамаа эдэлж явах сан.  
Даанч чихээ хатгавал тэр дороо үхээд  
Тарчлах зовлонг эдлэхгүй болно.  
Хэнээс ч төрсөн, юу хийснээ ч  
Ухааралгүй өнгөрсөн бол  
Дээд жаргал байжээ.  
Гаднаа би хэчнээн өнгөтэй, нигүүлсэнгүй байлаа.  
Тэгтэл дотроо хэчнээн буртаг, бузрыг агуулж байв даа...

3. Бичих чадварын ерөнхий шаардлагыг судалж, өөрийгөө үнэлээрэй.

Санаагаа төлөвлөх,  
эхлэл, гол, төгсгөл хэсэгт  
санаагаа оновчтой  
байрлуулах

Цогцолбороор санаагаа  
цэгцтэй илэрхийлэх,  
цогцолборуудын хооронд  
утгын уялдаа холбоотой  
бичих

Бичих чадвар

Бичих зорилгоо  
тодорхойлох, гол  
санааг илэрхийлэх

Үг, үсэг,  
найруулгын  
алдаагүй бичих

4. Бичих чадвараа хэрхэн сайжруулах вэ? Саналаа бичээрэй.
  - а. ....
  - б. ....гэх мэт



## Ном зүй

1. Аюурзана.Г, “Утга зохиолын тухай яриа”. УБ., 2001 он.
2. Аюурзана.Г, “Дэлхийн уран зохиолын 85 сод туурвил”. УБ., 2003 он.
3. Бүрэн дунд боловсролын Монгол хэл, бичиг, уран зохиолын сургалтын цөм хөтөлбөр, УБ., 2016 он
- 4 “Бүх цаг үеэс сонгосон дэлхийн яруу найргийн дээж “Гурван зуун шүлэгт”. Мэнд-Ооёо.Г, УБ., 2013 он.
5. Гаадамба.Ш. “Утга зохиолын онолын товч түүх”, УБ., 1982 он
6. Галбаатар.Д. “Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл”. Ред. Дулам.С, УБ., 2012 он
7. Гадаадын уран зохиол. Нэгдүгээр дэвтэр. Цэндсүрэн.Ч, нар. УБ., 1979 он
8. Дулам.С, Хасбаатар.Ц, Уран зохиолын онолын үүд. УБ., 1980 он
9. Дулам.С, Дорно дахины уран зохиолын үүд. УБ., 2004 он
10. Литературный энциклопедический словарь. М., г 1987
11. Классическая поэзия Востока. М., г 1976
12. Конрад.Н.И. “Японская литература” Л., г 1927
13. Оноре Дё Бальзак. Эцэг Горио. “Дэлхийн сонгодог утга зохиолын чуулган” тавин боть. Ред. Аким.Г, УБ., 2009 он
14. Уоллек Р. Уоррен О. Уран зохиолын онол. (орчуулгын) УБ., 1999 он
15. “Уран зохиол-8” Сурах бичиг. Жачин.Ч, Чүлтэмсүрэн.Р, Одсүрэн.П, УБ., 2007 он
16. “Унших-1”. УБ., 2002 он, “Унших-2”. УБ., 2003 он
17. “Утга зохиол шинжлэл. МУБИС. Утга зохиолын тэнхим. Ред. Оюунбадрах. Д, УБ., 2006 он
18. Софокл. “Эдип хаан”. Орч. Оюун.Э, УБ., 1979 он.
19. Сумьяа.Д. Цагаан дара эх” УБ., 2016 он
20. Францын шилдэг өгүүллэгүүд УБ., 2009 он Эмхэтгэсэн. Алтангүл.Б.
21. Хөвсгөл.С, Энхбаяр.С, “Өрнө дахины уран зохиолын дээж бичиг” 1-р дэвтэр. УБ., 2010 он.
22. Хөвсгөл.С. “Дорно дахины уран зохиолын түүхэн найрууллууд”. УБ., 2014 он
23. Хөвсгөл.С. “Өрнө дахины уран зохиолын түүхэн найрууллууд”. УБ., 2013 он
24. Хүүхдийн шилмэл зохиолын эрдэнэсийн сан 108. “Махабхарата (Куругийн хан хөвгүүдийн агуу их тулалдаан)”. “Хөх дэвтэр” хэвлэлийн газар. “Соёмбо” хэвлэлийн үйлдвэр. Орч. Баясгалан.Б, УБ., 2010 он.
25. Цоодол.Д, Түүвэр зохиол. 4 дүгээр боть. УБ., 2015 он
26. Цэвэл.Я. “Монгол хэлний товч тайлбар толь”. УБ., 1966 он
27. Шархүү.А. Дагвадорж.Ч нар. “Дэлхийн уран зохиолын бага нэвтэрхий толь”. УБ., 2003 он
28. Шри Галидас. Үүлэн зардас. Орч. Ринчен.Б, УБ., 1964 он.
29. Энхбаяр.С. “Утга зохиолын онол”. УБ., 2005 он
30. Японы яруу найраг. УБ., 1975 он

## Цахим материал

1. <https://mn.wikipedia.org/wiki/>
2. <http://www.literature.mn>
3. <http://www.digitalink.ink/wp-content/uploads/Khayyam.jpg>
4. [http://tabitabi.ru/\\_engine/picture/1/853.png](http://tabitabi.ru/_engine/picture/1/853.png)
5. <http://bawalalji.org/web/gallery/krishnalila.php>
6. <http://www.pechora-cbs.ru/content/news/642/1005132417.jpg>